

Бүрчээ

АНАГААХ УХААН

ЭРҮҮЛИЙГ ХАМГАЛАХЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

●
СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ

●
МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨГӨӨ, ЛЕКЦ, ТОЙМ

●
ТУРШЛАГА СОЛИЛЦЬЁ

●
ХОВОР ТОХИОЛДОЛ

●
ЭРДЭМТДИЙН ДУГНЭЛТ ЗӨВЛӨМЖ

●
ГАДААД ОРНУУДАД

1

1987

БНМАУ
Эрүүлийг Хамгаалах Яам
Эрдэм шинжилгээ-практикийн
улирал тутмын сэтгүүл

Орон бүхний пролетари
нар нэгдэгтүн!

АНАГААХ УХААН

18 дахь жилдээ № 1(61) 1987 он

АГУУЛГА

Эрүүлийг хамгаалах 1987 онд 3

«ЭРҮҮЛИЙГ ХАМГААЛАХЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Ж. Раднаабазар — Нийт 5хүн амyg үе шаттайгаар диспансерчлах асуудалд	6
Ц. Гомбо — Архидан согтуурахтай тэмцэхэд эмнэлгийн байгууллагаас зохиох ажил	10

СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ

Ш. Чадраабал, П. Янсан — Малчдын өвчлөл, хооллолтын зарим асуудал	13
Ж. Цогнэмэх, Д. Сэлэнгэ, Я. Шархүү — Анабазиныг клиникт хэрэглэсэн дүн	17
С. Ядмаа — Эмэгтэйчүүдийн архаг үрэвсэл өвчнийг оношлох, түүний байгалийн цогцолбор эмчилгээний үр дүн	19
С. Раднаа базар — Холын зайд гүйгчдэд хийсэн эмнэлэг хяналтын зарим ажиглалт	22

МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨГӨӨ, ЛЕКЦ, ТОЙМ

Т. Дэлгэр Н. Жанцан, Б. Байгаль, — Вируст гепатит	26
П. Нямдаваа — Дархалын олдмол дутлын хамшинж	37
— Цусны даралт ихсэх өвчний орчин үеийн эмчилгээний зарим асуудалд	46
Д. Баасанжав — Тархины судасны өвчнүүдийн эхний хэлбэрүүд, тархины цусны эргэлтийн түр цочмог юрчлэлт	52
Д. Цэгээнжав, Ц. Бундан — Зүрхний титмийн цус тасалдах өвчнийг оношлоход титмийнangiографийн ач холбогдол	54
Ө. Жүгдэр Б. Шижирбаатар, Д. Ичинхорлоо, — Кардиотокографийг эх барихын практикт хэрэглэх нь	58
Ю. З. Розенблум, В. С. Лапушкин — БНМАУ-д суралцаж байгаа зөвлөлтийн сурагчдын нүдний хараа муудахаас урьдчилан сэргийлэх асуудалд	62

ТУРШЛАГА СОЛИЛЦЬЁ

Э. Довдон, Р. Нямаа — Филатов-Кальфийн эластотонометрийн хэмжилтийн таблицыг хэрэглэсэн туршлага	66
--	----

ХОВОР ТОХИОЛДОЛ

Н. Нямаа — Үхрийн арьсны гуур	72
---	----

ЭРДЭМТДИЙН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

П. Батхүү — Хотын хүүхдэд үзүүлэх амбулатори-поликлиникоор үзүүлэх тусламжийн хэмжээ, хэрэгцээ	74
Ш. Дуламсүрэн — Цусны даралт ихсэх өвчний явцад цаг агаарын зарим хүчин зүйлийн көлөө	7

МЭДЭЭ

МЕДИЦИНА

Выход с 1970 г № 1 (61) 1987 г

СОДЕРЖАНИЕ

Здравоохранение в 1987 году	3
---------------------------------------	---

ОРГАНИЗАЦИЯ ЗДРАВООХРАНЕНИЯ

Ж. Раднабазар — К вопросу организации этапной диспансеризации всего населения	6
Ц. Гомбо — Работа лечебно-профилактических учреждений по борьбе с пьянством	10

КЛИНИКО-ЭКСПЕРИМЕНТАЛЬНЫЕ ИССЛЕДОВАНИЯ

Ш. Чадрабал, П. Янсан — Некоторые вопросы заболеваемости и питательного режима животноводов	13
Ж. Цогнэмэх, Д. Сэлэнгэ, Я. Шарху — Клиническое испытание таблеток анабазина	17
С. Ядма — Результаты диагностики и лечения хронических воспалительных заболеваний женской половой сферы	19
С. Раднабазар — Некоторые наблюдения медицинского контроля бегунов длинных дистанций	22

ОБЗОРЫ, ЛЕКЦИИ, КОНСУЛЬТАЦИИ

Т. Дэлгэр Н. Жанцан, Б. Байгаль, — Вирусный гепатит	29
П. Нямдава — Синдром приобретенного иммунодефицита	37
— Современная терапия артериальной гипертензии	46
Д. Басанжав — Начальные формы патологии сосудов и острое нарушение мозгового кровообращения	52
Д. Цэгэнжав, Ц. Бундан — Коронарная ангиография в диагностике ишемической болезни сердца	54
Ө. Жүгдэр Б. Шижирбатор, Д. Ичинхорло, — Применение кардиотокографии в акушерской практике	58
Ю. З. Розенблум, В. С. Лапушкин — Профилактика нарушений зрения у советских школьников, учащихся в МНР	62

ОБМЕН ОПЫТОМ

Э. Довдон — Опыт применения калибровочных таблиц для эластотонометра Филатова-Кальфа	66
--	----

РЕДКИЙ СЛУЧАЙ

Н. Няма — Гиподерма	72
-------------------------------	----

ДИССЕРТАЦИОННЫЕ ВЫВОДЫ И РЕКОМЕНДАЦИИ УЧЁНЫХ

П. Батху — Объем и потребность в амбулаторно-поликлинической помощи городскому детскому населению	74
ИШ. Дуламсурэн — Влияние некоторых метеорологических факторов на течение гипертонической болезни в г. Улан-Батора	76

ХРОНИКА

ЭРҮҮЛИЙГ ХАМГААЛАХ 1987 ОНД

БНМАУ-ын Ардын Их Хурлын 11 дэх удаагийн II чуулган „БНМАУ-ын эдийн засаг, нийгмийг 1986—1990 онд болон 1987 онд хөгжүүлэх улсын төлөвлөгөө, улсын нэгдсэн төсвийг хуульчлан баталж намын XIX их хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх талаар нийт байгууллага, хөдөлмөрчид, тухайлбал эрүүлийг хамгаалах салбарын өмнө тулгарч байгаа зорилтыг тодорхойлов.

МАХН-ын Төв Хорооны II бүгд хурал, АИХ-ын ээлжит чуулганаас ард түмний аж амьдралын нөхцөлийг сайжруулах, хүн амын бодит орлогыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн олон тооны чухал арга хэмжээ авахаар заалаа. Эрүүлийг хамгаалах салбарыг хөгжүүлэх, түүний материаллаг баазыг бэхжүүлэх, боловсон хүчний хангамжийг сайжруулах болно.

Тус салбарт VIII таван жилд хагас миллиард хөрөнгө оруулалт оруулахаар төлөвлөжээ. Таван жилд эмнэлгийн 4,1 мянган орны багтаамжтай, ээлжинд 7 мянган хүн үзэх эмнэлэг үйлчилгээний барилга байгууламж барьж ашиглалтанд оруулна. Эмнэлгийн дээд, тусгай дунд боловсролтой 8,2 мянган мэргэжилтэн бэлтгэнэ. Энэ арга хэмжээ нь хүн амд үзүүлэх эмнэлгийн тусламжийн хүрэлцээ чанарыг дээшлүүлэх боломжийг бүрэлдүүлж байна.

1987 онд Эрүүлийг хамгаалах, биеийн тамирын арга хэмжээг санхүүжүүлэхэд 524,3 сая төгрөг зарцуулна. Улаанбаатар хотод эх нялхсэн нэгдсэн төвийн иж бүрэн барилга, Ажилчин, Сүхбаатарын районд тус бүр ээлжинд 500 хүүхэд үзэх поликлиник, Дарханд төрөх газар, Улаангом, Ховдод халдвартын больниц зэрэг арав гаруй барилгыг ашиглалтанд оруулснаар салбарын үндсэн фонд 69 сая төгрөгөөр больницын орны тоог 5,5 хувиар нэмэгдүүлнэ. Сум дундын нэгдсэн эмнэлэг, сумын эмнэлгийг шинэ бүтэц, зохион байгуулалтаар ажиллуулж эхлэх ба 10 гаруй сумдад Ариун цэвэр халдварт судлалын салбар станц, групп байгуулж ажиллагаанд өруулна.

Дээд, дунд мэргэжлийн 1800 гаруй мэргэжилтэн бэлтгэн гаргах бөгөөд тэдгээрийн ихэнх нь хөдөөгийн эмнэлэг болон хүүхдийн эмнэлгийн байгууллагад ажиллах болно. Эрүүлийг хамгаалах салбарт шинжлэх ухаан техникийн ололт түргэн явцтай нэвтрэх юм. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангамж сайжирна. Компьютерийн томограф, электрон микроскоп, электрон тооцоолон бодох техник, төрөл бүрийн эхограф, гаммакамер зэрэг орчин үеийн өндөр хүчин чадалтай аппарат техникийг ашиглаж эхлэх бөгөөд эдгээрийн үр дунд өвчтөний онош нөлөө үзүүлэх юм.

Эрүүлийг хамгаалахын урьдчилан сэргийлэх ажлын хүрээ өргөжиж хүн амыг диспансерчлах ажил улам гүнзгий нэвтэрнэ. 1987 онд бараг 900 шахам эмч, эмнэлгийн дунд мэргэжилтний мэргэжил дээшлүүлнэ. Эм, эмийн зүйл, төрөл бүрийн тарилга үйлдвэрлэх хэмжээ 24 сая төгрөгт хүрч өсөх ба хөдөлмөрчдийн эмийн үйлчилгээ өргөжнө. Эмийн гүйлгээ 130 сая төгрөгт хүрнэ. 20 гаруй төрлийн эмийн шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэж, үйлчилгээнд нэвтрүүлэх бөгөөд эмийн үйлдвэрийн хэд хэдэн дамжлагад механикжуулалт, автоматжуулалтын шугам тавьж ашиглалтанд оруулна. Эмнэлэг үйлчилгээний ажлын чанар, шинжилгээний түвшинг дээшлүүлэх, хүндрэлийг багасгах, ажлыг хөнгөвчлөхэд чиглэгдсэн хэд хэдэн тэргүүн туршлагыг 180 байгууллага, тасаг, нэгж, 500 гаруй ажилтанд эзэмшүүлэхээр төлөвлөж байна.

Эд материалын нөөц, зардлыг хэмнэх улсын даалгавартай ажиллах бөгөөд байгууллага бүр бензин шатахуун, ус, уур, эрчим хүч хэмнэх, үйлдвэр, аж ахуйн газрууд тодорхой төрлийн түүхий эд материал

хэмнэх үүрэгтэй ажиллана. 30 шахам нэр төрлийн эмийн ургамал, жимс-гэнэ түүж бэлтгэх бөгөөд заримыг экспортод гаргах болно.

Эрүүлийг хамгаалах Яамнаас батлан гаргасан хүн амыг диспансерчлах аргыг нийт эмнэлгийн ажилтнууд нарийвчлан судалж, эзэмшиж хэрэгжүүлэх болно. Эмнэлгийн үйлчилгээний чухал үндсэн үзүүлэлт болсон хүн амыг диспансерчлах хувь хэмжээг өсгөх, урьдчилан сэргийлэх үзлэгийн тоо хэмжээг нэмэгдүүлэх, чанаржуулах, амбулатори-поликлиникийн үйлчилгээнд улам олон хүнийг хамарч, стационарын тус-ламжийн хүрээ өргөжино. Урьдын адил амбулаториср үнэ төлбөргүй эм олгож эмчлэх хүрээ өргөн байх бөгөөд хүн амын дунд зонхицж байгаа өвчлөлийг бууруулахад гол анхаарлаа чиглүүлэх болно. Нэн ялангуяа бага насын хүүхэд, жирэмсэн эмэгтэйчүүдийн өвчлөл, эндэгдлийг аль болохоор түргэн хугацаанд бууруулах зорилт тулгарч байна. Хүүхдийн хэсгийн тоог 441-д хүргэнэ. Эх хүүхдийн эндэгдлийг тогтмол бага хэмжээнд байлгаж байгаа аймаг, сумдын туршлагыг өргөн судлан сурталчлах шаардлага тавигдаж байна. 1987 оныг эрүүлийг хамгаалах салбарын ажлыг эрчимжүүлэх, намын их хурал дээр шүүмжлэгдсэн дутагдлыг үндсэнд нь арилгах он болговол зохино.

Эрүүлийг хамгаалах салбарт ажлын үр ашиг, чанарыг дээшлүү-лэхэд чиглэгдсэн хөдөлмөр зохион байгуулалт, урамшууллын бригадын хэлбэрийг өргөн нэвтрүүлэх шаардлага тавигдаж байна. Энэ талаар зарим эмнэлэг дээр туршсан дүн ашигтай болох нь харагдлаа. Ийм бригад байгуулах ач холбогдлыг хамт олны дунд өргөн сурталчлах хэ-рэгтэй байна.

Тус салбарт 1986 онд эхэлсэн ажлын эрч хүчийг бууруулахгүй, ажилдаа шүүмжлэлтэй хандаж, ажлын чанарыг дээшлүүлэх явдал чухал байна. Байгууллага бүр, хүн бүр 1987 онд нэг шинэ зүйлийг сэ-дэн, шинэ сэтгэлгээгээр ажиллахыг нам шаардаж байна. Бүх шатны боловсон хүчиний бие даасан ажиллагаа, санаачилгыг дээшлүүлж тэ-дэнд тавих зарчимч шаардлагыг өндөржүүлэх хэрэгтэй байна. Салба-рын боловсон хүчиний мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх системтэй ажил зохион байгуулах, гаргасан шийдвэр, төлөвлөгөө, уралдааны үүргээ биелүүлэхэд тавих хамтын ажлыг эрчимжүүлвэл зохино. Социалист уралдаан зохион байгуулж байгаа арга хэлбэрийг улам боловсронгуй болгох, нэн ялангуяа дүгнэх явдлыг тогтмолжуулах, хүний хүчин зүй-лийн ролийг өндөржүүлэх хэрэгтэй байна.

Салбарын нөөц бололцоог илрүүлэн ашиглах явдал юу юунаас чухал болж байна. Тус салбарт материал, санхүү, боловсон хүчиний их нөөц байна. Боловсон хүчинийг зөв хуваарилан байршуулж дүүрэн ашиглах явдал мэргэжлийн төдийгүй эдийн засгийн чухал асуудал юм. Тус салбарын өмнө тавигдсан зорилтыг хэрэгжүүлэхэд юуны өмнө со-циалист аж төрөх ёсыг хэвшүүлэх нь нэн чухал рольтой билээ. Ий-мээс салбарын нийт албан хаагчид эрүүл ахуйн сурталчилгааг шинэ агуулгаар баяжуулж оновчтой хэлбэр, аргыг сонгон авч явуулах хэ-рэгтэй байна.

Хөдөлмөрчдийн зүгээс эмнэлэг үйлчилгээний талаар гарч байгаа санал гомдолд хalamж анхаарал тавьж, шуурхай барагдуулах арга хэм-жээ авч ажиллах нь чухал байна.

МАХН-ын II бүгд хурлын шийдвэрийн дагуу эмнэлгийн дэргэдэх намын анхан шатны байгууллагын дайчин чадвар, нэн ялангуяа коммунистуудын манлайллыг өндөржүүлэн, намын байгууллагын ажиллагааг эмнэлэг үйлчилгээний гүнд чиглүүлж, эмнэлэг хөдөлмөрчдийн холбоог бэхжүүлэхэд ихээхэн анхаарвал зохино. Амбулатори-поликлиникийн тусламжийг өргөтгэх, урьдчилан сэргийлэх ажлын далайц, өгөөжийг дээшлүүлэхэд намын байгууллага ажлаа чиглүүлэх хэрэгтэй юм. Ам-булатори-поликлиникт хийгдэх үзлэг шинжилгээг иж бүрнээр хийж хө-дөлмөрчдийг олон дахин ирүүлдэг явдлыг эрс багасгах, диспансерийн

хяналтыг оновчтой болгох зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах, суурилагдсан ба олгосон тоног төхөөрөмж, автомашины ашиглалтыг эрс сайжруулж, шаардлагатай бол ээлжийн ажиллагаанд оруулах, сум аймгийн төвд хийгдэж байгаа шинжилгээ фношлогооны түвшинг хотын хэмжээнд ойртуулах, энэ зорилгоор эмч мэргэжилтэнг бэлтгэж тогтворт суурьшилтай ажиллуулвал үр өгөөж нь өндөр байх болно.

Хөдөлмөрчдийн өмнө ажлаа тайлагнаж, ажилдаа үнэлэлт дүгнэлт авч ажиллах шаардлагатай байна. Үйлчилгээний чанарыг сайжруулах асуудлыг юуны өмнө хүний төлөө тавих анхаарал халамж, хүний сэтгэл санаанд бүрэн нийцүүлэхэд чиглүүлж ажлын чанарыг төлөвлөх үнэлэх үзүүлэлтийг байгууллага бүр дээр тогтоож мөрдүүлэх, чанарын асуудлыг эмч ажилтан бүрийн ажлын хэмжүүр болгож тодорхой Үр дүнд хүрсэн байх зорилтыг 1987 онд дэвшүүлэн тавьж байна.

ӨГҮҮЛЭЛ БИЧИГЧДИЙН АНХААРАЛД

Тус сэтгүүлд ирүүлэх материал нь доорх шаардлагыг бүрэн хангасан байх хэрэгтэй. Үнд:

1. Сэтгүүлд ирүүлэх материал нь эрдэм шинжилгээний хүрээлэн албан байгууллагаас хэвлүүлэхийг зөвшөөрсөн албан бичигтэй байна.
2. Өгүүлэл нь 21 мөрөөр машиндсан өнгөн хувь байна.
3. Өгүүллийн хэмжээ нь зураг, ашигласан хэвлэлийн жагсаалт, хүснэгт, резюме (төвчлол)-г оруулаад машинаар цохисон 10 хуудаснаас илүүгүй байна.
4. Өгүүллийн эхнд зохиогчийн овог, нэр, ажиллаж буй албан байгууллагын нэрийг бичсэн байна.
5. Өгүүллийн эцэст зохиогч гарын үсгээ заавал зурна. Хамтын бүтээл бол бүх зохиогч гарын үсгээ зурна. Мөн редакциас зохиогчтой харилцах хаяя, утасны дугаарыг бичнэ.
6. Өгүүлэл нь товч, тодорхой, үгүүсэг, найруулгын алдаагүй, засваргүй байна.
7. Өгүүлэлд орсон нэр томъёог сайтар шалгасан байна.
8. Судалгааны өгүүллийг / судалгааны үндэслэл, арга, Үр дүн, шүүмж ба дүгнэлт гэсэн дэс дарааллаар бичнэ.
9. Өгүүлэлд орсон шинэ үг тоо баримтыг эх материалтай тулгасан, ямар ч зөрөөгүй байх ёстой.
10. Ишлэлт татсан эх зохиолын жагсаалтыг өгүүллийн эцэст ишлэл татсан дарааллын дагуу хийж, дугаарыг өгүүлэл дотор ишлэлийн ар талд хаалтанд бичнэ. Ишлэлт татсан эх зохиолыг өгүүллийн эцэст зохиогч, ном, сэтгүүл, өгүүллийн нэр, хэвлэгдсэн он, дугаар, хаана хэвлэгдсэн, хуудасны дугаар оруулсан машиндсан эхийг авна.
11. Өгүүлэлд зураг, диаграмм оруулбал тэдгээр нь хэвлэлийн шаардлага хангасан, маш тод өнгийн хар тушаар зургийн цаасан дээр зурсан, ард нь зохиогчийн нэр, зургийн дугаар, хаана оруулахыг тодорхой зааж бичсэн байна. Зургийн тайлбарыг өгүүлэл дотор (зургийн нэр, үсэг, муруй шугам зэрэг тэмдгийн тайлбар) бичнэ.
12. Өгүүлэлд орсон томъёог сайтар шалгаж хар өнгийн бэхээр бичнэ. Латин үсгийг цэнхэр бэхээр, грек үсгийг улаан бэхээр бичнэ.
13. Өгүүлэлд орсон хүснэгтийг машиндсан, товч тодорхой нэр, дугаартай хэмжээ нусээр биш, too баримтыг шалгаж, статистикийн аргаар боловсруулсан байх шаардлагатай.
14. Өгүүллийн товчлол (резюме)-г орос хэлээр өгүүллийн нэр, зохиогчийн нэр, товч утга гэсэн дарааллаар бичсэн байна.
15. Ирүүлэх материал нь урьд өмнө хэвлэгдээгүй буюу хэвлүүлэхээр өөр хэвлэлд өгөөгүй байх шаардлагатай.
16. Редакци нь хэвлүүлэхээр ирүүлсэн өгүүллийг товчлох, засварлах, түүнчлэн зохиогч зөвшөөрвэл товч мэдээлэл хэлбэрээр хэвлэх эрхтэй.
17. Дээрх шаардлагыг бүрэн хангаагүй өгүүллийг редакцийд хүлээн авахгүй.
18. Хэвлэгдээгүй материалыг буцаахгүй, өгүүллийг „Улаанбаатар. 48. Эрүүлийг хамгаалах Яам, Эмнэлгийн хэвлэлийн нэгдсэн редакци“ хаягаар ирүүлнэ.

ЭРҮҮЛИЙГ ХАМГААЛАХЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Ж. РАДНААБАЗАР (Эрүүлийг хамгаалах Яам)

НИЙТ ХҮН АМЫГ ҮЕ ШАТТАЙГААР ДИСПАНСЕРЧЛАХ АСУУДАЛД

Нийт хүн амыг шатлан диспансерчлах ажилд шилжих тухай МАХН-ын XIX их хурал эрүүлийг хамгаалахын зарчмын шинэ зорилт дэвшүүллээ.

Нийт хүн амыг диспансерчлах нь хөгжингүй социализмын үеийн эрүүлийг хамгаалахын үндсэн агуулга болон төлөвшиж байна. Одоо ЗХУ-д дунджаар нийт хүн амьн 60 гаруй хувийг жилд нэг удаа диспансерийн үзлэгт оруулж, цаашдаа нийт хүн амыг диспансерчлах ажилд шийдвэртэй ороод байна. Ах дүү социалист орнууд 1995 он хүртэлх хугацаанд нийт хүн амыг диспансерчлах ажлыг дуусгах бодлого баримталж байна.

Бүх нийтийн диспансерчлалын ажлыг явуулах амбулатори-поликлиникийн тусламжийг боловсронгуй болгон урьдчилан сэргийлэх ажлын нэгдлийг давамгайлан хөгжүүлж, эмнэлгийн боловсон хүчин, материалыг баазыг бэхжүүлсний үндсэн дээр хийж байгааг ах дүү социалист орнуудын эрүүлийг хамгаалахын практик баталж байна.

ЗХУ болон ах дүү социалист орнуудад хүн амыг диспансерчлах, ялангуяа нийт хүн амыг эмнэлгийн идэвхтэй хяналтад авах анхны шатны олон хүн амыг хамарсан эмч нарын бүрдмэл үзлэг гэж үзэж байна. Диспансерчлалд поликлиник, дотрын хэсгийн эмч чухал үүрэгтэй. Диспансерын хяналтын нийт хүмүүсийн 60 шахам хувийг насанд хүрэгчдийн дэвсгэр нутгийн поликлиникт, тэдний 44,4—58,5 % нь дотрын хэсгийн эмчид тус тус ногддог аж (1).

В. С. Преображенскаягийн судалгаагаар (1985) диспансерийн хяналтын архаг өвчний 55—70 % нь цусны эргэлтийн систем, хоол боловсруулах эрхтэний ба амьсгалын замын өвчин байжээ. Орчин үед судлаачдын анхаарал татаж байгаа эмзэг асуудлын нэг бол цочмог өвчинөөр өвчлөгсдийг диспансерийн хяналтад авах аргыг өргөтгөх явдал юм. Учир нь төрөл бүрийн шалтгаанаар олон хурц өвчин клиничийн бүдэг явцтай, архагших хандлагатай болж байна. Жишээлбэл: Уушгинь цочмог хатгалгааны өвчний 68—85 % архагшиж байна (4).

БНМАУ-ын эдийн засаг, нийгмийг 1986—1990 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд хүн амыг өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, диспансерийн хяналтад авах, хөдөөгийн хүн амд үзүүлэх эмнэлгийн нарийн мэргэжлийн тусламжийг нэмэгдүүлэх арга хэмжээг өргөжүүлэх сум дундын зарим эмнэлгийг нэгдсэн эмнэлэг болгон өргөтгөхийн хамт сум суурин газруудын эмнэлэгт хүүхэд, эмэгтэйчүүд, шүдний эмчийн хүрэлцээг сайжруулах, аймгийн нэгдсэн эмнэлэг, улсын хэмжээний үйлчилгээ бүхий нарийн мэргэжлийн төв диспансер, клиничийн эмнэлгээс хөдөөгийн хөдөлмөрчдөд газар дээр нь үзүүлэх эмнэлгийн үйлчилгээг өргөтгөхөөр заалаа.

Хүн амыг өвчлөхөөс урьдчилан сэргийлэх, аливаа өвчнийг эрт илрүүлэх, диспансерийн хяналтад авч, хөдөлмөр ахуйн нөхцөлтэй нь холbon төгс эрүүлжүүлэх замаар өвчлөл, нас баралт, хөдөлмөрийн чадвар түр алдалт, тахир дутуу болох явдлыг бууруулж чадсанаар

хөдөлмөрийн нөөцийг нэмэгдүүлж, нийгэм эдийн засгийн хөгжлийг түргэтгэхэд эрүүлийг хамгаалахын үр ашиг гардаг.

Тайлангийн материалаас үзэхэд манай улсын нийт хүн амын 15 орчим хувь, бодит судалгаагаар зарим хот, аймаг, район, сумын хүн амын 20 гаруй хувийг диспансерийн хяналтад авсан байна. Хүн амын өвчлөлийн байдалтай харьцуулбал архаг өвчнөөр өвчлөгсдийн гуравны нэг орчмыг эмнэлгийн идэвхтэй хяналтад авч байна. Гурав хүртэлх наслын хүүхэд, жирэмсэн ба нялх биетэй эх, уул уурхай мэт хүнд үйлдвэрийн ажилчид, үйлдвэр, соёл, шинжлэх ухааны тэргүүний хүмүүс диспансерийн бүрэн хяналтад оржээ. Тус улсын хүн амын диспансерчлалын одоогийн бодит байдлын энэ тоон үзүүлэлт дээр дүгнэлт хийж цаашдын төлвийг боловсруулсан байна.

Нийт хүн амыг зохих үе шаттайгаар диспансерчлахад шилжих ажил хоцрогдож байгааг МАХН-ын XIX их хурал тэмдэглэсэн билээ. Эрүүлийг хамгаалах Яам тус улсын нийт хүн амыг диспансерчлах ажлыг зохих үе шатаар эхэлж 1996—2000 онд дуусгах хэтийг чиглэл бодлогыг боловсруулав.

Диспансерийн хяналт нь өвчний учир хяналтад авсан хүн бүрийг жил тутам лаборатори, рентген, үйл оношийн шинжилгээгээр, үндсэн гурваас доошгүй мэргэжлийн эмч нар үзэж өвчтөнийг хяналтад авсан эмч нар улирал бүр хянагчдыг нэгээс дээш удаа үзэж өвчний дахилт, сэдрэлтийн эсрэг системтэй эмчилгээ хийж эмнэлэг-нийгийн эрүүлжилтийн идэвхтэй арга хэмжээг зохион байгуулахыг хэлнэ. Диспансерийн хяналтад авсан эрүүл хүмүүст энэ тодорхойлолтын эхний үзлэг, шинжилгээг хийж, эрүүл мэндийн талаар тусгайлан тогтоосон бүлгийн үнэлгээ өгч эгзэгтэй, өртөмтгийг байдлыг арилгах арга хэмжээ авч хянах болно.

1981—1985 онд БНМАУ-ын хүн амын нийт өвчлөлийн дундаж төвшин бүтцийг нарийн судлан тогтоож, улмаар 1986—1990 онд тус улсын эх нялхас, ажиллагдыг үе шаттайгаар диспансерчлах зохион байгуулалтын хэлбэр, арга зүй, хот хөдөөгийн хүн амд үзүүлэх эмнэлгийн тусlamжийн ялгаварт нормативыг боловсруулсны үр дунд БНМАУ-ын нийт хүн амыг 2000 он гэхэд бүрэн диспансерчлах зорилтог тавьж байна. Диспансерчлах ажлыг гурван шаттай явуулна.

1-р үе буюу 1986—1990 онд хүн амыг олноор диспансерчлах бэлтгэл ажлыг хангах (материаллаг бааз, боловсон хүчиний бэхжүүлэх, зохион байгуулалтын арга хэлбэрийг боловсронгуй болгох, чанаржуулах) болно. 1986—1990 онд 0—3 наслы болон 7 настай бүх хүүхэд, жирэмсэн эхчүүд, үйлдвэрийн ажилчид, малчид, хөдөө аж ахуйн механизмуулагчид өсвөр үеийг (16—18 наслы) нийтээр диспансерчлах ажилд шилжих юм. Энэ үед амбулатори-поликлиникийн тусlamжийн зохион байгуулалтын одоогийн арга, үйлчилгээний хэлбэрийг өөрчилж урьдчилан сэргийлэх үзлэгийн тасаг бүхий дэвсгэр нутгийн томоохон поликлиник байгуулах асуудалд гол анхаарлаа хандуулах нь зүйтэй.

Диспансерчлал бол нийгмийн асуудал мөн. Диспансерийн хяналтад юуны өмнө ажиллагдыг авч тэдний хөдөлмөрийн чадварын урт ба түр хугацааны алдагдлыг сэргээх, эрүүл мэндийг бэхжүүлэх ажлыг нэн тэргүүний зорилт болгодог. Иймээс юуны өмнө ажиллагдыг диспансерчлах асуудлыг эрүүлийг хамгаалахын онолын судалгаа, практик арга хэмжээний тэргүүн шугам болгож байна.

1991—1995 онд диспансерчлалын хүрээг өргөтгөж чанар, үр дүнг дээшлүүлж тус улсын нийт хүн амын 60—80 хувийг жил бүр диспансерийн буюу эмч нарын бүрдмэл үзлэгт оруулах юм,

1996—2000 онд манай улсын нийт хүн ам үндсэндээ диспансерийн хяналтад хамрагдах болно.

Диспансерчлалын түвшин, хамааралтыг тогтмол өргөсгөн нэмэгдүүлж, байнгын хяналтыг эмч нарын бүрдмэл болон урьдчилан сэргий-

Xуснэгт 1

Нийт хүн амыг диспансерчлах үе шатлал

I (1986—1990)

Бэлтгэл үе

Материаллаг
баз

Боловсон
хүчин

Зохион
байгуулалт

Арга
зүй

Эхлэл

Эх нялхас, үйлдвэрийн ажилчид, өсвөр үе

II (1991—1995)

Хэрэгжилт
(Өргөжилт, чанар, ҮР ашиг)

Бүх хүн амыг жилд нэг удаа диспансерийн
үзлэгт оруулна

Хүн амын 60—80 %

III (1995—2000)

Хэрэгжиж дуусах

Бүх хүн амыг үндсэнд нь диспансрчлах

Лэх үзлэгээр хийж, үр ашгийг тооцон практик ажиллагаанд нэвтрүүлэх талаар Эрүүлийг хамгаалах Яамнаас 1986 онд тусгай тушаал гарган хүн амыг диспансерчлах аргачлалыг шинэчлэн боловсрууллаа. Одоогийн нөхцөл байдлаас судлан үзэхэд нэг эмчид хяналтад эрүүл болон өвчтэй хүмүүсийн тооны доод хэмжээг ихэсгэн, диспансерийн хяналтад 230 өвчтөнийг (насанд хүрэгсдийн 130, хүүхдийн 70) нэршилийн жагсаалтаар хянахаар тогтов.

Xуснэгт 2

Хүн амыг диспансерчлах шинэ аргачлалын
бүтэц

Өвчлөгсдийг
илрүүлэх

— Урьдчилан сэргийлэх үзлэг (урьдчилан байнгын зориудын)

— Эмч нарын бүрдмэл үзлэг

— Амбулатори, стационарын өвчтөнөөс

Динамик
ажиглалт

— Эрүүл хүмүүс (жилд 1—2)

— Өвчтэй хүмүүс (үзлэг, шинжилгээ, эмчилгээний арга
өвчний нэршлээр —230)

Үр дүнг
тооцох

— Эмнэлгийн үр ашиг

— Нийгмийн үр ашиг

— Эдийн засгийн үр ашиг

Диспансерчлал бол амбулатори-поликлиникийн „үйлдвэрийн бүтээгдэхүүн“ байдаг учраас орчин үед хүн амын өвчлөлд 70 гаруй хувийг эзэлж байгаа амьсгал, зүрх судас, мэдрэл ба мэдрэхүйн эрхтэн, хоол боловсруулах ба ялгах эрхтний өвчнийг эмчлэх, сэргийлэх ажилд поликлиникийн үүрэг ихээхэн өслөө.

Дэвсгэр нутгийн зарчим бол поликлиникийн үйлчилгээний үндэс юм (3).

Диспансерийн хяналтыг өргөсгөх анхны үе шат бол өвчнийг аль болох эрт илрүүлэх асуудал мөн. Орчин үеийн шаардлагын үүднээс авч үзвэл амбулатори-поликлиникийн эмч нар дэвсгэр нутгийн үйлчилгээний хүн амд жил бүр эмч нарын бүрдмэл үзлэг хийж өвчтэй хүмүүсийг хяналтад авах, мөн больницод хэвтсэн, амбулаторид үзүүлсэн хүмүүсээс диспансерийн хяналтын хүмүүсийг сонгон авах, эмч нарын бүрдмэл үзлэг хийж диспансерийн хяналтыг өргөсгөнө (2).

Хүснэгт 3

Поликлиникийн эмч нарын бригадын үзлэг

Бригадын үзлэг

Бие бялдар, лаборатори, үйл оношийн шинжилгээ (эмнэлгийн дунд мэргэжилтэн)

Үндсэн мэргэжлийн эмч нарын үзлэг (хэсгийн эмч, эмэгтэйчүүд, мэс засал)

Нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг

Өндөр, нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг

ДҮГНЭЛТ: Нийт хүн амыг зохих үе шаттай диспансерчлах ажлыг идэвхтэй, жигд зохион байгуулан, урдчилан сэргийлэх ажлыг давамгайлан хөгжүүлэх, амбулатори-поликлиникийн тусламжийг зөв зохистойгоор зохион байгуулах, эрүүлийг хамгаалахын байгаа нөөц бололцоог зөв зохистой ашиглан эмнэлэг үйлчилгээг чанарын цинэ шатанд гаргах явдал эрүүлийг хамгаалахын чухал зорилт мөн.

АЦИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. Г. А. Новгородцев и др — Диспансеризация населения СССР. М. 1985.
2. П. П. Петров и др — Организация динамического наблюдения в условиях диспансеризации. Сов. здравоохранение. 1986. 10.
3. Л. Ф. Серенко и др. — Основы организации амбулаторно-поликлинической помощи. М. 1976.
4. Н. В. Эльштейн — Терапевт и специализации медицины. М. 1979, Таллин

Редакцийд ирсэн 1986. 11. 25

АРХИДАН СОГТУУРАХТАЙ ТЭМЦЭХЭД ЭМНЭЛГИЙН БАЙГУУЛАГААС ЗОХИОХ АЖИЛ

Ариун цэвэр гэгээрлийн сурталчилгааны чухал хэсэг нь архидалттай хийх тэмцэл мөн. Архидалтын эсрэг сурталчилгааг ямар ч ажил мэргэжил, албан тушаалын хүмүүс, ахмад, залуу үе явуулж болно. Гэвч эмч, эмнэлгийн ажилтан нар хүний эрүүл мэндийг гардан хариуцаж, ажил амьдралын аливаа нарийн асуудлын гүнд нэвтэрдэг учраас тэдний хийсэн ухуулга сурталчилгаа илүү үр дүнтэй байх ёстой. Учир нь архи, төрөл бүрийн мансууруулах ундаа эд эрхтэнд яаж нөлөөлдөг, ямар хор хохирол учруулдгийг эмч хүн бусад мэргэжлийн хүмүүсээс сайн мэддэг, тайлбарлан ойлгуулах чадвартай к.м. Гагцхүү эмч хүн мэргэжлийнхээ үүднээс асуудлын эв дүйгий нь олж зөв ойлгуулж итгүүлэх урлаг, сэтгэхүйг эзэмдэх чадварыг өөрөө эзэмших нь чухал.

Архидалттай тэмцэх талаар гарсан МАХН-ын Төв Хорооны 1985 оны 08 тоот албан даалгавар, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1985 оны 126 дугаар зарлиг, ууж согтуурахтай тэмцэх ажлыг хүчтэй болгох тухай Эрүүлийг хамгаалах Яамны сайдын 1985 оны 115 дугаар тушаалын заалтыг биелүүлэгч жинхэнэ эзэн нь эмнэлгийн ажилтан байх нь тодорхой.

Эдгээр албан даалгавар, зарлиг тушаалыг хэрэгжүүлэх нь зөвхөн хэв журмын зөрчлөөс сэргийлэх төдийгүй архидалттай холбоотойгоор үүсдэг сэтгэхүйн хямрал, солиорол, төрөл бүрийн гэмтэл, элэг цөс, хоол боловсруулах замын эрхтэний үрэвээл, сурьеэ, зүрх судасны өвчин, архаг эмгэгт нэрвэгдэгчдийн тоог үлээмж багасгах боломжтой юм. Өөрөөр хэлбэл архидан согтуурахыг арилгаснаар хүн амын эрүүл мэнд сайжирч, эмнэлгийн байгууллагуудын ажлын ачаалал багасах юм.

Хэнтий аймагт 1985 онд тахир дутуугийн группэд орсон 240 хүний материалтай танилцаж, өөрсөдтэй нь уулзаж ярилцахад тэдний 37 хувь нь архидалттай холбоотой байв.

Улаанбаатар хотын Гэмтэл согогийн эмнэлгийн 1985, 1986 оны эхний гурван улирлын дүн бүртгэлийн мэдээг харьцуулан үзэхэд согтуурлаас шалтгаалсан гэмтлийн эзлэх хувь нэг түвшинд байлаа.

Архидан согтуурах явдалтай эмнэлгийн байгууллагаас хийх тэмцэл нь нэгдүгээрт ухуулга сурталчилгаа, хоёрдугаарт архаг архичдад хийх архинаас гаргах эмчилгээ юм.

Архидалтын эсрэг хийх сурталчилгаа.

Архидалттай тэмцэхэд эмнэлгийн байгууллагаас зохиох ажлын гол хэлбэр нь ухуулга сурталчилгаа юм. Ухуулгыг хүмүүсийн нас, ажил мэргэжил, архи хэрэглэдэг эсэхийг харгалzan төрөлжүүлж хийх нь үр дүнтэй байдаг. Архи хааяа уудаг цаашид ууж болзошгүй хүмүүст архины хорыг тодорхой жишээгээр тайлбарлан цаашид архийг даамжуулан уухгүй байх талаар сурталчилгаа хийвэл зохино.

Нэгэнт архичин болсон хүмүүст бол архины хор нөлөөг өөрт нь байгаа эмгэг өөрчлөлтэй холбон тайлбарлаж архинаас өөрөө гарах эрмэлзэл төрүүлэх ийн чухал. Тийм хүмүүст архинаас гарч эрүүлжин ажил амьдралаа үргэлжлүүлэн хийж байгаа хүмүүсийн жишээ татаж ойлгуулах нь чухал.

Залуучууд өсвөр үеийнхэнд хийх сурталчилгаанд архи хүний эрүүл мэндийг хохироож эрдэм боловсрол, эрхэлсэн хөдөлмөргүй болгож,

айл гэрийн амьдралыг бусниулан, амь насыг алдагдуулдгийг тайлбарлаж ойлгуулах нь зүйтэй.

Эх эцэг, эмэгтэйчүүд, гэрийн ажилтай хүмүүст архидалттай тэмцэх талаар хийх ухуулга сурталчилгааны гол нь гэр орондоо архидах боломж, нөхцөлийг бүрдүүлэхгүй байх, зочноо зөв, архигүй зочлох, хүүхэд залуучуудыг багаас нь архинаас хол байлгахад чиглэгдвэл зохино.

Наркологийн тусламж

Архидалттай тэмцэх талаар эрүүлийг хамгаалах байгууллагаас хийвэл зохих ажлын нэг чухал хэсэг нь наркологийн тусламжийн асуудал юм.

Архаг архичинг эмчилж хордлогыг нь тайлж, архи жигшээх бүрдмэл арга хэмжээг наркологийн тусламж гэж нэрлэдэг.

Архичдыг эмчилж ажил амьдралд үбुцааж оруулан, эрүүл мэндийг нь анхаарах талаар Эрүүлийг хамгаалах Яамны системийн байгууллагууд олон чухал арга хэмжээ авч хэрэгжүүлж байна.

Хүн амд үзүүлэх наркологийн тусламжийг өргөтгөн чанаржуулах зарим арга хэмжээний талаар гарсан Эрүүлийг хамгаалах Яамны сайдын 1986 оны 108 дугаар тушаалд сэтгэл мэдрэлийн өвчний эмчлэх улсын клиникин эмнэлгийн наркологийн тасгийг эмчилгээний 80 ортой, 3—4 их эмчтэй ажиллуулах, сэтгэл мэдрэлийн улсын диспансерийн наркологийн кабинетыг архины эсрэг эмчилгээ хийж, үр дүнг нь хянан, архины хорын эсрэг сурталчилгааны ажил зохиодог „Наркологийн зөвлөгөө өгөх төв“ болгон 10—15 ортой өдрийн эмчилгээний газар байгуулсан билээ. Мөн тушаалаар хүн амын дунд согтууруулах ундааны зүйлийг хэтрүүлж хэрэглэгчид, архаг архичдыг илрүүлэх үзлэгийг жилд 2 удаа зохион явуулж тэднийг архинаас гаргах, эмчлэх ажлыг тогтмолжуулах, Ховд, Архангай, Дорнод аймаг, Дархан хот, Улаанбаатар хотын районын амбулатори-поликлиникт наркологийн кабинетыг нээх, нарколог эмчийн мэргэжил олгох курсыг 1986 онд улсын хэмжээгээр анх удаа зохион байгуулж хийлгэх, сэтгэл мэдрэлийн эмч нарын мэргэжил дээшлүүлэх курсын программыг наркологийн чиглэлээр өргөжүүлэх зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж эхлээд байна.

Эмнэлгийн байгууллагад архичин байх ёсгүй

Архи хүний эрүүл мэндэд, ажил амьдралд ямар их хохирол учруулдагийг сайн мэддэг, архидалттай тэмцэх ажлыг зохион явуулдаг гол байгууллагын хувьд эмнэлгийн аль ч салбарт архи уудаг хүн байх ёсгүй. Энэ талаар үлгэр жишээ байгууллага байх ёстой юм. Гэтэл 1986 оны эхний хагас жилд эрүүлийг хамгаалах байгууллагын хэмжээгээр бүртгэгдсэн 122 хэрэг зөрчлийн 52 (45 хувь) нь архидалттай холбоотой байгаа нь зохиож байгаа ажил хангальгүй харуулж байна.

Эрүүлийг хамгаалах Яамны сайдын 1985 оны 115 дугаар тушаалд „Эрүүлийг хамгаалахын ажилтан ажилчид архи уух ёсгүй“ сэдэвт гэгээрлийн хурал хийж, архи уудаггүй байгууллага, цех, тасаг, кабинет, салбар, анги, хэсэг болох хөдөлгөөнийг хамт олны дунд өрнүүлэх, үүрэг амлалт авахуулах гэсэн заалтыг эмнэлгийн байгууллага бүр хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна.

1985 онд Анагаах ухааны дээд сургууль, Улсын хүүхдийн клиничийн төв эмнэлгийн хамт олноос архи уудаггүй хамт олон болохоор нийт эмнэлэг, урьдчилан сэргийлэх байгууллагыг уриалж авсан үүрэгт архидан согтуурах явдалтай хийх тэмцлийн талаар гарсан МАХН-ын Төв Хорооны албан дээлгавар, Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн зарлигийн дагуу хөтөлбөр гарган эмч, ажилчдад хичээл заах, согтуурах

ундааны зүйл хэрэглэж болзошгүй хүмүүсийн судалгаа гаргаж тэдэнд хalamжлан хүмүүжүүлэгчийг томилж ажиллуулах, хэвтэж эмчлүүлэгчдэд тухайн сэдвээр хичээл заах, ажилчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд эмнэлгийн нам, захиргаа, олон нийтийн байгууллагууд биечлэн оролцох зэрэг олон чухал ажлыг хийхээр амлалт авсан билээ.

Энэ уриалгыг хэрэгжүүлэх талаар эмнэлгийн байгууллага бүр санаачилга гарган ажиллах нь чухал байна.

Редакцид ирсэн 1986. 09. 18.

СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ

Ш. ЧАДРААБАЛ, П. ЯНСАН (Анагаах ухааны хүрээлэн)

МАЛЧДЫН ӨВЧЛӨЛ, ХООЛЛОЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ

Хүн амын эрүүл мэнд, ялангуяа өвчин эмгэг нь тэдний орчин ахуй, дадал заншил, хоол тэжээлтэй ихээхэн холбоотой байдаг. Ялангуяа хоолны найрлага, хүнсний хэрэглээний бүтэц нь хүн амын эрүүл мэндэд нөлөөлдөг чухал хүчин зүйлийн нэг юм. МАХН-ын нийгэм эдийн засгийн бодлогын нэг чухал бүрэлдүүн хэсэг нь хөдөөний хүн амын аж байдал, соёл ахуйн нөхцлийг сайжруулах явдал мөнийг хөдөө аж ахуйг хөгжүүлэх, хүн амын хүнсний хангамжийг сайжруулах зорилтот программаар тодорхойлон заасан билээ. (5).

Манай орны мал аж ахуйн үйлдвэрлэлд 112,6 мянга гаруй хүн ажиллаж байна.

Тус улсын байгаль газар зүйн янз бүрийн бүсийн бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг малчдын хөдөлмөр ахуй нөхцөл, эмнэлэг үйлчилгээг сайжруулах асуудлыг иж бүрнээр судлах даалгаврын дагуу Анагаах ухааны хүрээлэнгээс Өмнөговь аймгийн Ханхонгор, Булган аймгийн Орхон, Хэнтий аймгийн Дархан сумын малчдын эрүүл мэнд, хооллолтын бодит байдлыг судалсан юм.

Судалгааны зорилго нь: Малчдын эрүүл мэнд юуны өмнө өвчлөлтийн түвшин, бүтэц, хоол тэжээлийн бодит байдлыг судлан тогтоох, хүн амыг эрүүлжүүлэх, хүнсний хангамжийг сайжруулах арга хэмжээг боловсруулах явдал байв.

Бид малчдын өвчлөлийг орчин үеийн нийгмийн эрүүл ахуйн ухааны сонгомол 2 арга болох эмнэлэгт үзүүлсэн байдлыг болон эмч нарын бүрдмэл үзлэгийн материалаар, хоол тэжээлийн бодит байдлыг хавар, намрын улиралд анкет судалгааны аргаар тус тус судлав. Судас хатуурах, зүрх судасны ба хоол боловсруулах эрхтэний өвчин эмгэгийн ихэнх нь хоол тэжээлтэй шууд холбоотой байдаг.

Манай улсын малчдын нийт өвчлөл *1000 хүн амд 1245,5* байна. Өвчлөлийн түвшин, бүтцэнд хоол боловсруулах эрхтэний өвчин зонхилох суурийг эзлэж байна. Малчдын нийт өвчлөл дотор хоол боловсруулах эрхтэний өвчин 22,6 хувь буюу (298,1%) хоёрдугаарт орж байна. Гэтэл эмч нарын бүрдмэл үзлэгээр илэрсэн нийт өвчлөлийн 40 гаруй хувийг нь эзэлж байна.

Хоол боловсруулах эрхтэний өвчиний дотроос хodoод 12 хуруу гэдэсний төрөл бүрийн үрэвсэл, гэдэс хodoодны хямрал, элэг цөсний замын үрэвсэлт өвчин зонхилон тохиолдож байна.

Хооллох дэглэмийг зөв баримтлаагүйгээс ихэвчлэн хodoодны архаг үрэвсэл үүсч байна. Тухайлбал удаан хугацаагаар өлсөх, хэт хурц хоол идэх, хэтэрхий халуун хоол унд хэрэглэх, цаг баримжаагүй хооллох, яаруу сандруу идэж уух зэрэг орно. Энэ өвчинийг эмчлэхэд өвчиний үе шатыг харгалзан хоолыг зөв тохируулах нь шийдвэрлэх ач холбогдолтойг зөвлөлтийн эрдэмтэд (М. А. Самсонов, А. А. Покровский 1971) судлан тогтоосон байна. Эмнэлэгт үзүүлсэн материалаар бүртгэгдсэн хodoод, 12 хуруу гэдэсний үрэвсэлт өвчин хоол боловс-

Хүснэгт 1

**Хоол боловсруулах эрхтэний өвчин
(эмч нарын бүрдмэл үзлэгээр)
илэрсэн нийт өвчин**

Сумдын нэр	1000 хүн амд ногдох өвчлөл	нийт өвчлөлд эзлэх хувь %
Ханхонгор	595,5	43,1
Орхон	462,2	41,0
2 сумаар	528,8	42,0

Хүснэгт 2

**Хоол боловсруулах эрхтэний өвчлөл
(1000 хүн амд)**

Өвчний нэр	эмнэлэгт үзүүлэлтээр	эмч нарын үзлэгээр шинээр илэрсэн	нийт өвчлөл
Бүх өвчлөл	84,0	214,1	298,1
Үүнээс: гастрит дуоденит	35,9	31,3	67,2
Ходоод гэдэсний хурц хямрал	8,2	6,5	14,7
Элэг цэсний өвчин	17,2	9,8	27,0

руулах эрхтэний нийт өвчлөлийн 41,7 хувийг, гэдэс хodoодны хямрал 21,6 хувийг тус тус эзэлж байна.

Эмч нарын бүрдмэл үзлэгийн материалыар хоол боловсруулах эрхтэний өвчин нэгдүгээрт байгаа нь шүд, амны хөндийн өвчин үзлэгээр их хэмжээтэй илэрдэг, нөгөө талаар энэ ангиллын архаг өвчин нэлээд оношлогдсонтой холбоотой байна. Шүд, амны хөндийн хурц өвчин 1000 хүнд 395,5% илэрсэн байна. Ходоод 12 хуруу гэдэсний үрэвсэл нь 30—39 (358,5%), 40—49 (350,0%), 50—59 (388,4%) насанд зонхилон илэрсэн байна.

Хүснэгт 3

**Малчдын хоол боловсруулах эрхтэний нийт өвчнийг
ЗХУ-ын судалгааны материалтай харьцуулбал**

Судалгаа хийсэн газар, зохиогч, он	1000 хүнд ногдох интенсив үзүүлэлт
1. З(өвлөт Казах улсын малчид С. Х. Душманов 1979)	120,6
2. Зөвлөлт Дагестаны малчид (Н. Х. Джангишиев 1976)	211,9
3. БНМАУ-ын малчид (1984 он)	281,1

Манайд хоол боловсруулах эрхтэний өвчлөл Зөвлөлт Казак улсын малчдын өвчлөлөөс 2 гаруй дахин их байна. (1). Үүнийг манай малчдын хоол тэжээл, түүний дэглэм, дадал заншилтай ихээхэн холбоотой гэж үзнэ.

Манай хөдөөний хүн ам, ялангуяа малчид хоол хүнсэндээ их хэмжээний мах хэрэглэж ногоо жимс бараг хэрэглэхгүй, цайг халуунаар ихээр уудаг, хооллох тодорхой дэглэмгүй, хоногийн хоолны ихэнхийг орой хэрэглэдэг зэрэг онцлог, ахуйн заншилаас ходоод гэдэсний архаг өвчин харьцангуй их тохиолддог байна (4). Ходоодны архаг үрэвсэлтэй өвчтөний 87% нь дэглэмгүй хооллодог, 70% нь хурц өөх тостой шарсан хоол хэрэглэдэг байна (3).

Хүснэгт 4

**Малчдын хоногийн хоолны найрлага, илчлэг
($M \pm m$)**

Хоногийн хоолны найрлага	Булган аймгийн Орхон сум	Хэнтий аймгийн Дархан сум	Өмнөговь аймгийн Ханхонгор сум
Уураг, г	128,63 \pm 1,1	131,18 \pm 1,93	121,89 \pm 1,70
Өөх тос, г	114,67 \pm 3,7	105,09 \pm 2,76	75,59 \pm 2,18
Нүүрс ус, г	422,95 \pm 4,8	369,8 \pm 8,16	518,90 \pm 8,74
Илчлэг ккал	3321,1 \pm 41,4	3121,86 \pm 18,6	3329 \pm 40,3

Хүснэгт 4-өөс үзэхэд малчдын хоногийн хоолны илчлэг нь физиологийн шаардлагыг хангаж байна. Харин Ханхонгор сумын хувьд хоолны найрлаганд өөх тос харьцангуй бага байна.

Хүснэгт 5

**Малчдын хоногийн хоолны илчлэгийн хуваарилалт
($M \pm m$)**

Илчлэгийн үзүүлэлт	Булган аймгийн Орхон сум	Хэнтий аймгийн Дархан сум	Өмнөговь аймгийн Ханхонгор сум
Өглөөний хоолны илчлэг	26,56 \pm 0,85	30,0 \pm 1,1	23,14 \pm 1,08
Өдрийн хоолны илчлэг	33,90 \pm 0,88	32,0 \pm 1,1	40,0 \pm 1,1
Оройн хоолны илчлэг	39,64 \pm 0,83	37,3 \pm 1,1	36,0 \pm 1,56

Хооллох дэглэмийн нэг чухал үзүүлэлт болох хоногийн хоолны илчлэгийн хуваарилалтыг авч үзэхэд нийт илчлэгийн $23,14 \pm 1,08 - 30,0 \pm 1,1$ хувийг өглөө, $32,0 \pm 1,1 - 40,0 \pm 1,1$ хувийг өдөр, $36,0 \pm 1,56 - 39,64 \pm 0,89$ хувийг орой тус тус хэрэглэж байна. Энэ нь хоногийн хоолны илчлэгийн ихэнх нь буюу 50-иас дээш хувь нь оройн хоолонд ногддог байсан заншилд аажмаар нааштай өөрчлөлт гарч байгааг харуулж байна. Гэвч тодорхой цаг баримтлан хооллох асуудал малчдын хувьд хангалтгүй байна.

Үндсэн шимт бодисууд болох уураг, өөх тос, нүүрс усны хангамжийн харьцаа $1 : 1 : 3 - 1 : 1 : 3,3$ байгаа ба хоногийн хоолны нийт илчлэгт тэдгээрийн өгч байгаа илчлэгийн эзлэх хувийн жингийн харьцаа $17 : 32 : 51$ байгаа нь манай хүн амын хоолны найрлагын тохиирооны онцлогийг харуулж байна.

Малчдын хоол тэжээлийн найрлаганд байгаа уургийн 60-аас илүү хувийг амьтны гаралтай сайн чанарын уураг эзлэж байна.

Малчдын хоолны найрлаганд $869,25 \pm 31,6 - 1038,09 \pm 44,07$ мг кальц, $1668,29 \pm 37,2 - 1675,66 \pm 23,36$ мг фосфор агуулагдаж байгаа нь эрүүл ахуйн шаардлагын үүднээс авч үзэхэд хангалттай хэмжээ կ.м. Гэвч малчдын хоолны найрлаганд байгаа С витамины хэмжээ ялангуяа хаврын улиралд шаардлагатай хэмжээнээс ихээхэн доогуур байлаа. Энэ нь малчдын хоол тэжээлд С витаминаар баялаг төрөл бүрийн хүнсний ногоо бараг хэрэглэгдэхгүй байгаатай холбоотой կ.м. Ер нь малчдын хоол хүнсний нэр төрөл цөөн max, гурил, сүү зэрэг цөөн бүтээгдэхүүн өдөр тутам давтсан хэрэглэгдэж байна.

Хөдөө орон нутгийн нөхцөлд хамгийн их бололцоотой сүүний хэрэглээний хэмжээ аль ч улиралд шаардлагат хэмжээнд хүрэхгүй байна. Энэ бүгд нь хөдөөгийн хүн амын хүнсний хэрэглээний бүтээцийг сайжруулах шаардлагатай харуулж байна.

Бид дээрх шаардлагыг харгалзан үзэж дурдсан сумдын хүн амын хүнсний хангамжийг сайжруулах арга хэмжээний тухай зөвлөмж боловсруулж тус тусын сум нэгдэлд шилжүүлсэн нь эдгээр сумдын хүнсний программын эрүүл ахуйн үндэслэл болж байна. Малчдын дунд цусны даралт ихсэх өвчин 62,1%, атеросклероз 21,6% тус тус илэрсэн байна. Энэ нь малчид давстай цай их хэрэглэдэг, өөх тос ихтэй хоол иддэгтэй холбоотой байж болно.

Малчдын дунд ходоод гэдэсний ба элэг цөсний архаг өвчин зонхилон тохиолдож байгаа нь тэднээс амралт, рашаан, хоолны сувиалд явах шаардлагатай харуулж байгаа կ.м. Ховд аймагт хийсэн судалгаанаас 1000 өвчтөн тутамд 214,9 нь рашаан сувиалд явах шаардлагатай байна (4). Гэтэл амралт, рашаан сувиалд жилдээ хөдөө аж ахуйн ажилчдын дөнгөж 10 хүрэхгүй хувь нь сувилуулж байна. Жанчивлангийн улсын рашаан сувиалд сүүлийн 10 жил сувилуулагчдын 72,6% нь ходоодны архаг үрэвсэлтэй (Б. Амар 1985), Хужиртад сувилуулсан цусны даралт ихтэй хүмүүсийн гуравны хоёр хувь нь даралт хэвийн байдалд орсон (Н. Дашлхавга, Т. Сүхбаатар 1985) зэрэгээс үзэхэд малчдын дунд зонхилж байгаа дээр дурдсан өвчиний рашаан сувиалд эмчлэн сувилах шаардлагатай байна. (4).

ДҮГНЭЛТ: 1. Малчдын нийт өвчлөлийн дотор хоол боловсруулах эрхтэний өвчин 1000 хүнд 298,1% буцу хоёрдугаарт байна. Малчдын дунд хооллох дэглэмтэй ихээхэн холбоотой ходоод, 12 хуруу гэдэсний үрэвсэл, ходоод гэдэсний хямрал, элэг цөсний үрэвсэлтэй өвчин, цусны даралт ихсэх, судас хатуурах зэрэг өвчин зонхилон тохиолдож байна.

2. Малчдын хооллолтын байдлыг судалсан дүнгээс үзэхэд тэдний хоногийн хоолны найрлаганд $121,89 \pm 1,70 - 131,18 \pm 1,93$ г уураг, $114,67 \pm 3,7$ г хүртэл өөх тос агуулагдаж байгаа нь манай хүн амын хоолны найрлага уураглаг-тослог чанартайг нотлон харуулж байгаа ба хоногийн хоолны илчлэг нь физиологийн шаардлагыг үндсэнд нь хангаж байна.

Гэвч малчдын хоол тэжээлд max, гурил голлож, витамин, эрдэс бодис элбэгтэй төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ маш хангалтгүй, негөө талаар хоолны хэм хэмжээ, дэглэм мөрдөгдөхгүй байна. Энэ нь тэдний хоолны найрлагын тохироог бие махбодын физиологийн шаардлагын хэмжээнд ойртуулан сайжруулах шаардлагатай харуулж байна.

3. Малчдын физиологийн шаардлагат хэмжээнд хүрэхгүй байгаа хүнсний бүтээгдэхүүний хэмжээг 5 жил тутам тодорхой хувиар нэмэгдүүлж 2000 он гэхэд хэрэгцээт шаардлагыг хангах зорилт тавих, үүний тулд ЭХЯ-ны сайдын 1984 оны 192 тоот тушаалаар батлагдсан эдгээр сумдын хүн амын хүнсний хангамжийг сайжруулах тухай зөвлөмж, 1981 оны 205 тоот тушаалаар батлагдсан – „БНМАУ-ын хүн

амын хоол тэжээлийн физиологийн норм" зэргийг хэрэгжүүлэх нь зүйтэй юм.

4. Улсын амралт, рашаан, хоолны сувилалд малчдын амрах хяналтын тоог ихэсгэх, одоогоор дөнгөж 19 байгаа нэгдэл дундын амралт, рашаан сувилалын тоог нэмэх, хүчин чадлыг нь ихэсгэх аж ахуй дундын ба хоршоолол, нэгдлийн биеэ даасан амралт, хоолны газар буй болгох хэрэгтэй.

Малчдын хүүхдийн хөдөлмөр амралтын зуслан лагерь, сувилал байгуулах, хөдөө аж ахуйн кампанит ажил эхлэхийн өмнө ба дууссаны дараа малчдыг бөөнөөр нь зохион байгуулалттай амрааж сувилуулах нь чухал байна.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. С. Х. Душманов—Особенности заболеваемости и медицинское обслуживание населения района отгонного животноводства., 1979. 9—11.
2. Н. Х. Джангишиев—Здравоохранение Российской Федерации. 1975. 3,25—28.
3. Ш. Чадраалбал, Д. Баянбилэг—Материалы научно-практической конференции НИИМ, УБ. 1984. 12—13.
4. Ш. Чадраалбал, Д. Эржен—Актуальные вопросы курортологии в МНР. УБ. 1985. 36—37.

НЕКОТОРЫЕ ВОПРОСЫ ЗАБОЛЕВАЕМОСТИ И ПИТАНИЯ ЖИВОТНОВОДОВ.

Ш. ЧАДРААЛBAL, П. ЯНСАН

В статье представлены фактическое состояние здоровья и питания животноводов, изученные авторами в трех экспериментальных сомонах страны.

Наибольшая частота заболеваемости хроническими болезнями приходится на болезни органов пищеварения 298,1%. В данном классе болезней наиболее частыми являются гастриты дуодениты 67,2% и функциональные расстройства желудка и кишечника 14,7%, болезни печени и желчного пузыря 27,0%. Наиболее частоту болезней органов пищеварения авторы связывают со своеобразным режимом и характером питания животноводов.

Редакцид ирсэн 1986.01.21

Ж. ЦОГНЭМЭХ, Я. ШАРХҮҮ (Анагаах ухааны дээд сургууль)
Д. СЭЛЭНГЭ (Химийн хүрээлэн)

АНАБАЗИНЫГ КЛИНИКТЫН ХЭРЭГЛЭСЭН ДҮН

Тамхийг тогтмол хэрэглэх нь хүний эрүүл мэндэд муугаар нөлөөлж бүх эрхтэн системийн үйл ажиллагааг аажмаар хордуулж нас богиносгох ноцтой хүчин зүйлийн нэг болно (4). Тамхины утаанд агуулагдах хүчтэй хоруудын дотор „никотин” (тамхины ургамлын гол алкалоид) голлох байрыг эзэлнэ. Тамхинд дасах нь гагцхүү түүний өвөрмөц амт, үнэртэй никотиноос хамаардаг (4, 5) байна. Хэрэв никотиниг нь ялган цэвэрлэвэл тамхи ямарч амт үнэргүй байхаас гадна хүний төв мэдрэлийн системд үзүүлэх өвөрмөц (тааламжтай, аятайхан) нөлөө байхгүй болно. Иймд архаг тамхичдыг тамхинаас гаргах хэд хэдэн аргын дотор никотиниг түүнтэй төстэй өөр бодисоор орлуулах аргыг сүүлийн үед хэрэглэх (3) болжээ. Никотиниг орлох бодисын тоонд лобелин, цитизин, анабазин зэрэг фармакологийн ойролцоо нөлөө бүхий алкалоидыг хэрэглэж байна.

Монголын Шинжлэх ухааны академийн Химийн хүрээлэн эх орны нэг зүйл ургамал болох „баглуураас“ цэвэр анабазин ялган авч клиникийн судалгаанд зориулан цөөн тоогоор шахмал эм бэлтгэн гаргажээ. Анабазин-фармакологийн үйлчилгээний хувьд никотинтой төстэй тул архаг тамхичдыг тамхинаас гаргах зорилгоор хэрэглэх бүрэн үндэстэй болох нь харагдлаа.

Фармакологийн бүлгийн хувьд анабазин алкалоид нь никотин, лобелины нэгэн адил (5, 1) төвийн ба захын холин рецептор, уртавтар тархин дахь амьсгалын төвийг сэргээх сонгомол нөлөөтэй бөгөөд анагаах ухааны практикт лобелин гидрохлорид, цититон (1, 2) зэргийг амьсгалын төв ямар нэг шалтгаанаар суларсан үед сэргээх зорилгоор хэрэглэнэ. Харин анабазины хөдөө аж ахуйд хортон шавьж устгахад хэрэглэнэ. Сүүлийн жилүүдэд никотиныг анабазин, лобелин зэргээр орлуулан архаг тамхичдыг тамхинаас гаргахын тулд (1, 2, 3) янз бүрийн хэлбэрээр (уух, жажлах, тарих) хэрэглэх болов.

Улсын Клиникийн төв эмнэлгийн мэдрэлийн тасагт цөөн тооны архаг тамхичинд анабазиныг уулгаж судалгаа хийв.

Хүснэгт 1

Анабазины үйлчилгээний Үр дүн

Асуулт	Анабазин хэрэглэсэн бүх хүн	Тамхинаас гарсан	Тамхинаас гараагүй
I хэвтэж эмчлүүлсэн	27	22	5
II Амбулаториор эмчлүүлсэн	10	6	4
Бүгд	37	28	9

Хүснэгт 2

Анабазин хэрэглэсэн хүмүүсийг насаар ангилбал

Асуулт	19 хүртэл	20—25	26—30	31—35	36—40	41—45	46—50	51 дээш
Хэвтэж эмчлүүлсэн	2	5	7	3	4	2	2	2
Амбулатоиын	1	3	1	4	1	—	—	—

Хүснэгт 3

Тамхи хэрэглэсэн хугацаагаар (жилээр) авч үзвэл

5 хүртэлх	6—10	11—20	21-ээс дээш
4 1	7 5	15 4	1 —

Больницод хэвтэж эмчлүүлээд эдгэрч байгаа 27, амбулаторийн нөхцөлд гэрээр эмчлүүлж буй 10, (сайн дурын үндсэн дээр) бүгд 37 хүнд анабазин өгч ажиглав.

Судалгаанаас үзэхэд хэвтэж эмчлүүлсэн (нэгдүгээр хүснэгт) 27 хүнд анабазиныг өдөрт 6—8 удаа уулгахад 22 нь (81,5%) тамхинаас бүрэн гарч 5-д нь (18,5%) үр дүн өгөөгүй.

Амбулаториор (гэрээр) анабазин хэрэглэсэн 10 хүний 6 нь (60%) тамхинаас гарч 4 нь (40%) тамхинаас гарч чадсангүй.

Анабазинаар эмчилсэн хүмүүсийг тамхи хэрэглэсэн хугацаагаар ангилахад 6—10 жил тамхи татсан 12 хүний 2 нь, 11—20 жил тамхи татсан 19 хүний 6 нь, 21-ээс дээш жил тамхи хэрэглэсэн 2 хүний нэг нь тамхинаас гараагүй байна.

Анабазин хэрэглэсэн хүмүүсийг насаар нь ангилахад тамхинаас гараагүй 9 хүний 7 нь 31-ээс дээш насын хүмүүс байв.

Дүгнэлт: 1. Эмчийн өдөр тутмын хяналтын дор анабазиныг клиникт хэрэглэхэд тамхинаас гаргах үр дүн 81,5% байв.

2. Гэрээр (эмчийн байнгын хяналтгүй) анабазиныг хэрэглэхэд архаг тамхичдын 60% нь тамхинаас гарч байв.

3. Анабазины тусламжаар тамхинаас гаргахад архаг тамхичдын нас, тамхи хэрэглэсэн хугацаа ихээхэн хамааралтай байна.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. С. В. Аничков, М. Л. Беленький—Учебник фармакологии. М. 1955. 54
2. Г. К. Батрак—Фармакология. Киев, 1980, 391
3. А. Н. Кудрин—Фармакология с основами патофизиологии. М. 1977. 258
4. Ф. Н. Петров, А. Ф. Серенко—Популярная медицинская энциклопедия М. 1968. 513.
5. Д. А. Харкевич—Фармакология М. 1980, 86.

КЛИНИЧЕСКОЕ ИСПЫТАНИЕ ТАБЛЕТОК АНАБАЗИНА

М. Цогнэмэх, Д. Сэлэнгэ, Н. Шарху

Фармакологическим советам при Министерстве здравоохранения МНР в качестве средства против курения рекомендовано применение анабазина. Анабазин в виде таблеток, назначается внутрь, 4—6 раз в день.

Полученный результат применения анабазина показывается, что из 37 курильщиков 28 прекратили курить, что составляет 81,5%.

Таким образом, анабазин оказался хорошим, эффективным средством в борьбе с курением.

При применении анабазин внутрь, у курильщиков ненаблюдались какого либо токсического действия и побочных явлений.

Редакцид ирсэн 1985. 07. 06

С. ЯДМАА (Хужирт рашаан сувилал)

ЭМЭГТЭЙЧУҮДИЙН АРХАГ ҮРЭВСЭЛ ӨВЧНИЙ ОНОШЛОХ, ТҮҮНИЙ БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОР ЭМЧИЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Бид, Хужиртын рашаан шаврын цогцолбор эмчилгээнд эмэгтэйчүүдийн бэлиг эрхтэний архаг үрэвсэл өвчний үед бичил цусан хангамжинд яаж нөлөөлдөгийг судлах зорилт тавьсан юм. Үрэвслийн голомтын бичил цусан хангамж нэгдүгээрт артерийн хялгасан судас түр хугацаагаар нарийсах, хоёрдугаарт хялгасан судас тэлж бүдүүрэх (үрэвслийн идэвхтэй улайлтын үе), гуравдугаарт цус тунгалаг тогтонгиших (үрэвслийн тогтонгишлын буюу венийн дүүрэлтийн үе), дөрөвдүгээрт цусны бичил эргэлт зогсох байдлаар хямардаг (1.2).

Умайн хүзүү, үтрээний хана, хүнхэр нь дотор бэлиг эрхтэний эруул, эмгэг эсэхийг гэрчилдэг. Дотор бэлиг эрхтэний архаг үрэвслийн улмаас мэдрэл судасны ажиллагаанд тэжээлийн болон органик өөрчлөлт гарах нь олонтоо байдаг. (5,7). Иймээс дотор бэлиг эрхтэний архаг үрэвслийг захын эрхтэний цусны бичил эргэлтийн шинжээр баттай оношлож болно. (5,7).

Хумсны толионы хялгасан судасны бичил эргэлтийн шинжээр зарим өвчний хөдлөл зүйг тогтоосонд үндэслэн энэхүү аргыг эмнэлзүй, физиологийн чухал шинжилгээ (3, 5, 7) гэж баталжээ.

Умайн хүзүү, үтрээн хүнхэр, үтрээн хананы дээд гуравны нэг нь умайн артерийн уруудах салааны цусаар хангагддаг (4, 6). Энэ нь бидний, гадна бэлиг эрхтэний бичил цусан хангамжийн үзүүлэлтээр дотор бэлиг эрхтэний архаг үрэвсэлт өвчний онош тогтоох, эмчилгээний үр дүнг шалгах анатоми, физиологийн үндэслэл болж байгаа юм-

Аргачлал. Хужирт рашаан сувиалд БНПАУ-ын „КЛР—21“ хэмээх 7 өнгөөр харж болох 300 дахин өсгөдөг хоёр нүдний колъюскопыг өргөн ашиглаж байна.

Кольюскопоор шинжлэх дараалал. Шинжлүүлэгчийг үзлэгийн орон дээр салтаа, хэвлэйн булчин нь физиологийн дундаж байрлаад байхаар байрлуулна. Колъюскопоо гүйдэлд залгана. Үтрээнд тохиорх хэмжээний өөрөө тогтдог толь тавина. Ямар өнгөнд харахаа гэрэл шүүвч ашиглан сонгож авна. Багаас өсгөн, хоёр нүдээр зэрэг шинжлэнэ.

Кольюскопын шинжилгээгээр умайн хүзүү, үтрээн хүнхэр, үтрээн хананы хялгасан судасны цусны бичил эргэлтийг:

1. Ягаан, улаан, хөхөвтөр, цайвар, бүүдгэрээр салстын дэвсгэр өнгөний байдал.
2. Харагдах хялгасан судасны тоо түүний цус дүүрэлт
3. Агчил, атонийн шинжээр хялгасан судасны хүчдэл
4. Артерийн хялгасан судаснаас венид шилжилтийн гогцоондох цус дүүрэлтийн шинж
5. Жигд тасалданги, лугшсан, буцаж урсаж байгаа эсэхээр цусны бичил эргэлт
6. Хэвийн, хурдассан, түргэссэн, алгуурхан, түр тасалдах, зогсолтоор цус урсах хурд.
7. Хялгасан судасны гогцоорох хэсэгт бүдүүрэх, цүлхийлт байгаа эсэх,
8. Хялгасан судаснаас нэвчилт байгаа эсэх, түүний хэмжээ. Эдгээр 8 үзүүлэлтийг зовиур шаналгаа, эмнэлзүйн шинж тэмдэг, эмнэлзүй, биохимиин шинжилгээний дүнтэй харьцуулан онош тогтоосон болно.

Кольюскопын шинжилгээг цогцолбор эмчилгээний өмнө, нэг удаагийн эмчилгээ дууссаны дараахан, 2 цаг өнгөрсний дараагаар хийж дунг нэгтгэн статистикийн боловсруулалт хийв. (11).

Хужирт рашаан сувиалын цогцолбор эмчилгээ

1. Эмчилгээний хоол
2. Өвчтөний гам
3. Хөдөлгөөний дэглэм
4. Гидрокарбонат, карбонат, натри, сулавтар радон, цахиурын хүчил, фтор бүхий азотын хий давамгайлсан нийлмэл найрлагатай разаанд орох.
5. Шавар эмчилгээг „гуявл“, „хөхөвл“ хэлбэрээр 40—42 градусаар 15 минутаар өнжөөд эсвэл хоёр өдөр дараалан тавьж, 3 дахь өдөр өнжих юм уу эсвэл рашаан онгоцонд оруулна.
6. Шулуун гэдэс үтрээний аль нэгээр 40—42 градусын халуун шавраар хоёр өдөр дараалан 20 минут шаврын чихээс хийх буюу эсвэл өнжөөд гадуур шавар эмчилгээ хийхдээ нэг өдөр хийнэ.

7. Эмчилгээний биеийн тамир.

Бид, судалгаандаа 22—45 насны 204 эмэгтэйг авч эмчилгээний үр дүнгээс хамааруулан хоёр бүлэгт хуваав.

Нэгдүгээр бүлэгт умай түүний дайврын архаг үрэвсэл нь 2—3 ээлж эмчилгээнд эрүүлжсэн бөгөөд өвчтөний өгүүлэл, эмнэлзүй, кольпоскопын шинжилгээгээр илэрхий байсан өвчтөнийг авав.

Хоёрдугаар бүлэгт архаг эмгэг нь дөрвөөс дээш ээлж эмчилгээнд сайжраагүй байгаа өвчтөнийг оруулав. Судалгааны үр дүнг харьцуулах зорилгоор хяналтын бүлэгт 22—45 насны жирэмсэн бус эрүүл 25 хүн хамруулж дээрх шинжилгээг нэгэн адил хийсэн болно.

Судалгааны дүн

Нэгдүгээр бүлэгт хамрагдсан 174 эмэгтэйд цогцолбор эмчилгээний өмнө кольпоскопын шинжилгээ хийхэд үтрээн хана, умайн хүзүү, хүнхэрийн салст бүрхүүлийн өнгө нэлэнхүйдээ тод ягаан, ганц хоёрын зэрэг хялгасан судас, багахан хэмжээний салс харагдаж байв.

Рашаанд оруулан үтрээн угаалга хийснээс хойш 2 цагийн дараа дээрх хүмүүст умайн хүзүү, үтрээн хана, хүнхэрийн хялгасан судас тэлэн өргөсөж урсгал нь жигд хурдассан байв. Салст бүрхүүлийн өнгө улам ягаарч тодорсон, хялгасан судсууд жигдхэн өргөссөн, венийн сүлжээ төдийлөн тодроогүй, салст эмчилгээний өмнөхтэй ижил хэмжээтэй байв.

Шавар „гуявл“, үтрээ, шулуун гэдэсний аль нэгээр шавар чихээс хийх эмчилгээний явцад умайн хүзүү, хүнхэр, үтрээн хананы салст бүрхүүл тодрон ягаарч, хялгасан судасны сүлжээ ихсэж, цусны урсгал нь хурдассан байлаа. Салстын өнгө тод ягаан болсон байв.

Эмчилгээний өмнөх болон дараах хувирлын зөрүү нь статистикийн үнэн магад ($P < 0.05$)-тай байлаа.

Хоёрдугаар бүлэгт хамруулсан 30 эмэгтэйд эмчилгээний өмнө кольпоскопоор харахад салст бүрхүүл улаан өнгөтэй, хялгасан судас нь ончрон зангиж жигд бус тэлсэн, цусны урсгал удааширсан, салст ихтэй байв. Энэ бүлэгт орсон эмэгтэйчүүдэд рашаан шаврын цогцолбор эмчилгээний дараах судасны хариу урвал нэгдүгээр бүлгийнхтэй харьцуулахад рашаан шаврын аль алинд тэр даруйдаа эрс тод биш харин хоёр цаг өнгөрсний дараа тодорхой илэрч байв. Үүнийг бид үрэвслийн голомтод тараах, хураах хялгасан судас нэг хэсэгтээ нарийсаж нөгөө хэсэгтээ будуурч ончрон цусны урсгал зогсох болтлоо удаашрах, тасалдах, цусны дүрст элемент нэвчин гарч байгаа, мөн ийм голомтын бүлэн, уургийн бүлэгнүүлэгч нь мэдрэл булчингийн судасны аппаратад цогцолбор эмчилгээнд илрэх хариу урвалыг бууруулах саатал, заримдаг саажил үүсгэсэн байдгаар тайлбарлаж байна.

Судас мэдрэлийн хариу урвалын энэ зөрүү статистикийн үнэн магад ($P < 0.05$)-тай байв.

Хяналтын бүлэгт кольпоскопоор эмчилгээний өмнөх өөрчлөлт нэгдүгээр бүлгийнхтэй ойролцоо байсан боловч эмчилгээний дараа хоёр цагийн хойнох хариу урвал тун сүл илэрч байв.

Дүгнэлт. 1. Хужиртын гидрокарбонат карбонат натри, гидросульфид, сувалтар, радонт цахиурын хүчил, форт, азотын нийлмэл найрлагатай рашаанаар эмэгтэйчүүдийн архаг үрэвсэл өвчнийг эмчлэхэд мэдрэл цусан хангамжийн илэрхий хариу урвал эмчилгээнээс хойш 2 цагийн дараа тодорхой илэрч байна.

2. Эмчилгээний шавраар гадуур болон дотуур (үтрээ, шулуун гэдэсний чихээс) эмчилгээ хийхэд мэдрэл цусан хангамжийн хариу урвал тэр даруйдаа маш хүчтэй илэрч байв. Эмчилгээний өмнөх, хойнох судасны өөрчлөлтийг шинжилгээд кольпоскопын шинжилгээ үр дүнтэй арга болох нь батлагдлаа.

3. Умай, дайврын архаг үрэвсэл нь эмчилгээ авахгүй байгаа хүмүүст мэдрэл, цусан хангамжийн урвал муу байв.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. А. Д. Адо—Акуш и гин. 1970, 6. 10—15
2. А. Д. Адо—Акуш и гин. 1971. 3, 20—25
3. Н. С. Бакшеев, В. Я. Голота и др—В кн; Акуш и гин. Киев. 1971, 1, 110—122.
4. Г. Ф. Иванов—Основы нормальной анатомии человека. М, 1959, 495—508.
5. В. Н. Компаниец—Лечение гинекологических больных на курорте Сергеевка-Кишинев, 176. 4—23.
6. О. К. Никончик—Артериальные кровоснабжения матки и придатков женщины. 1962. 61—69.
7. А. А. Тирана—Кольпо и капилляроскопические изменения до и во время, и после гинекологических бальнеопело процедур. Вопр, курсортологии. Рига. 1970, 215—218.
8. Геохимия подземных минеральных вод МНР изд второе исправ допол. Новосибирск 1980. 53—63.
9. Ж. Дугаржав—Анагаах ухааны статистикийн сурх. УБ. 1976.

РЕЗУЛЬТАТЫ ДИАГНОСТИКИ И ЛЕЧЕНИЯ ХРОНИЧЕСКИХ ВОСПАЛИТЕЛЬНЫХ ЗАБОЛЕВАНИЙ ЖЕНСКОЙ ПОЛОВОЙ СФЕРЫ

С. Ядма

После применения Хужиртинских гидрокарбонатно карбонатно натриевых гидросульфидных слабо радионовых кремнистых и фтористых ванн у больных женщин с воспалительными заболеваниями матки и придатков, выраженная ответная реакция с стороны капиллярного кровообращения половой сферы наступает через два часа после бальнеопроцедур.

А после применения грязевых аппликаций в виде трусов и вагинальных, а также ректальных тампонов наибольшая местная ответная реакция капиллярного кровообращения наступает сразу же во время применения пело процедур.

У женщин с затяжными течениями воспаления матки и придатков с усиленными выделениями из цервикального канала, ответная реакция капиллярных сосудов шейки матки и стенка влагалища после пелобальнео процедуры менее выражена.

Редакцид ирсэн 1985.05.18

С. РАДНААБАЗАР (Рашаан эмчилгээний туршлага шинжилгээний төв)

ХОЛЫН ЗАЙД ГҮЙГЧДЭД ХИЙСЭН ЭМНЭЛЭГ ХЯНАЛТЫН ЗАРИМ АЖИГЛАЛТ

Манай оронд нийтийн биеийн тамир, хол ойрын явган, дугуйтай, цанатай аялал эрчимтэй хөгжиж нийт хөдөлмөрчин олон түмэн, ялангуяа залуусын дуртай зүйл, бие махбодыг өлчиржүүлж чийрэгжүүлэх арга, тэсвэр хатуужил, эр зориг олгох хэрэгсэл болж байна (3).

Харин холын зайд явган аялах, гүйх, цана, тэшүүр, дугуйгаар явах тамирчдад хийсэн эмнэлэг хяналтын ажиглалт дутмаг байна.

Бид энэ удаагийн судалгаандаа 1275 км зайд өртөөчилөн гүйсэн тамирчдад хийсэн эмнэлэг хяналтын ажиглалтын материалыг ашиглав. Олон хоногийн гүйлтэнд 19—46 наасны 21 эрэгтэй тамирчин оролцсоны дотор хөнгөн атлетикийн спортын мастер I, I зэрэгтэй тамирчин 6, II зэрэгтэй тамирчин 14 байв. Эдгээр тамирчид олон хоногийн гүйлтийн өмнө 20—45 хоногийн тусгай бэлтгэл хийжээ. Өртөөчилсөн гүйлтийн явцад хоног тутам нэг тамирчин дунджаар 25—50 км зайд 2,8—3,3 м/сек-ийн хурдтай туулж байлаа.

Бид эмнэлэг хяналтын үзлэгээ олон хоногийн гүйлтийн туршид бие махбодын ерөнхий хэмжилт, үзүүлэлтэнд тулгуурлан цусны дараалт, судасны лугшилт, амьсгалын тоо, биеийн жинг хэмжих байдлаар хийлээ.

Бидний ажиглалтын зорилго нь холын зайд гүйгчдийн бэлтгэл хангарт, гүйлтийн явцад тамирчдын биеийн байдалд гарч болох өөрчлөлт, цуцалт ядралтаас сэргийлэх боломжийг судлахад эмнэлэг хяналтын үүргийг тодорхой болгоход чиглэгдэв. Ажиглалтыг тодотгох зорилгоор гүйлтэнд оролцоогүй ч аялалд хамтран явсан 21—56 насын 20 хүнд эмнэлгийн үзлэг, хэмжилт хийсэн болно.

Хэмжилт, ажиглалт

1. Судасны лугшилт хүний бие махбодын физиологийн чухал үзүүлэлт, тамирчдын бэлтгэл хангалтын тодорхой хэмжигдэхүүн юм (1.2). Бид судасны лугшилтыг өглөө, оройд тамирчдыг тайван байгаа үед, өдөр 15—25 км зайд гүйсний дараа хэмжиж байв.

Бидний ажиглалтаар өглөө нойрноос сэргээн тамирчдын судасны лугшилт минутанд 50—60, орой амралт, усан сэргээлтийн хойно минутанд 60—64, биеийн их ачааллын үед (15—25 км гүйсэн) 130—210 байв.

Гэтэл биеийн тамираар хичээллэдэггүй хүмүүст судасны лугшилт өглөө, оройд адил 72—80 байлаа.

2. Артерийн даралт. Тамирчдад биеийн ачаалал тохирсон бэлтгэл хамасан, зөв дасгалжсан тохиолдолд зах хязгаарын судасны эсэргүүцэл багассантай холбогдон arterийн даралт буурдаг (1.2). Бидний хэмжиж буй тамирчдын arterийн даралт дунджаар өглөө 90/60 муб, орой 110/70 муб, өдөр их ачааллын үед 130/90—170/90 муб хүрч байв. Харин харьцуулсан хяналтын хүмүүсийн даралт тогтмол 120/80—130/90 муб байлаа.

3. Амьсгал. Өглөө, оройд тамирчдын амьсгал минутад 14—17, өдөр их ачааллын үед 30—60 болж байсан ба энгийн хүмүүст амьсгал минутад 18—20 байв.

4. Зовиур. Гүйлтийн явцад шөрмөс татах, булчин зангирах, толгой эргэх, толгой өвдөх, дотор давчдах, амьсгаадах, тавхай, өсгий өвдөх, ходоод цанхайх, суулгах зэрэг зовиур ажиглагддаг.

Эдгээр зовиур нь гүйлтийн үед кальци, фосфор, магни, кали зэрэг эрдсийн бодисын хэрэгцээ, шаардлага нэмэгдэхийн зэрэгцээ тэдгээр бодис хөлсөөр дамжин алдагдах нь эрс ихэсдэг (4) зэргээс болж цусны даралт, судасны лугшилт, амьсгал зэрэг физиологын гол үзүүлэлтуүдэд өөрчлөлт явагддаг.

Жишээ нь: Тамирчин М. 29 настай, эрэгтэй, спортын I зэрэгтэй. Спортоор 10 гаруй жил хичээллэж байгаа. Зовиур шаналгаагүй, бодит үзлэгээр эмгэг өөрчлөлт илрэхгүй байсан боловч гүйлтийн эхний хоногт өглөө тайван үед судасны лугшилт минутад 72—80, а/д 120/80—130/90 муб, амьсгал минутад 16—18 байсан бөгөөд гүйлтийн үед их хөлөрч, З дахь хоногт өглөө гүйж эхлэнгүүт (7 орчим минут) хүйтэн хөлс асгарч, дотор давчдан, толгой эргэх зовиуртай байв. Бодит үзлэгээр: арьс салст цайвар, их хөлөрсөн, зүрхний авиа тод жигд, түргэссэн. а/д 120/80 муб, судасны лугшилт минутад 216, уушги жигд цулшангийн амьсгалтай, амьсгал минутад 60, хоёр шилбэндээ бага зэрэг хавантай байв.

Тамирчныг амрааж, зүрхний булчингийн үйл ажиллагааг дэмжих болон ерөнхий тамир тэнхээ нэмэх эм уулгаж, хоол ундны харьцаа. ачааллын хэмжээг тохируулсны дараа (3—4 хоног) хэвийн байдалд эргэн орж олон хоногийн гүйлтийг дуустал дахин зовиур илрээгүй болно. Гүйлтийн явцад үүнтэй төстэй тохиолдол хэд хэд ажиглагддаг. Ер нь их цуцах гол шалтгаан нь хөдөлгөөний болон дотоод эрхтний хэвийн үйл ажиллагаа түр хугацаанд алдагдахаар тайлбарлагддаг.

Тамирчин С. 28 настай, эрэгтэй. Спортын II зэрэгтэй. Биеийн тамир спортоор II жил хичээллэсэн. Оройн үзлэгээр зовиур шаналгаагүй, арьс салст цайвар ягаан, өөхөн эд, булчингийн хөгжил сайн, үе мөчний хөдөлгөөн хэвийн, зүрхний авиа тод, жигд бус, I минутанд 1—2 ээлжийн бус агшилт сонсогдоно. Зүрхэнд шуугиангүй. а/д 130/90 муб, судасны лугшилт 96, хүчдэл дүүрэлт сайн, ушги цулцангийн амьсгалтай, хэржигнүүргүй, амьсгал минутад 18, хэвийн зөвлөн, хөндуургүй, элэг дэлүү тэмтрэгдэхгүй. Мэдрэлийн эрхтэний талаас эмгэг өөрчдөлт илрээгүй. Дараа өдрийн өглөөний үзлэгээр: зовиур шаналгаагүй. Зүрхний авиа тод, жигд, шуугиангүй. а/д 110/70 муб, судасны лугшилт минутанд 68, амьсгал 16, байсан ба багийн бүрэлдэхүүнд оруулан 20 км явуулахад а/д 120/80 муб, судасны лугшилт 72, амьсгал 24, зүрхний цохилт жигд бус болж I минутанд 2—3 удаа ээлжийн бус агшилт сонсогдож байв. З хоног амрааж, эмчилгээ хоорол тэжээлийн сэргээлт хийсний дараа өглөөний үзлэгээр зовиур шаналгаагүй байв. а/д 120/80 муб, судасны лугшилт 72, амьсгал 18 ба зүрхний авиа тод, жигд байв. Мөн багийн бүрэлдэхүүнд оруулан бага хурдтайгаар 10 км гүйлгээд үзэхэд а/д 140/100 муб, судасны лугшилт 76, амьсгал 24 уд/мин болж зүрхний авиа тод, жигд, шуугиангүй байв. Уг тамирчин нийт 25 км гүйсний дараа толгой өвдөнө, хамар битүүрнэ гэж зовиурлав. Тэр үед а/д 140/100 муб, судасны лугшилт 64 удаа/мин, амьсгал 18 уд/мин, зүрхний авиа тод, жигд бус, агшилт сонсогдож байлаа.

Уг тамирчныг цаашид гүйлтэнд оролцуулаагүй болно. Ийм тохиолдол, өөр нэг тамирчинд ажиглагдсан боловч тодорхой хугацааны амралт, сэргээлтийн дараа хэвийн байдалдаа эргэн оров. Эдгээр жишээнээс тамирчин бүрт бэлтгэл сургуулийн явцад шаардлагатай бүх шинжилгээ, үзлэгүүдийг хийж байх хэрэгтэй болох нь тодорхой байна.

Дүгнэлт. Бидний ажиглалтаас үзэхэд зөв дасгалжсан тамирчдад артерийн даралт тайван үед 90/60, 100/60 муб, судасны лугшилт 50—60 уд/мин, амьсгал 14—16 уд/миний байхад дасгалжаагүй хүмүүст артерийн даралт 120/80 муб, судасны лугшилт 72—80 уд/мин, амьсгал 18—20 уд/мин байна.

Бүх төрлийн спортын уралдаан тэмцээнд оролцох тамирчдын бэлтгэл сургуулилтанд эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд дасгалжуулагчидтай хамтран ажиллах нь тамирчны спортын амжилтанд нөлөөлөхөөс (1) гадна тэдний эрүүл мэндийг хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэх болно.

Олон хоногийн гүйлтийн явцад тамирчдын амралт усан сэргэлтийн дэмжлэг, хоорол тэжээлийн талаар улам нарийвчилсан судалгаа явуулах шаардлагатай юм.

Нийтийг хамарсан урт, богино хугацааны хол, ойрын аялал, бусад спортын тамирын уралдаан тэмцээнд оролцогчдын эрүүл мэндийн байдлыг тодорхойлж, уралдаан тэмцээний явцад зарим лабораторийн шинжилгээ хийх зайлшгүй шаардлагатай болох нь судалгаанаас харагдаж байна.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. А. А. Бутченко, М. С. Кушаковский, Н. Б. Журавлева — „Дистрофия миокарда у спортсменов“ М. 1980
2. Р. Сваншивили — „Некоторые методы функционального исследования спортсменов“. Тбилиси 1984.
3. Э. Донгиндзоо — „Спортын физиологийн онцлогууд“ УБ. 1969.
4. Ш. Чадраабал — „Тамирчдын хоолны найрлагын тохироэны асуудалд“ „Анагаах ухаан“ 1984. №1. 42—44

НЕКОТОРЫЕ НАБЛЮДЕНИЯ МЕДИЦИНСКОГО КОНТРОЛЯ БЕГУНОВ ДЛИННЫХ ДИСТАНЦИЙ

С. Раднабазар

Проведено врачебно-контрольное наблюдение у 21 бегуна в возрасте 19—44 лет дистанцию 1275 км. В сутки они пробежали дистанцию в 35—30 км со скоростью 2,8—3,3 м/сек.

Наблюдение показало, что утром у бегунов пульс 50—60 удар/мин, артериальное давление 90/60 мм.рт.ст. дыхание 14—17 раз/мин, в пике нагрузки соответственно 130—210 уд/мин, 130/90—170/90 мм.рт.ст. 30—60 раз/мин, вечером соответственно 60—64 уд/мин, А/Д 110/70 мм.рт.ст., дыхание 14—17 раз/мин. А также был сделан сравнительный анализ режима питания, физического восстановления и жажды. С объективными данными. Результат наблюдения показывает что у тренированных бегунов в покое отмечалось А/Д 90/60—100/60 мм.рт.ст. пульс 50—60 удар/мин, дыхание 14—16 раз/мин, а у не тренированных А/Д 120/80 мм.рт.ст. пульс 72—80 уд/мин, дыхание 18—20 раз мин.

Редакцид ирсэн 1985. 10. 11

СЭТГҮҮЛ ҮҮДИЙН 1986 ОНЫ ТЭРГҮҮН БИЧЛЭГИЙН ШАГНАЛ ОЛГОЛОО

Нэгдүгээр шагналыг „Эрүүл мэнд“ сэтгүүлд „Хүний экологийн тухай ойлголт, орчин үеийн шийдвэрлэх асуудлууд“, „Хүний боломж потенциалыг хөгжүүлэх асуудалд“ өгүүлэл бичсэн Анагаах ухааны дээд сургуулийн багш А. Дамдинсүрэн, „Анагаах ухаан“ сэтгүүлд „Анагаах ухааны эрдэм шинжилгээний ажлын байдал, цаашдын зорилт“ тэргүүн өгүүлэл, „Оюуны хөдөлмөрийн хүмүүсийн Физиологийн зарим үзүүлэлт ба биологийн хэмнэл“ судалгааны өгүүлэл бичсэн Эрүүлийг хамгаалах Яамны ажилтан Б. Лхагва нарт;

Хоёрдугаар шагналыг „Эрүүл мэнд“ сэтгүүлд „Анд нөхдийн дунд зэрэг тэмдэглэл бичиж, Хүн, гэр бүл, хамт олон“ цуврал орчуулга хийсэн ЭХНР-ийн утга зохиолын ажилтан Г. Цэрэнжигмэд; „Анагаах ухаан“ сэтгүүлд „Оношийн үнэний асуудал, оношлогооны алдааны танин мэдэхүйн шалтгаан“ өгүүлэл бичиж зарим орчуулга хийсэн Эрүүл ахуй, халдварт иян судалалын улсын институтийн эрдэм шинжилгээний ажилтан С. Цоодол нарт;

Гуравдугаар шагналыг „Эрүүл мэнд“ сэтгүүлд „Хараа хайлласан ачтан“, „Бригадын бага эмч“ зэрэг сурвалжлага тэмдэглэл бичсэн Хээтийн аймагийн нэгдсэн эмнэлгийн ерөнхий эмч Н. Лувсанжамба, „Анагаах ухаан“ сэтгүүлд „Вирус судалалын аргаар ялган оношлосон цочмог гепатитын үндээн хэлбэрүүдийн клиник биохимийн төрх“ судалгааны өгүүлэл бичиж зарим орчуулга хийсэн Эрүүл ахуй халдварт иян судалалын улсын институтийн эрдэм шинжилгээний ажилтан М. Алтанхүү нарт тус тус олголоо.

ЭМНЭЛГИЙН ХЭВЛЭЛИЙН НЭГДСЭН РЕДАКЦИ

МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨГӨӨ, ЛЕКЦ, ТОЙМ

Т. ДЭЛГЭР (Халдварт өвчнийг анагаах клиникийн эмнэлэг)
Н. ЖАНЦАН, Б БАЙГАЛЬ, (Анагаах ухааны дээд сургууль)

ВИРУСТ ГЕПАТИТ

1970-аад оноос хойш вируст гепатит өвчнийг судлах талаар ЗХУ болон бусад социалист орнуудад ихээхэн амжилт оллоо.

“Австралийн эсрэг төрөгч” ийлдэст гепатитын үүсгэгчтэй шууд холбоотой болох тухай 1964 онд В. Блюмбергийн дэвшүүлсэн таамаглал төгс батлагдаж, В. Блюмберг энэ ажлаараа Нобелийн шагнал хүртсэн юм. Австралийн эсрэг төрөгчийн цэвэр бэлдмэлийг ЗХУ-д анх гарган авч өвчтөний цусанд эсрэг бодисуудыг илрүүлэн тогтоос.

Орчин үед энэхүү эсрэг төрөгч, түүний олон хувилбарыг илрүүлэн тогтоошиноо шинжилгээний нарийн аргуудыг практикт нэвтрүүлэн хүний бие махбод, өвчин үүсгэгч вирус хоёрын харилцан үйлчилгээний нарийн механизмыг зохих төвшинд шийдвэрлэгдээд байна.

Вируст гепатит дэлхийн олон оронд түгээмэл тарж дэлгэрсэн бөгөөд олон хүнийг хамарч өвчлүүлдгийн хувьд томуугийн дараа ордог халдварт өвчин к.м. Вируст гепатитын шалтгаан, эмчилгээ, урьдчилан сэргийлэхтэй холбогдсон олон талт асуудлыг бүрэн төгс шийдвэрлэж чадаагүйгээр үл барам уг өвчин хүндэрэх, элдэв үлдээц тогтох, ойр болон алсын тавилан муу байх, архаг хэлбэрт шилжих зэрэгт нөлөөлөх хүчин зүйл, шалтгаан нөхцөлийг судлах ажил хангальтгүй байна. Ийм учраас вируст гепатит (ВГ) нь зөвхөн халдвартын эмчтөдийгүй анагаах ухааны бусад салбарын эмч мэргэжилтийн анхаарлыг зүй ёсоор татаж байгаа юм. Орчин үед ДЭХБ-ын болон улс орнуудын Эрүүлийг хамгаалах байгууллагын өмнө ВГ-тай тэмцэх асуудал хурцаар тавигдаж байгаа нь:

1. ВГ нь дэлхийн улс орснд өргөн тархсан халдвартай
2. Өвчилсөн хүн удаан хугацаагаар хөдөлмөрийн чадвар алддаг
3. Өвчний ойрлын болон алсын тавитан цөөн биш тохиолдолд муу байдаг.
4. Эрт оношлох оношлогооны өвөрмөц арга хараахан бүрэн төгөлдөржиж чадаагүй
5. Өвөрмөц эмчилгээ байхгүй
6. Найдвартай урьдчилан сэргийлэх өвөрмөц арга сдоогоор олдоогүй зэргээр тодорхойлогдож байна.

ВГ бол зөвхөн хүнд тусдаг, дэлхийн олон улс орносор нэлээд түгээмэл тархсан, гол төлөв хоол хүнсний зүйлээр, мөн арьс салст бүрхүүл гэмтэхэд цусаар дамжин халдврладаг, элэгний ретикулогистиоцит тогтолцоо болон парепхемийг илэрхийгээр гэмтээж ерөнхий хордлогын байдлаар илрэдэг цочмог халдварт өвчин к.м. Зарим судлаачид энэ өвчин агаар дуслын замаар халдан тархдагийг угүйсгэхгүй байна.

Элэгний үрэвсэл үүсэхэд эмнэлзүйн халуурах, шархлах бусад шинжтэмдэг илрэхийн зэрэгцээгээр далд ба шарлахгүй хэлбэр бас цөөнгүй үзэгддэг.

Орчин үед ВГ өвчний үүсгэгч хоорондоо эсрэг төрөгч чанараараа ялгаатай хоёр янзын вирус болох нь вирус судлал ба иммун судалын шинжилгээгээр нэгэнт батлагдсан бөгөөд сүүлийн жилүүдэд

дээрх хоёр төрлийн вирусээс гадна дстроо наад зах нь 2-оос доошгүй хувилбар бүхий "С" бүлгийн вирус бас байдаг ийн нотлогдож байна. Энэ өвчнийг тахалт гепатит, паренхиматоз гепатит, халдварт шар, вируст гепатит, ийлдэст гепатит гэх мэт янз бүрээр нэрлэдэг нь уг өвчнийг нэгдмэл нэг нэр томъёоны дор ойлгоход бэрхшээлтэй болгож байна. Ийм учраас 1953 онд Дэлхийн эрүүлийг хамгаалах байгууллагын экспертийн хороо уг өвчний нэр томъёог шинэчлэн тогтоож ходоод гэдэсний замаар тархдаг нууц үе нь богино, А вирусээр үүсдэг "халдварт гепатит", парентерал замаар дамждаг нууц үе нь урт В вирусээр үүсдэг "ийлдэст гепатит" гэж 2 хэлбэр болгон хувдааж, улмаар 1973 онд уг өвчний нэрийг олсон улсын нэгдсэн нэр томъёонд оруулж өрөнхийд нь вируст гепатит (ВГ) гэж нэрлээд халдварт гепатитыг вируст гепатит А (ВГА) ийлдэст гепатитыг вируст гепатит В (ВГВ) гэж тус тус нэрлэв.

Сүүлийн үед өөрийн шинж чанараар В вирустэй төстэй боловч зөвхөн цус юүлэх үед цусаар дамжин халдвартаж болдог С вирус үүсэгчтэй "А ч биш В ч биш" гепатит гэж бас ялгадаг.

ВГА ба ВГВ гэж ялган оношлох боломжгүй нөүцөлд ВГ гэсэн өрөнхий нэрээр өвчинг нэрлэнэ.

Шалтгаан. ВГА-ийн үүсгэгч вирус нь рибонуклеин хүчил бөгөөд хүрээ өвөрмөц чанартай. Тэр нь 25—28 нм диаметртэй, физик химийн шинж чанараараа энтервирустэй төстэй, халдвартын процессын үед цусны ийлдэс, цэс, ялгадас болон элэгний эсийн цитоплазмд байрласан байна. А вирус нь хүйтэнд тэсвэртэй, 60 градус халаахад 30 минутын дараа идэвхгүйжүүлэгдэнэ. Харин буцалгахад 1 минутын дотор сөнөнө.

Одоо үед А вирус нь хүчтэй эсрэг төрөгчтэй бөгөөд, халдвартын эхний 10 хоногоос эхлэн, халдвартын бүх явцад бие махбодод эсрэг төрөгчийн эсрэг бодис бий болно. Өвчний хурц үед IgM-ийн ангид замарагдах эсрэг бодис үүсдэг бол өвчний 30 дахь хоногоос IgG-анийн эсрэг бодис нэмэгдэж ирнэ. Европ болсон америк тивийн олон оронд хийсэн иммун судлалын шинжилгээнийт хүн амын 40—70 хувьд гепатит А-гийн эсрэг төрөгчийн эсрэг бодис цусанд илэрч байсныг нотолжээ.

ВГВ. ЕГВ үүсгэгч-вирусийн судалгаа нь Австрали тивийн угуул нутгийн хүн амын цусанд шинэ эсрэг төрөгч байхыг олж тогтоосноор эхлэв. Энэхүү эсрэг төрөгчийг "Австрали антиген" гэнэ.

Хожим нь Дейн 1970 онд ВГВ-гийн вирусыг нээж, түүний эсрэг төрөгчийн бүтцийг шинжлээд Блюмбергийн бүр 1964 онд олж нээсэн австрали антиген нь уг вирусын зөвхөн гадна талын буюу гадаргийн липопротеин бүрхүүл байсныг тогтоожээ.

ВГВ үүсгэгч вирус нь нарийн бүтэц, зохион байгуулалттай 42 нм диаметртэй Дейний биенцэр 1 м. Тэр нь 28 нм хэмжээний электрон нягт зүрхэвчтэй, 7 нм зузаан бүрхүүлээр гадна талаараа бүрхэгдсэн, гайрлагандаа хсёр гинжин ороомог бүхий дезокси-рибонуклейн хүчил болон ДНК-полимераз гэгдэх вирусын еөрийн ферменттэй байна.

Одоо үед В вирус нь эсрэг төрөгчийнхөө шинж чанараар хоорондоо ялгагддаг вирус-өвөрмөц З төрлийн эсрэг төрөгч нэмэгджээ, Энэ бол:

1. Гадаргын антиген ($\text{HB}_s\text{-Ag}$). Энэ антиген нь химийн бүтцээрээ липопротеид бөгөөд бие махбодод тэр нь нэвтрэн ороход түүний хариуд нарийн өвөрмөц чанартай эсрэг бодис (анти $\text{HB}_s\text{-ag}$) бий болно. Хурц халдвартын үед $\text{HB}_s\text{-ag}$ нь өвчийн клиник шинж илрэхээс 2—8 долоо хоногийн өмнө 10 тодорхойлогдож байгаад шарлах шинж эхлэснээс хойш 1—3 долоо хоногийн дараа алга болно. Зарим үед өвчин эдгэрснээс хойш ч үргэлжлэн биед хадгалагдаж болно. Гэтэл эсрэг бодис Anti- $\text{HB}_s\text{-ag}$ нь гол төлөв өвчийн дараа үүсч бий болдог

бөгөөд, тэр нь өвчин эдгэрсэн, бие махбодод дархлалт үүссэнийг харуулах үзүүлэлт болно.

2. Цөмийн антиген (HBc-ag). Тэр нь В гепатитын вирусын цөмийн оршдог, нуклеокапсид юм. Халдвартын процессын үед цөмийн антиген Дейнийн биенцрээс гадна бол зөвхөн элэгний гепатоцит эсэнд л олдож болно. Ийм учраас уг антигенийг илрүүлэх шинжилгээг цус, ийлдсэнд хийх шаардлагагүй. Харин халдвартын үед HBc-ag нь өөрийн эсрэг бодис анти HBc-ag их хэмжээгээр үүсгэдэг тул энэхүү эсрэг бодисыг шинжилж, өвчний онош тавихад ашиглана. Хэрэв энэхүү эсрэг бодис анти HBc-ag нь IgM ангид хамарагдах бол ВГВ-ээр өвчилж байна гэж болно. Хэрэв IgG ангийн бол халдварт авч өнгөрсний тэмдэг болно.

3. Халдвартлах чанарын антиген (HBe-ag). Энэ антиген Дейнийн биенцрийн цөмд байрладаг, бүтцэндээ уурагт бодистой. HBe-ag нь цөмийн антигенээс (HBc-ag) ялгагдах тал нь гэвэл HBe-ag нь халдвартын үед цусанд чөлөөт байдлаар юмуу, эсвэл иммуноглобулинтай холбоот байдлаар олддог, цусны халдвартлах чанар буюу цусанд вирус байгааг заагч үзүүлэлт болж өгнө. Харин түүний эсрэг бодис анти HBe-ag нь ийм чанар хадгалдаггүй. Иймд цусанд вирус байгааг заадаг үзүүлэлтийн хувьд HBe-антиген нь гадаргын (HBs-ag) антигений хамт бие махбодод тодорхойлогдвол нэг бол өвчний тавилан муугаар төгсөх, эсвэл өвчин архаг явцтай болсныг гэрчлэх шинж мөн.

Антиген тодорхойлох онош зүйн ач холбогдол. Өвчин үүсгэгчийн антигенуудыг тодорхойлох нь цочмог ВГ-ийг оношлох өвөрмөц арга мөн. В гепатитын үед өвчтөний цусны ийлдсэнд гадаргын (HBs-ag) ба халдвартлах чанарын (HBe-ag) антигенуудыг, А гепатитын үед баас ялгагдсанд А вирусын антигенийг тус тус тодорхойлдог. Тодорхойлж байгаа аргаас шалтгаалж гадаргын антиген (HBs-ag) В гепатитын үед 30—90 хувьд олддог. Уг антиген нь Гелийн тэжээлт орчинд тундасжуулах урвалаар (РПГ) 30—40 хувьд, иммуноэлектрофорез, хавсрата холбох, цус наалдуулах шууд бус урвал зэрэг аргаар 60—70 хувьд, харин радиоиммун судлалын аргаар бол 90 хувьд илрэдэг. Гадаргын антиген илэрсэн тохиолдол бүрийг цочмог В гепатит гэж үзэж болохгүй. Олонх судлаачдын мэдээгээр хүн амын дунд 3—6 хувьд HBs-антиген тээгч эрүүл хүмүүс байдаг.

Өвчтөн юм уу, антиген тээгч эрүүл хүмүүс үү гэдгийг ялган салгахын тулд антиген тодорхойлох шинжилгээг давтан хийж шийдвэрлээнэ. Хэрэв өвчний улмаас антиген илэрсэн бол сүүлчийн шинжилгээгээр тэр нь тодорхойлогдохгүй. Тэрчлэн бусад антиген ба түүний эсрэг бодисыг тодорхойлох замаар ч онош тогтоож болно.

Шинжилгээнд HBs-антигенээс гадна цөмийн антигений эсрэг бодис (Анти HBc-ag) илэрвэл энэ тохиолдолд цочмог В гепатит байжээ гэж үзнэ. Хэрэв В гепатитаар өвчилсөн хүмүүст HBs-ag ерөөс илрэхгүй бол (ийм хүмүүс 10 хувьд байна) өвөрмөц серо урвалыг дараах тактик баримтлан хийнэ.

Үүнд:

1. HBs-ag-г нарийн өвөрмөц аргаар давтан тодорхойлох
2. Цусны ийлдсэнд анти HBs ба анти HBe эсрэг бодисыг илрүүлэх шинжилгээ хийх.

Өвчний эдгэрэлтийн үед Анти-HBs бодис илрэн гарч ирэх юмуу, түүний титрийн өсөлт 4 дахин их болж нэмэгдсэн бол оношийн холбогдолтой гэж үзэх,

3. Анти HBs ба Анти-HBe бодис тодорхойлогдохгүй үед анти HBc бодисыг илрүүлэх шинжилгээ хийх, хэрэв Ig M ангид хамарагдах түүний титр ихэссэн бол тухайн үед цочмог ВГВ-ээр өвчилж байгаа гэж, IgG-ийн анти-HBc бодис ихэссэн бол халдварт аваад өнгөрсөн гэж үзнэ. Энд бас антигенемитэй явагдаж байдаг архаг гепатитыг ялган оношлох явдал гардаг.

Халдварт судлал, А гепатит. Ердийн үед вируст гепатитаар зөвхөн хүн өвчилдөг. Иймд халдвартын эх уурхай нь хүн байна. Өвчний шарлахгүй далд, балархай хэлбэрээр өвчилсөн хүмүүс халдварт тараах хамгийн их асуултай. Өвчний хамгийн халдвартай цаг нь өвчний нууц үеийн сүүлч, шарлахын өмнөх үе км. Шарлах шинж тэмдэг илэрч гарснаас хойш халдвартын аюул эрс багасдаг. Вирус нь өвчний анхны шинж тэмдэг илрэхээс 2—10 хоногийн өмнө цусанд олдож дараа нь шарлаж эхлэхэд цуснаас алга болдог. Хөхний сүүнд вирус ордоггүй тул хөхний сүүгээр халдвартархдаггүй гэж үзэж болно. Халдварт ихэвчлэн амаар, ус, хүнсний бүтээгдэхүүнээр дамжин халдвартана.

Халдварт тараахад бөхир гар, өвчтөний хэрэглэж байсан эд юмс ба-гагүй үүрэгтэй.

Хүн ВГА-аар их өвчлөмтгий чанартай байдаг. Сүүлчийн үед ВГА-г агаар дуслын замаар тархдаг халдварт өвчин гэж ч үздэг ойлголт гарав. ВГА-аар гол төлөв хүүхэд өвчилдөг, өвчний эхний үед амьсгалын замын эрхтэний гэмтлийн шинж их байдаг, уг өвчин богино хугацаанд олон хүнийг хамарч өвчлүүлдэг, гэдэсний халдвартын үед авдаг урьдчилан сэргийлэх арга хэмжээ үр дүн муутай байдаг, эрүүл хүний цусанд А вирусын эсрэг бодис (бүх хүн амын 60—70 хувьд) олонхидоо үүсчихсэн байдаг зэрэг нь ингэж ойлгох үндэс болж байна.

ВГА-гийн халдварт судлалын онцлог.

— 3—15 хүртэлх насын хүүхэд, залуу хүмүүсийн дунд өвчлөл их байдаг.

- Өвчлөл 3—5 жилийн үечлэлтэйгээр ихсэх хандлагатай
- Намар, өвлүүн улиралд ихэсдэг
- Вирус хадгалагч үүсдэггүй
- Өвчилсний дараа биед удаан хугацаагаар дархлал тогтдог ба дахин өвчлөх нь маш ховор
- Гаммаглобулинаар урьдчилан сэргийлэхэд үр дүнтэй байдаг.

В Гепатит. Халдварт тараагч эх уурхай нь вирус хадгалагч хүмүүс, цочмог В гепатитын янз бүрийн хэлбэрээр өвчлөгсөд, мөн вирусын гаралтай архаг гепатиттай хүмүүс юм. Гол төлөв цус сийзвн сэлбэх, мэс засал, шүд, эмэгтэйчүүдийн эмчилгээ, янз бүрийн тариа, урьдчилан сэргийлэх тарилга хийх, шинжилгээ авах үед энтерал бус (парентераль) замаар халдана. Цус, ялангуяа улаан эсийн сэлбэлт нь халдварт тараах асуултай. Эхсээр дамжин урагт халдах боломжтой гэж үздэг тал бий. Удаан хугацаагаар дархлал тогтоно. Сүүлийн үед ВГВ нь энтерал замаар хоол хүнсний зүйлийн хамт вирус орж халдвартарааж байгааг үгүйсгэж байна. Мөн янз бүрийн тарилга мэс засал хийлгээгүй ч гэсэн арьс салст бүрхүүлийн жижиг шархлаагаар халдварт дамжин орж байгааг олон судлаачид мэдээлж, ингэж халдварт дамжих замыг гэр ахуйн хавьтальн зам гэнэ.

ВГВ-гийн халдварт судлалын онцлог.

- Гол төлөв нэг хүртэлх насын хүүхэд, өндөр настан өвчилдөг.
 - тодорхой улиралчлал байхгүй
 - эмч, сувилагч, лаборантууд өвчтөний цустай илүү их ойртож ажилладаг мэргэжлийн хүмүүс өвчлөх нь их
 - өвчлөгчдөөс вирус тээгчид болох нь цөөнгүй
 - гаммаглобулинаар урьдчилан сэргийлэхэд үр дүн гардаггүй.
- А ч биш В ч биш гепатит халдварт судлалын хувьд В гепатиттай төсөөтэй бөгөөд эмнэл зүйн шинж байдлаар дээрх 2 гепатитын дундаж байрыг эзэлдэг.

ВГ-ын клиникийн ангилал.

1965 онд Москва хотноо хуралдсан олон улсын симпозиум хулээн зөвшөөрсөн доорхи ангиллыг баталжээ.

А. Үүсгэгч, халдварт судлалын шинжээр нь:

а) халдварт гепатит

- б) ийлдэст гепатит
- в) вируст гепатит

Б. Эмнэл зүйн илрэлийн байдлаар нь:

- а) Субклиник хэлбэр (клиникийн шинж тэмдэггүй)
- б) клиник хэлбэр (шарлалтат, шарлалтгүй, далд, балархай)

В. Өвчний явцаар нь.

- а) хурц
- б) ужиг 1. цөсний тогтонгошилтой
2. цөсний тогтонгошилгүй

в) архаг

Г. Хүнд хөнгөнөөр нь:

- а) хөнгөн

б) дунд

в) хүнд

Д. Хүндрэлүүд:

- а) элэгний цочмог ба цочмогдуу гепадистрофи
- б) цөсний замын үрэвсэлт өвчнүүд
- в) дахилт ба сэдрэлт

г) бусад

Е. Төгсгөл ба уршиг

- а) үлдэц шинж
- б) гепатитын дараах хам шинж
- в) үйл ажиллагааны гипербилирубинеми
- г) цөсний замын дискинези
- д) холецистит ба холецистохолонгитүүд
- е) архаг гепатитууд
- ж) элэгний цирроз

Эмгэг жам. Одоо хүртэл вируст гепатитын эмгэг жамын асуудал бүрэн судлагдаагүй байна. ЗХУ-ын эрдэмтэн А. Ф. Блюгер ВГ-ийн эмгэг жамын явцыг 7 үед тоймчлон хувааж байна. ҮҮНД:

1. Халдварт нэвтрэн орох ўе
2. Гэдэс ходоодны хана гэмтэх ўе
3. Тунгалгийн булчирхайн үрэвсэх ўе
4. Халдвартын анхны түгэлт буюу вирус цусаар түгэх эхний ўе
5. Цул эрхтэнүүдээр түгээмэл тархах ўе элэг дэлүү зэрэг эрхтэн гэмтэнэ.
6. Халдварт дахин түгэх буюу вирус цусаар дахин бие маходоор тарах
7. Дархлал үүсэх, бие маходо халдвараас чөлөөлөгддэх ўе

А вирус амаар нэвтрэх ороод нэрийн гэдэсний булчирхай эпителийн эс, ханын лимфийн эдэнд тохинож тэндээ үржиж олширно. Энэ ўе нь өвчний нууц хугацаатай тохирч байдаг бэгээд чухамхүү энэ цагаас эхлэн баасаар вирус гадагш ялгаран гарна. Энэ үеийг энтерал ўе гэж нэрлэх ба зөвхөн А гепатит өвөрмөц үзэгдэнэ.

Харин В гепатитын үед бол эмгэг жамын 2-р үеэс эхэлнэ.

Бүрэс тунгалгийн булчирхайд нэвтрэн ороод тэндээ үржинэ. Ялангуяа энэ үед тунгалгийн булчирхайн ретикуляр эсэд өөрчлэлт гарна. Энд х эснүүд үхжиж, уг үхжсэн эсийн уураг нь аутоантиген чанартай болдог. Үүний хариуд бие маходод ретикул эсийн эсрэг бодис (противретикулярые антитела) бий болно. Цаашилбал вирус нь тунгалгийн хоригийг нэвтрэн давж гарсны дараа цусанд орж, улмаар цусны улаан бээмийг гэмтээнэ.

Гэмтсэн цусны улазн бээм нь аутоантиген чанартай болж, улмаар өөрийн эсрэг бодис (противоэритроцитарные антитела) үүсэхэд хүргэнэ. Нийшид эмгэг процесс даамжирахын хэрээр цул эрхтэнүүдээр вирус тэрж, элэг дэлүү илүүтэй гэмтэнэ. Анхандаа элэгний эсийн гепатосит гэмтэл гол тэлэв хоёрдогч өөрчлэлтийн нөлөөнээс болж үүс-

дэг. Энэ үед вирусын гэмтээх шууд нөлөө бага байдаг. Элэгний эс гэмтэхэд юуны түрүүнд эсийн мембранийн чанар ихсэж, эсийн дотор байрлалтай индикатор ферментүүд, тухайлбал трансаминаэзүүд ялангуяа уураг задлах чанартай эсийн лизосомын ферментүүд цус руу шүүрэн гардаг. Иммун тогтолцооны хангатгүй ажиллагаанаас эмгэгийн процесс цаашид ихсэж элэгний өөрийн эс гепатоцит өвчин үүсгэгч вирусээр гэмтээгдэж эхлэнэ. Гэмтлийн хэмжээ, байржад нь хөөр гепатитын үед өөр байдаг. Гол төлөв гэмтэл нь А гепатитын үед элэгний хэсэгхэний захаар, В гепатитын үед бол төвөөр болсон байдаг. Ухжил нь голомтлог, тархмал шинж байдалтайгаас гадна элэгийг нэлэнхүйд нь хамарч болдог.

Элэгний эс гэмтэж үхжихэд бие махбодын иммун эсүүдийн үүрэг их ач холбогдолтой байна. Өвчний ид үед иммун хариу урвалыг зохицуулах үүрэгтэй лимфоцитын Т-супрессор эс сул үйл ажиллагаатай байснаас Т-киллэр эсүүд идэвхжиж элэгний эсийг илүү түргэн үхүүлнэ.

Энэ үед үхэжсэн эсийн уураг өөрийн биед харш антиген чанартай болж бие махбодод үйлчилснээс элэгний эсийг гэмтээх үйлчилгээтэй аутоантителаг үүсгэхэд хүргэнэ. ВГ өвчний хүнд хэлбэр, гепатодистрофийн үед элэгний морфолог хамгийн их өөрчлөгдөж элэгний үйл ажиллагаа бүрэн хямрана. Элэгний хэмжээ, жин ахар богино хугацаа ны дотор багасах элэг „хайлах“ шалтгааныг аутоаллерги, аутоантител үүссэнтэй холбоотой гэж үзэж байна.

Вируст гепатитын үед элэг зонхилон гэмтдэгээс пигментийн соилицоо хамарч билирубин цусанд ихэсч уул өвчний үндсэн шинжийн нэг болох арьс, салст бүрхүүл шарлана. Эрүүл элэг гемоглобини эсийн бүтээгдэхүүнийг хоргүй болгож цэсний хамт гадагш нь ялгаруулан гаргадаг. Цусанд билирубин хэрхэн үүсдэгийг гүйцэд судлаагүй боловч задарсан эритроцитын гемоглобиноос үүсдэг нь батлагдаж байна.

Гемоглобин нь „албаа өнгөрөөсөн“ эритроцитоос үүсдэг нь тодорхой. Насанд хүрсэн хүмүүсийн 100 мл цусанд 15 грамм гемоглобин буюу 5 мл цусанд 750 гр гемоглобин байна. Өдөр бүр 7,5 гр гемоглобин задарч байдаг. 1 гр гемоглобиноос 35 мг билирубин үүсдэг ба хоногт 260 мг буюу 5,1—19 мкмоль/л билирубин үүснэ. Энэ процесс бие махбодын ретикул-эндотелийн эсүүдэд явагдана.

Билирубин нь шууд бус чөлөөтэй-гемobiliрубин, шууд холбоотой холебилирубин гэж 2 янз байдаг. Гемоглобин задарсны дараахан үүссэн гемobiliрубин нь цусанд уурагтай нийлж колloid уусмал байдалтай байна. Гемobiliрубин элгэнд очиж түүний 80 хувь нь глюкуронидтой, 20 хувь нь сульфат давстай нэгдэлд орж шууд билирубин буюу холебилирубынг үүсгэдэг. Энэхүү элгэнд нэгдэлжих урвал явагдсаны эцэст эд эсэнд ихэд хортой зөвхөн тосонд уусдаг шууд бус билирубин нь усанд уусах чанартай бөөрний шүүлтийг нэвтрэн шээсэнд орж чаддаг хор багатай холебилирубин болж хувирна. Билирубины нэг молекул глюкуроны хүчлийн 1 буюу 2 молекултай нэгдэлд орж болох тул моноглюкуронид ба диглюкуронид гэж ялгана. Цөсөөр гадагш ялгаруулж байгаа пигментийн 75—80 хувь нь диглюкуронид байдаг. Хүний биед хортой гемobiliрубини хоргүйжүүлэх үйл ажиллагаа элгэнд 3 үе шатаар явагдана.

1. Элэгний гепатоцит эс нь цусан дахь гемobiliрубиний тогтоон барьж шүүж авна.

2. Гемobiliрубин элгэнд нэгджих урвалд (конюгаци) орж холебилирубин үүснэ. Энэ процесс элэгний ямар эсэнд явагддагийг нь одоо болтол бүрэн тогтоогоогүй. Элэгний гепатоцит эсэнд энэ ажиллагаа явагддаг гэсэн ойлголт байгаа боловч элэгний нэлэнхи үхжлийн улмаас гепатоцит бүрэн задарч, үхэжсэн үед цусанд холебили-

рубин ихэсдэг шалтгааныг тайлбарлаж болохгүй байна. Сүүлийн үед глискуроны хүчилтэй нэгдэлд орох билирубины ажиллагаа куфериин эсэнд явагддаг гэж үздэг.

3. Элэг бол нэгдэлд орсон холебилирубиныг бие махбодоос залуулах, цэсний хамт гадагш ялгаруулах үндсэн үүргийг гүйцэтгэдэг. Холебилирубин буюу шууд билирубин цэсний хамт гэдсэнд орж тэнд уробилиноген, стеркобилиноген болж задарна. Уробилиноген нарийн гэдэсний дээд хэсэгт хаалган вэнд шимэгдэн дахин элгэнд очно. Тэнд исэлдэх урвалд орж пропентодопент болж эргэж нарийн гэдсэнд очдог. Зөвхөн 1 хувь нь цусанд орж бөөрөөр дамжин шээсээр гадагш ялгаран гарна. Вируст гепатит туссан анхны өдрөөс элэг гэмтэхэд билирубинийг гадагш ялгаруулах элэгний үйл ажиллагаа алдагдаж цусанд шууд билирубин ихэсдэг. Түүнчлэн энэ өвчний эхний үеэс эдгэрэх хүртэл өвчний бүх явцад шээсэнд цэсний пигмент (холебилирубин) олдоно. Харин уробилиноген шээсэнд зөвхөн өвчний эхэн ба эдгэрэлтийн үед гарч ирдэг. Вируст гепатитын холестатик хэлбэрийн үед шаралт үүсэхэд механик хүчин зүйл нөлөөтэй байдаг.

ЭМНЭЛ ЗҮЙ.

ВГ нь үндсэн 3 хэлбэрээр явагдана. Энэ нь эмнэл зүйн тодорхой шинж тэмдгээр илрэх шарлалттай ба шарлалтгүй хэлбэр, эмнэл зүйн ямарч шинж тэмдэггүй зөвхөн цусны энзимиин идэвхийн өөрчлөлтөөр явагдах субк. линик хэлбэр болно.

ВГ-ИЙН ШАРЛАЛТАЙ ХЭЛБЭР

1. А гепатит (халдварт гепатит). Өвчний нууц хугацаа дунджаар 2—6 долоо хоног үргэлжилнэ. Шарлахын өмнөх үе 5—7 хоног байдаг. Энэ хугацаанд эмнэл зүйн олон язнын шинжүүд илэрнэ. Ямар шинж тэмдэг давамгайлан гарч байгаагаас шалтгаалж өвчин эхлэх үед хэд хэдэн хам шинж болгон ялгаж болдог.

Томуу төст хам шинж. Хурц эхэлнэ. 38° ба түүнээс дээш халуурна, толгой булчин өвдөж амьсгалын дээд замын улайх үрэвслийн шинж илэрнэ.

— Хоол боловсруулах замын хямралын шинж. Хоолонд дургүй болох, баруун хавирга доогуур мөн агуулхай орчим унжирч өвдөнө. Бөөлжис цутгах, бөөлжих, суулгах, эсвэл өтгөн хатах, гэдэс дүүрэх, ам гашуун оргих зэрэг шинж тэмдгээр эхэлнэ.

— Мэдрэл сульдалын хам шинж. Бие сурлах, амархан ядрах, тамирдах, хөлрөх, цочромтгой юмуу, эсвэл ноомой болох, нойр хямрах зэрэг шинж үзэгдэнэ.

— Үе мөчний өвдөлт. Гол төлөв том үе мөн яс булчингаар өвдөнө. Өвдөлт хүчтэй биш байдаг. Дээрх шинж тэмдгүүд хавсран ямар нэгэн байдлаар илрэх явдал цөөнгүй. Иймд энэ байдлыг өвчин эхлэлтийн полиморфизм гэх нь ч бий. Бас хааяа өвчтөнд ямар ч шаналгаа зовиур байхгүй, мэдэгдэх шинж илрэхгүйгээр шууд нүд, арьс нь шарлаж эхэлж болно.

А гепатит ихэнхдээ гэдэс хodoодны хямрал юм уу, эсвэл томуу төст шинжээр илрдэг. Өвчний шарлах үе 7—15 хоног үргэлжилнэ. Эхлээд халуурч, бөөлжиж байгаад шээс хүрэн өнгөтэй болж улмаар нэг мэдэхэд нүдний уурагт бүрхэвч шар тяятай болно. Үүний сацуу олонх өвчтөнд шарлахын өмнөх үед ажиглагдаж байсан хордлогын шинж тэмдгүүд багасах юм уу бүрмесен алга болно. Арьс нүдний шар түргэн хугацаанд нэмэгдэж эхний 7—10 хоногийн дотор дээд хэмжээндээ хүрч, хэсэг хугацаа өнгөрсний дараа мөн хурдан багасаж эхлэнэ. Шар өнгө эхлээд салст бүрхэвчинд гарч дараа нь их бие үе мөчөөр ажиглагдана. Шар өнгө арилахдаа ч дээрхийн эсрэг дарааллаар явагдана. Баасны өнгө цайрна. Зүрхний цохилт цөөрнө. Элэг заримдаа дэлүү томроно. Элэгний гадаргуу тэгш, зөөлөвтөр, ялимгүй эмзэг

байдаг. Цусанд цагаан цогцосны тоо цөөрч, УЦТУ хэвийн юмуу удааширсан байна. Өвчний энэ хэлбэр олонх тохиолдолд хөнгөн явцтай байдаг учраас өвчний эдгэрэх үе хурдан эхлэнэ. Энэ үед өвчтөний зориур шаналгаа эмнэл зүйн бусад шинж тэмдгүүд арилж биохимиийн шинжилгээний үзүүлэлтүүд хэвийн болно. Гол төлөв өвчин тавилан сайтай байдаг.

2. В гепатит (ийлдэст гепатит). Нууц хугацаа нь 1,5—6 сар үргэлжилнэ. Шарлахын өмнөх үе нь 10—12 хоног түүнээс ч илүү үргэлжилнэ. Өвчин ихэнхдээ аажим эхлэнэ. Хоол боловсруулах замын хямрал, мэдрэл сульдал, ялангуяа үе мөчний хам шинжүүд шарлахын өмнөх үед А гепатитыг бодвол илүү их тохиолдоно. Өвчтөний 10 орчим хувьд бие загатнах, арьсан дээр тууралт үүснэ. Хордлогын шинж тэмдэг шарлахын өмнөх үед аажим аажмаар нэмэгдэх юм уу, эсвэл сул илэрч шарлалтын үеэс эхлэн нэмэгдэж ирнэ. Шарлах үе нь урт, 2—3 долоо хоногийн дараа щар хамгийн их хэмжээндээ хүрнэ. Зарим өвчтөнд үе мөчөөр нь өвдөж халуурна. Баруун хавирганы доогуур хөндүүрлэнэ. Эдгэрэх үе удаан үргэлжилнэ. В гепатит хүнд хэлбэрээр явагдаж, архаг явцад орох нь элбэг байдаг. Элэгний хурц экцефалопати (ЭХЭ) зөвхөн В гепатитын үед тохиолддог гэж ихэнх судлаачид үзэж байна.

Эмнэл зүйн шинж тэмдгийн илрэл, лабораторийн шинжилгээний үзүүлэлтийг харгалзан ВГ-ийн хүнд, хөнгөн явцыг тогтооно. Эдгээрийн алийн ч гэсэн биеэ даасан ач холбогдолгүй боловч өвчний хүнд хөнгөнийг үнэлэхдээ бие махбодын хордлогын ерөнхий шинж тухайлбал бие сул байх, толгой эргэх, огиулж бөөлжих, нойрмоглох, зан сэтгэхүйд нь өөрчлөлт гарах зэргийг илүү харгалзан үзэх ёстой. Ийм учраас өвчтөний биеийг өвчний анхны өдрөөс эхлэн байнга ажиглаж байх нь чухал.

Хөнгөн хэлбэр. Өвчний хөнгөн хэлбэрийн үед хордлогийн шинж үл ялих тодрох буюу, эсвэл огт илрэхгүй ч байна. Биеийн арьс салслагын шар бага, элэг ялимгүй томорсон байж болно. Цусан дахь билирубины хэмжээ 85 мкмоль/л-ээс доош, аминотрансферазын идэвх хэвийн хэмжээнээс 2—4 дахин нэмэгдэнэ. Протромбин ба сулемагийн сорил хэвийн. Энэ хэлбэр 2—3 долоо хоног үргэлжилнэ. Хүндрэхгүй, өвчин ужиг болох нь ч ховор.

Дунд хэлбэр. Энэ хэлбэрт биеийн хордлогын шинж тод илэрч хоолонд дургүй болох, огиулах, бөөлжис цутгах, толгой өвдөх, аюулхайгаа хөндүүрлэнэ. Биеийн арьс салслагын шар тод, элэг нь томорсон байна. Заримдаа хамраас цус гарах, бие загатнах, 38°—38,5° хүртэл халуурч болно. Нойр гажуудах, бие сулрах нь энэ үед цөөнгүй байдаг. Судасны лугшилт удааширч, зүрхний авиа бүдгэрэх, arterийн даралт буурахын зэрэгцээ цусны улаан, цагаан эсийн тоо цөөрч, эозинофил, лимфоцитын тоо олширч эхлэнэ. Цусан дахь билирубины хэмжээ 170 мкмоль/л хүртэл нэмэгдэж, трансаминазын идэвх хэвийн хэмжээнээс 3—5 дахин, түүнээс ч дээш ихсэнэ. АлАТ 5,5—6 мкмоль/ч, л, АсАТ 3,5—4 мкмоль/ч, л. Протромбин бага зэрэг багасч, сулема 1,5 мл хүртэл буурна. Өвчний энэ хэлбэр дунджаар 5—6 долоо хоног, шар нь ойролцоогоор 30 хоног үргэлжилнэ.

Хүнд хэлбэр. Хүнд хэлбэрийн үед илрэх үндсэн шинж бол хордлого мөн. Энэ үед элэгний эд эсийн ухжил явагдаж бусад эрхтэн систем, ялангуяа төв мэдрэлийн системийн хордлого үүсдэг учраас юуны өмнө энэ хордлогын шинж тод байна. Шар илрэхийн өмнөх үед бий болсон шинж тэмдгүүд хоолонд дургүй болох, бөөлжис цутгах, ядрах, залхуу хүрэх нь намдахгүйгээр барахгүй шарлалтын үед улам нэмэгдэнэ. Халуурч хамраас цус гарах шинж нэмэгдэнэ. Өвчний эхний өдөрөөс өвчтөн сул, нойрмог байхаас гадна шар маш ихтэйгээс арьс улаавтар шар, түүний нугалаануудад жижигхэн цус харвалтууд гарсан

байна. Гэхдээ хүнд үед арьсны шар заавал их байх албагүй. Мөн толгой эргэх ба өвдөх, өдөр нойрмоглож шөнө унтахгүй байх, өвчтөн цочромтгой болох зэрэг шинж үзэгдэнэ. Энэ үед судасны цохилт олширч хэл өнгөртөнө. Элэг томрохгүй. Зарим үед томорсон элэг багасах, тэмтрэхэд тэр нь зөөлөн, хөндүүрлэнэ. Энэ үеэс шээсний гарц мэдэгдэхүйц ховорддог. Шар ихтэй, хордлогын шинж тод илэрсэн мөртөө элэг бага байх нь өвчин хүндэрч болохын дохио мөн. Хүнд үед билирубины хэмжээ 171—342 мкмоль/л-ээс илүү, протромбины индекс багасаж, сулема 1,2—0,9 мл хүртэл буурна. Өвчний хүнд хэлбэр дунджаар 45—50-иас дээш хоног үргэлжилнэ. Трансаминазын идэвх АлАТ 6—7 ммоль/ч. л, АсАТ 4,5—5 ммоль/ч. л өндөр байна. Цаашид элэгний үйл ажиллагааны хурц дутагдал эхэлбэл энэ хэмжээ хурдан багасаж ирнэ. Өвчний 6—7 дахь долоо хоногоос шар арилж, шар буурахын хэрээр элэгний хэмжээ аажмаар хэвийн байдалд орно.

ВИРУСТ ГЕПАТИТЫН ГАЖ ХЭЛБЭРҮҮД

1. **Шарлалтгүй хэлбэр.** ВГ-ийн шарлалтгүй хэлбэрээр хүүхэд олондоо өвчилнө. Шарлахгүй, билирубины хэмжээ ихсэхгүй, өтгөн шээсний өнгө хэвийн байдгаараа энэ өвчин шарлалттай хэлбэрээс ялгаатай.

2. **Балархай хэлбэр.** Эмнэл зүйн шинж тэмдгүүд нь маш бүдэг илэрдэг тул практикт бараг оношлогдоггүй боловч халдвартараах акултай. Биохимиин шинжилгээний үзүүлэлтүүд өөрчлөгдэх трансаминазын идэвх ихэссэн байдаг. Мөн халдварт судлалын мэдүүлэг онош тавихад тусална.

3. **Шинж тэмдэггүй хэлбэр.** Эмнэл зүйн ямар ч шинж тэмдэг илрэхгүй. ВГ гарсан голомтонд биохимиин шинжилгээ хийж энэ хэлбэрэйг илрүүлдэг.

4. **Эрүүл антиген тээгч.** Эмнэл зүйн шинж тэмдэг, биохимиийн шинжилгээний өөрчлөлтгүй. Зөвхөн цусанд HBsAg илэрсэн, иммун шинжилгээний бусад өөрчлөлттэй байна. Ийм хүмүүс донор байж болохгүй.

5. **Цөсний сувгийн үрэвсэлт (холангидиг) хэлбэр.** Гол төлөв залуу хүмүүст тохиолдоно. Шарлахын өмнөх үед халуурах, туурах, үе мөч өвдөх, загатнах шинжүүд ажиглагдана. Шар ихтэй, явц удаан (2—4 сар). Элэг том, хөндүүр байна. Цусанд цагаан эс олширч улаан эсийн тухаа урвал (УЭТУ) түргэснэ. Аминотрансферазын идэвх бага зэрэг ихэссэн байна.

6. **Цөс зогсонгишсон хэлбэр.** Ихэвчлэн настай хүмүүст тохиолдоно. Ерөнхий хордлогын шинж тэмдэг сул илэрсэн юм уу огт байхгүй байхад шар их хэмжээтэй удаан хугацаагаар үргэлжлэх, бие загатнах, цусанд билирубин, холестерин, беталипопротеидын хэмжээ их, шүүлтлэг фосфатазын идэвх өндөр байх онцлогтой. Явц нь ужиг. Харин элэг томрохгүй, трансаминазын идэвх ихэнхдээ хэвийн байдгаараа холангидиг хэлбэрээс ялгагдана.

Зарим хүмүүст тохиолдох ВГ-ийн онцлог.

1. **Настай хүнд тохиолдох ВГ** нь аажим эхлэнэ. Удаан явцтай. Шарлахын өмнөх үед хоол боловсруулах замын үйл ажиллагааны хямралын шинж илүүтэй үзэгдэнэ. Шарлах үе урт, элэг удаан агшина. Механик шарлалттай төстэйгээр цөс зогсонгишилтой явагдах онцлогтой. Цөсний суваг ба хүүдий, нойрын булчирхай, ходоодны үрэвсэл зэрэг бусад архаг өвчний сэдрээх нь олонтоо байдаг.

2. **Жирэмсэн үед** ВГ-ээр өвчлөх нь гол төлөв В гепатит байна. Жирэмслэлт нь ВГ-ын явцад муугаар нөлөөлж хүндрэл үүсгэж болохад гадна өвчин ужирах, архагшигад дөхөм үзүүлнэ. Төрөлхийн үйл ажиллагааны сурал үүсэх, цус алдах зэрэг төрөхийн хүндрэл тохиолддог. Хүнд явцтай үед жирэмслэлтийг таслан зөгсоох үйлдэл өвчинг хүндрүүлэх хүчин зүйл болно.

3. Хүүхдэд тохиолдох ВГ-ийн явц. ВГ нь ямар ч насын хүүхдийг өвчлүүлэх боловч 3-аас дээш насын хүүхдийн дунд илүүтэй байна. Нэг нас хүртэлж хүүхдэд ихэнхдээ В гепатитээр өвчилдэг. Ийм учраас өвчний хүндрэл ихтэй байдаг. ВГ хүүхдэд тусахдаа зарим онцлогтой байна.

— Шарлахын өмнөх үеийн шинж тэмдэг бүдэг, ихэвчлэн хоолонд дургүй болох, хөхнөөс гарах юмуу хөхөө барьж тавиад байх, огиулах, бөөлжих, уцаарлах, ноомой болох, түрүүлгээ харж хэвтэх гэж оролдох, гэдээ дарж уйлах, суулгах, нойр нь муудах зэрэг шинжүүд ажиглагдана. Үүнээс гадна ханиад томуугийн шинжээр эхлэх нь ч цөөнгүй байдаг. Шарлахын өмнөх үеийн үргэлжлэх хугацаа түргэн байна.

— Цусан дахь билирубины хэмжээ их байхад арьс, нүүрний шар тийм ч тод биш мэт ажиглагддаг.

— Элэг нь насанд хүрсэн хүмүүсийг бодвол илүү том болж, удаан хугацаагаар хэвийн хэмжээнд орохгүй, хүндрэл үүсэх үед ч гэсэн эзэг тэр бүр багасахгүй байдаг.

— Дэлүү том болох нь илүү.

— Хүнд явцтай, хүндрэл үүсэх нь элбэг.

4. Хорт хэлбэрийн ВГ. В гепатитаар өвчилсөн зарим тохиолдолд өвчин анхны өдрөөс хүнд байж дороо хүндрэх явдал тохиолдоно. Энэ үед ТМС-ийн хордлого илэрч, хүүхэд цочромтгой болж хөдөлгөөн нь нэмэгдэх, унтах эхэлснээ гэнэт уйлж босч ирэх, гулгиж бөөлжиж эхлэнэ. Цаашид биеийн халуун ихсэж татах шинж ажиглагдана. Гар хөлөө савчих, тайван биш болох мөн гэдээс дүүрнэ. Элэг төдийлөн том биш шар заавал их байх албагүй. Хөөрлийн байдал удахгүй намдаж, хүүхэд хөдөлгөөнгүй унтаа болж гадны цочролыг мэдэхээ болино. Тарилга хийхэд зөвхөн орилж хашгирна. Хүүхэн хараа нарийсч, гэрлийн урвал суларна. Татах нь нэмэгдэж, иусархагийн хам шинж илэрнэ. Зүрхний цохилт олширч амьсгаадна. Элэг зөвлөх к муу хэмжээ нь багасаад тэмтрэгдэхгүй болж 1—3 хоногийн дотор гүн оврогын байдалд орж нас бардаг. Заримдаа хөөрлийн тодорхой шинжүүд тод илэрч амжилгүй шууд гүн овортод орох явдал байдаг. Биохимиин шинжилгээнд билирубин-ферментийн зөрөө тод ажиглагдаж сулема буурна.

Хүндрэл. ВГ-ийн үед дараах хүндрэл тохиолдоно. Үүнд:

— Элэгний хурц энцефалопати (ЭХЭ)

— Хаван үсжилтын хам шинжит хэлбэр

— Цөс ялгаруулах замын үрэвсэл зэрэг хамаарна.

Элэгний хурц энцефалопати нь ВГ-ийн акултай хүндрэлийн нэг юм. Элэгний хурц энцефалопати-ээр хүндрэхэд нөлөөлөх зарим хүчин зүйлс байдаг. Үүнд:

— жирэмсэн, хөхүүл үе, шилжилтийн насанд бие махбодод гарсан физиологийн өөрчлөлт

— өвчлөхийн өмнө ба өвчин туссан үедээ элгэнд хортой нөлөө бүхий эм хэрэглэсэн байх.

— үйлдвэр, ахуйн хорт нөхцөл

— архаг архидалт юм уу өвчлөхийн өмнө архи уух

— хурц хоол хэрэглэх

— өвчлөхийн өмнө биеийн тамирын хүнд дасгал, сургууль хийх, уралдаан тэмцээнд орох, биеийн хүнд хүчир ажил хийх, даарч хөрөх

— санаа сэтгэлийн хямрал дарамттай байх

— халдварт өвчинөөр өвчлөх

— зүрх судас, уушги, бөөр, хоол болоесруулах замын архаг өвчинөөр өвчлөх,

Эмнэл эзүй. Элэгний хурц энцефалопати-ийн яєцыг 4 үе бүх у зэрэг болгын хуваана. 1 зэрэг (оврогын урьдалын 1-р үе). Энэ үед ВГ-ийн хүнд ягцад илрэх шинж тэмдгийн зэрэгцээгээр сэтгэхүйн тогтвортгүй.

тэл болж мнаас айж цочих, сэтгэлийн гутралд орох юм уу эсвэл тэл болж мнаас айж цочих, сэтгэлийн гутралд орох юм уу эсвэл хөөрлийн байдал ажиглагдана, заримдаа уйламтгай болох, эвщээх, са- хын алдах, хөлрөх, толгой эргэх, нойрны хэм алдагдах, зүрх дэл- наа алдах, хөлрөх, толгой эргэх, нойрны хэм алдагдах, зүрх дэл- сэж, дотор бачимдах, гар салганах, элэгний орчим өвдөх зэрэг шинж байдал илэрч шар улам нэмэгдэн элэгний хэмжээ багасна. „Элэгний үнэр“ ханхлана. Шинжилгээ хийхэд цусанд цагаан эс олширч билиру- бины хэмжээ ихэссээр атал ферментийн идэвх буурах хандлагатай бол- но.
Альбумин, беталипопротейд, фибриноген багасч протромбины заалт, су- лема буурна.

лема буурна.
Исаев (сврғынын үрділдік 2-р уе). Ухаан ғаларттан орон зайды.

II зэрэг (оврогын урьдалын 2-р ўе). Ухаан балартай оршиж, цаг хугацааны баримжаа алдагдана. Асуултанд хариулж чадахгүй юм уу буруу, эсвэл нэг л янзаар хариулна. Нэг ўе хөөрлийн байдалтай байснаа гүн сааталд орно. Йе ўе өвчтөн ороосоо босон харайж хашгичин орилж чарлана. Энэ уед ажиглагдах өөр иэг шинж бол „гарын дэвэх салгалалт“ юм. Өвчтөний нүдийг аниулж байгаад 2 гарыг нь урагш сунгуулж, шуу сарвууны үеэр нугалуулан хуруунуудыг нь сарвайлгахад шувуу далавчaa дэвэх мэт хөдөлгөөн хийдэг. Шөрмөсний рефлекс ихсэнэ. Элэгний хэмжээ улам багасна. Шинжилгээнд билирубин-ферментийн зөрөө тод илрэнэ. Альбумин, протромбины заалт, сулема эрс буурч шээний хэмжээ багасдаг.

III зэрэг (оврогын 1-р үе). Ухаан алдана. Тарилга хийх зэрэг хүчтэй цочролд зөвхөн ёлох байдлаар хариулдаг. Үе ўе ёолж хашгирна, ўе мөчний булчингийн хүчдэл ихсэж эмгэг рефлексүүд бий болдог. Хүүхэн хараа нарийсдаг, зүрхний цохилт эрс олширч судасны дүүрэлт багасдаг. Хамар, хоол боловсруулах эрхтэний замаас цус алдах, арьс салстад цусан харвалт үүсэх нь олонтоо. Бор хүрэн өнгийн зүйлээр бөөлжинө. Цус алдалт нь ЭХЭ-ийн үед өвчтөн нас бараг гол шалтгааны нэг болдог. Элэгний хэмжээ улам багасна. Өвчтөн дордоо бие засна. Шинжилгээнд дээр дурдсан өөрчлөлтийн зэрэгцээгээр бодисын солилцооны хямралын шинж (ялангуяа үлдэгдэл азотаммиак ихсэх) гарна.

аммиак илсэх) гарна.

IV зэрэг (оврогын 2-р үе). Өвчтөн ямарч цочролд хариулт өгөхгүй, хүүхэн хараа өргөсч рефлексүүд суларсаар бүр үгүй болдог. Амьсгал гүнзгий шуугиантай (кусмаульн амьсгал) болж, зүрхний цохилт эрс түргэсч, судасны дүүрэлт суларсаар мэдэгдэх төдий болно. Тархи уушги хавагналтын шинж гарч өвчтөн нас гарна.

СЭЛРЭЛТ БА ДАХИЛТ

Эмгэг процесс бүрмөсөн дуусаагүй боловч эдгэрэлтийн үе эхэлсний дараа хурц үеийн эмнэл зүй, биохимийн шинжүүд дахин гарч ирэхийг сэдрэлт гэнэ. Эмнэл зүй биохимийн бүрэн эдгэрэлтээс хойш ямар нэгэн хугацааны дараа хурц үеийн шинжүүд давтан илэрвэл дахилт гэж үздэг. Хоолны болон ажил хөдөлмөрийн дэглэм зөрчих, сэтгэл санааны хурц хямралд орох, өөр өвчинеөр өвчлөх үм уу архаг өвчин хурцдах, удаан хугацаагаар гормон хэрэглэсэн, архи уусан үед ВГ сэдрэж, дахиж, түүнд нөлөөлөх шалтгаан болно.

ВИРУСТ ГЕПАТИТЫН ТӨГСГӨЛ (ТАВИЛАН)

1. Эдгэрэлт. Ихэнх өвчтөн эмнэлгээс гарсны дараа, эхний хэдэн сар жилийн дотор бүрэн эдгэрнэ.
 2. Улдэц шинж.
 - а) Ужиг эдгэрэлт (3 сар хүртэл) энэ үед ферментийн идэвх ба-га зэрэг их, тимол өндөр байх ба зарим зовиур, өвчний шинж тэмдэг ажиглагдаж болно.
 - б) Элэг том байх. Өвчтөнд зовиур щаналгаа байхгүй, биохимиин шинжилгээний үзүүлэлт хэвийн байна. Тэмтрэхэд элэг ерийн хэмжээ-нээсээ том, хатуу биш байна.

в) Билирубины хэмжээ, их байх. Зарим өвчтөнд эмнэлгээс гарсан дараа хэсэг хугацаанд билирубини шууд бүлэг давамгайлж нийт билирубини хэмжээ их хувеэр байдаг. Энэ үед мэдэгдэх өвчиний өөр шинж тэмдэг байхгүй.

3. Удаан хугацаагаар ургэлжлэн явагдах эмгэг.

3. Уудайн хугацаанд түүхийн эхийн нийтийн агуулалтадаа
а) Ужигд гепатит. Энэ үед идэвхтэй процесс 3—6 сар үргэлжил-
нэ. Элгэний хэмжээ том, аминотрансферазын идэвх өндөр байна. Энэ
нь ихэнх дээз эдгэрэх боловч заримдаа архаг гепатитад шилжинэ.

б) HBsAg үргэлжлэн илрэх. В гепатитын дараа ажиглагдана. Эмнэл зүй биохимийн өөрчлөлт гарахгүй. Зөвхөн цуснаас HBs Ag удаан хугацаагаар олдсоор байна.

б) Идэвхгүй архаг гепатит. Вируст гепатитаар б сараас доошинаар хугацаа гар өвчилсөн үед онöшлгэдээ. Эмнэл зүйн өөрчлөлт их биш, биохимийн шинжилгээнүүдэд бага зэргийн өөрчлөлттэй байна. Тавидан сайн, элэгний хатуурал үүсэхгүй.

г) Архаг идэвхтэй гепатит. Энэ нь хэдийгээр цөөн тохиолдох боловч хүнд явцтай тавилан муутай юм. Цаашдаа элэгний хатуурал үүснэ. Үүнийг сүүлийн үед системийн өвчин гэж үзэх явдал бий. Эмнэл зүйн хувьд мэдрэл сульдалын, ходоод гэдэсний хямралын шинжээс гадна алга улайлх „судсан цацраг“ тууралт гарах нь элбэг. Үе мөч өвдөх, туурах, халуурах, дэлүү томрох нь энэ хэлбэрийн онцлог шинж юм. Биохимийн шинжилгээнд аминотрансферазын идэвх тогтмол сондер байх ба альбумин багасаж гаммаглобулин ихэснэ. Тундаст сорилууд эрс өөрчлөгднө.

(Үргэлжлэл нь дараагийн дугаарт.)

Редакцийн ирсэн 1986. 05.31.

П. НЯМДАВАА (Эрүүл ахуй, халдвэр, нян судлалын улсын институт)

ДАРХЛАЛЫН ОЛДМОЛ ДУТЛЫН ХАМШИНЖ

Идэр насны гомосекс (ижил хүйсийн хүнтэй хурьцах гаж арацшинтай) эрчүүдийн эсийн дархлал ихэд суларснаас болзолт эмгэг төрөх чадвартай зарим эгэл биетэн, мөөгөнцөр, вирусын түгээмэл (генерализированный) халдвэр, зарим хорт хавдраар үхлүүт өвчилсан тохиолдлыг 1981 онд америкийн хэсэг эмч нар бичсэн (19, 20, 23) нь дархлалын олдмол дутлын хамшинж (Acquired immunodeficiency syndrome—AIDS синдром приобретенного иммунодефицита—СПИД) нэр авчээ.

Дархлалын олдмол дутлын хамшинж (ДОДХ) нь эмчилгээ муу авдаг учраас онош тавьснаас хойш нэг жилийн дотор өвчтөний 50% нь, хөөр жилийн дотор бараг бүгд нас барж байсан хийгээд халдвартай, 6—8 сар тутам онвшлосон тохиолдол 2 дахин ихэсч байсан тул

тэр дээр АНУ болон барууны өрнүүдэд ихээх эн шуугиан дэгдээсэн юм.

Анх зөвхөн АНУ-д нутагшмал (эндемик) юм шиг байсан энэ эмгэг нь бусад өрөнд ч тохиолддог, зөвхөн бэлгийн замаар бус, мөн нягт хавьтал, цус, цусан бүгээгдэхүүнээр болон эмнэлгийн ажилла-баруудын үед (В гепатиттэй төсгэй замаар) халдвартархаж болох нь цаашдын судалгаагаар илэрхий болсноор дэлхий нийтийн анхаарлыг татах болсон тул ДЭХБ 1983 ондоо эхлэн хэд хэдэн тусгай зөвлөлгөөн, лавлагаа төвүүд зохиол байгуулж, 1983 оны 5 дугаар сард хуралдсан ДЭХБ-ын 39 дүгээр Ассамблейгаас ДЭДХ-той тэмцэх ДЭХБ-ын тусгай программ нээсэн юм (1, 3, 24, 25, 27, 28).

Манай улсын олон талын харьцаа өдөр ирэх тутам өргөжиж буй нөхцөлд манай эмч нар энэхүү „шинэ“ төвөгтэй эмгэгийн тухай тодорхой мэдлэгтэй байх шаардлагатай юм.

1. **Үүсгэгч:** Парис дахи Пастерын институтын хэсэг судлаачид лимфаденопати бүхий өвчтөнөөс 1983 онд ялгаж, лимфэзденопатийн вирус (Lymphadenopathy-associated virus—LAV) гэж нэрлэсэн омог (5), АНУ-ын Хавдар судлалын үндэсний хүрээлэнгийн эрдэмтэд ДОДХ бүхий өвчтөнөөс 1984 онд ялгаж, хүний Т лимфоцитын вирусын 3 дугаар хэвшинж (Himan T-Lymphotropic virus Type-III—HTLVIII) гэж нэрлэсэн омог нь (21) ДОДХ-ыг үүсгэгч нэг вирусын 2 омог гэдгийг одоо нийтээр хүлээн зөвшөөрсөн (1, 4, 6, 22, 25, 26, 31) бөгөөд вирусын таксономын олон улсын хорооноос энэ вирусыг хүний дархлалын дуглын вирус (Himan immunodeficiency virus) гэж нэрлэхээр 1986 онд шийдвэрлэлээ (30). Энэ вирус нь 100 нм орчим хөндлөн огтлолтой бэмбөлөг хэлбэртэй, суперкапсидтай, эсээс нахиалах хэлбэрээр үрждэг, ревертаза фермент агуулдаг, нэг мушгиатай шулуун РНХ агуулдаг зэрэг үндсэн төрхөөрөө ретровирусын овогт хамаарах нь баттай тогтоогдсон боловч чухам аль дэд овог, төрөлд хамааруулахыг бүрэн шийдээгүй байна. Хүний дархлалын дутлын вирус (ХДДВ)-ын ревертаза фермент нь магнийн нөлөөгөөр идэвхждэг, капсидын 2 уураг: ларгагтин, нугагтины эхний 20—30 аминхүчлийн дараалал нь ижил зэргээрээ С хэвшинжийн онковирусын нэг төлөөлөгч болох үхрийн лейкозын вирус (BLV)-тэй төстэй. Гэвч ревертаза фермент нь харьцангуй өндөр молекул жинтэй (100 орчим килодальтон), мөн пролагтийн гэж тэмдэглэдэг пролиноор баялаг фосфоржсон уураг, эсийн гаралтай онкоген агуулдаггүйгээрээ болон капсидын гол уураг ларгагтины эсрэгтөрөгчийн шинжээрээ хүний Т—лимфоцитын вирусын бусад омог HTLV, HTLVII-той илүү төстэй боловч HTLV, HTLVII-нь in vitro нөхцөлд Т-лимфоцитыг хавдрын трансформацид оруулдаг бол ХДДВ нь эс гэмтээх үйлчилгээ үзүүлдгээрээ ялгардаг. ХДДВ нь харьцангуй том (120 килодальтон) суперкапсидын гол полипептид (суренвин)-тэй, тэр нь олон (20 ба дээш) байрлалд сахаржсан, илүү хувьсамхай чанартай зэргээрээ бусад бүх ретровирусээс ялгаатай юм. Харин үржлийн зарим онцлог, нуклеотидын дарааллын гомолог зэргээрээ ХДДВ нь лентивирусын дэд овгийн төлөөлөгчид-тэй илүү ойр байна.

ХДДВ нь туслагч Т лимфоцит (T-helper) бусу ОКТ4 (Лей ЗА) маркертай Т лимфоцитод л үржих чадвартай.

2. Эмгэг жам: ДОДХ үүсэх эмгэгжамын механизмын бүрэн гүйцэд тайлгадаагүй байгаа боловч хүний дархлалын дуглын вирус (ХДДВ) нь туслагч Т—лимфоцитын ОКТ 4 рецепторт бэхлэгдэж, дотор нь орж үржээд эцэст нь хайлуулах тул лимфоцитын Т4 популяци явандаа үгүй бэлсноос эсийн дархлал ажиллагаагүй болж, эсийн дархлалд илүү өртөгдэмтгий бэлзолт эмгэг терөгчид идэвхжсэнээр энэ эмгэг илрэнэ гэж үзэж байна (1, 2, 3). Харин ихэнх тохиолдолд В лимфоцит гэмтэхгүй тул эсрэг бие ялгаруулах чадвар хэвээр байдаг нь

Тун хэмжээ

Даралт бууруулах эмийн тун хэмжээг шилж авахад эмч нараас цөхрөлтгүй оролдлого, эв дүй, тэвчээр шаардана. Бага зэргийн даралт ихсэх үеийн эмчилгээг бага тунгаар эхлэх бөгөөд дараа нь аажмаар үр дүн өгтөл ихэсгэж, аль болохуйц асуул багатай гаж нөлөөгүй хамгийн бага тунгаар удаан хугацаанд эмчлэх нь чухал юм. Зарим даралт бууруулах эмийг их тунгаар хэрэглэхэд тодорхой антерогенность өгдгийг анхаарах хэрэгтэй. Тун хэмжээ ихэсгэх явцыг эмийн түргэн үйлчилгээ, бие махбодиос түүний ялгарч гарах хугацаа хоёрыг харгалзан тогтооно.

Өвчтөнтэй холбоо тогтоох онцлог. Өвчтөний эмчид итгэсэн итгэл, өвчтөн эмч хоёрын хооронд тогтсон сайн харилцаа нь артерийн даралт ихсэх өвчнийг үр дүнтэй эмчлэх урьдчилсан нөхцөл болдог. Ийм холбоо харилцаа тогтоох нь өвчтөний хувийн онцлогоос болж хүндрэлтэй байж болно. Өвчтөн, нэг эмчийн хяналтанд байх нь эмчилгээнд хандах дэс дарааллыг сахихад чухал ач холбогдолтой и.м. Өвчтөндөө эмийн бус эмчилгээ зайлшгүй чухал гэдгийг ойлгуулах нь чухал юм. Гэр орны болон ажилтай уялдан ажил, амрах хэлбэр өөрчлөгдөх тохиолдолд өвчтөн түүнээс татгалзвал ятгаж үнэмшүүлэх эсвэл харилцан бүүлт хийх зэргээр өвчтөнд зөв дэглэм баримтлах боломж олгож байх хэрэгтэй.

Удаан хугацаагаар эмчлүүлэх тохиолдолд, өөрийнх нь өвчний тухай, тодорхой үе шаттай эмчилгээ хийнэ гэдгийг өвчтөнд сайн ойлгуулсан байх нь ач холбогдолтой юм. Эмийн тун хэмжээг сонгож авах үед танаас тэсвэр, цөхрөлтгүй оролдлого шаардана, таны бие аажмаар сайжрана гэдгийг урьдчилан сайн ойлгуулах хэрэгтэй. Хэрэв артерийн даралтад өвчтөн өөрөө буюу ойр хавийн хүн хэмжиж үздэг бол хоногийн хэлбэлзлийг хэт үнэлэх зэргээс сэргэмжилбэл зохино. Эм өгөх дөө гарч болзошгүй хүндрэлийн тухай (өвчтөн эмийн тухай уншсан бол) өвчтөнд урьдчилан сануулах, эмийн гаж нөлөө (сулрах, ам хатах)-г тэсвэрлэх, эдгээр нь системтэй эмчилгээний явцад яваандаа арилна гэдгийг зориуд хэлэх нь зүйтэй юм. Өвчтөнд тэр ч байтугай их хэмжээгээр даралт бууруулах эм хэрэглэхэд бэлгийн ажиллагаа алдагдах ноцтой хүндрэл ч илэрч болдгийг сайн ойлгуулах хэрэгтэй. Өвчтөнтэй, итгэж найдах харьцааг батжуулах нь эмчээс цаг хугацаа шаардагдах нь дамжиггүй. Ийм цаг хугацаа зарах нь замбараагүй эмчилгээний алдсан цагаас хожоотой байх болно.

Артерийн даралт ихсэх өвчний хүнд хэлбэрийг эмчлэх. Артерийн даралт ихсэхийн хортой хэлбэр буюу даралт ихсэхтэй хэлбогдон гарч ирсэн яаралтай тусламж шаардлагатай өвчтөнд хийх эмчилгээ нь дээр өгүүлсэн эмчилгээнүүдээс зарчмын ялгаатай юм. Тийм өвчтөнийг заавал хэвтүүлж эмчлэх хэрэгтэй. Ийм өвчтөнд артерийн даралтыг буулгахын тулд (ядахдаа хэдэн өдөр ч гэсэн) түргэн үйлчилгээтэй, үр дүн сайн өгөх тун хэмжээгээр, тариануудыг (лазикс, дигизол, симпатолитик, зарим ганглиобликатор, нитропруссид натр) хийж даралтыг нь байнга хянаж, үр дүн өгсөн үед уух эмэнд аажмаар шилжүүлэх хэрэгтэй.

Дүгнэлт. Даралт бууруулах эмчилгээг ерөнхийд нь биелүүлж дагад олонхи өвчтөний артерийн даралт буурах ба түүний тэнхээ тамирыг хэвийн байдалд барьж тогтоож болно. Артерийн даралт ихсэх өвчний эмчилгээг сайн үр дүнд хүргэхийн тулд цаг хугацаанд идэвхтэй илрүүлэх нь чухэл. Үүний тулд:

1. Тайлбарлан таниулах өвөрмөц ажлыг аль болохуйц өргөн хүрээтэй зохиож, эмчилгээнд хандах өвчтөний ухамсыг дээшлүүлэх.

2. Артерийн даралт ихсэхийг бууруулахад чиглэгдсэн заслын ерөнхий журмыг даган мөрдөх нь тэргүүн зэргийн зорилт мөн гэдэгт өвчтөн эмч хоёрын анхаарлыг хандуулах.

3. Даралт бууруулах эмийн эмчилгээний зарчмыг эмч нар ягштал, дэс дараатай сахиж мөрдөх нь өвчтөнийг диспансерлахад чухал.

4. Янз бүрийн хэмжээ, хэлбэрийн даралт бууруулах эмээр тогтолцом хангах нь чухал юм.

Ингэж даралт бууруулах эмийн үр дүнг дээшлүүлэх, хэтийн төлөв, эмчилгээний шинэ арга, шинэ эм бий болгох, системтэй эмчилгээний зохион байгуулалтыг боловсронгуй болгох нь зүйтэй байна.

„Клиническая медицина“ сэтгүүлийн 1986 оны нэгдүгээрээс их эмч Ц. Чойжинхорлоо орчуулав.

Редакцийд ирсэн 1986.06.10

Д. БААСАНЖАВ (Анагаах ухааны хүрээлэн)

ТАРХИНЫ СУДАСНЫ ӨВЧНҮҮДИЙН ЭХНИЙ ХЭЛБЭРҮҮД, ТАРХИНЫ ЦУСНЫ ЭРГЭЛТИЙН ТҮР ЦОЧМОГ ӨӨРЧЛӨЛТ

Тархины инсультыг (тархинд цус харвах, тархинд цус тасалдаж үхжил үүсэх) үүсгэгч шалтгаан, тэдгээрийн эмгэг жам, эмнэлзүй ба эмчилгээний аргуудыг боловсруулах судалгаа шинжилгээний ажлын үр дүнд уг салбарт ихээхэн ахиц гарсан боловч учир дутагдалтай хэвээр байна. Зүрхний инфаркт өвчинеэр өвчилсөн бүх өвчтөний 80% нь, сайжирч хөдөлмөрийн чадвартай болж байхад хүнд инсультээр өвчилсөн бүх өвчтөний 80 орчим хувь нь тахир дутуу болж байна. Иймээс тархины инсультээс урьдчилан сэргийлэх нь эмнэлгийн болон нийгэм эдийн засгийн онцгой ач холбогдолтой юм.

Тархины судасны өвчнүүдийн эхний хэлбэр нь тархины инсульт үүсэхийн урьталь үе болдог нь цөөнгүй. Иймээс тархины судасны өвчнүүдийн эхний хэлбэр үүсэх шалтгаан, тэдгээрийн эмгэг жам, эмнэлзүй, урьдчилан сэргийлэх ба эмчлэх аргуудыг гүнзгийруулэн судлах шаардлагатай байна. Ийм судалгаа 1981—1985 онд ЭЗХТЗ-ийн хүрээнд хийгдлээ. Судалгааны ажилд БНБАУ, БНКУ, БНМАУ, ЗХУ, БНСЧСУ-ын эрдэм шинжилгээний хамтлагууд оролцов. Судалгааны Төв зохицууллагч байгууллагын үүргийг ЗХУ-ын Анагаах Ухааны Академийн мэдрэл-судалалын хүрээлэн гүйцэтгэж байна.

Судалгааны үр дүнд тархины цусан хангамжийн бүрэн бусын эхний илрэлүүд (ТЦХБЭИ) буюу тархины цусны эргэлтийн далд дутагдлын тухай анх бүхэл бүтэн ойлголттой болгов. Сэтгэхүйн болон биеийн хүчний хэт ачааллын үед үйл ажиллагааны тэрхүү өсөн нэмэгдэж байгаа шаардлагыг өвчтөний тархины цусан хангамж хангаж чадахгүй болох нь нотлогдов. Энэ байдал толгой өвдөх, чих шуугих, анхаарал, ажлын чадвар, ой ухаан сурлах, нойргүй болох зэрэг шинжээр илэрдэг. Тархины цусны эргэлтийн түр цочмог өөрчлөлтөөс ялгаатай нь ТЦХБЭИ бүхий өвчтөний өгүүлэлд нэг удаа, эсвэл олон дахин давтагдах байдлаар мэдрэлийн голомтолсон шинж тэмдэг илэрч байсан тухай бодит баримт байдаггүй.

ТЦХБЭИ нь тархины судасны өвчний ээнэгшилтэй байгаа үе юм. Гэхдээ энэ ээнэгшил нь тогтвортой биш, тархинд цус болон бусад чухал шаардлагатай бодисын хэрэгцээ нэмэгдэх үед тархины цусны эргэлтийн зохицуулалт алдагддаг. ТЦХБЭИ-ийн эмгэг жамд нийт

тархины болон түүний тодорхой хэсгийн цусны гүйдлийн түвшин буурч цусан хангамжийн эгзэтгэй байдал үүсгэх, судас нарийсахаас гадна гемореологийн, мөч зарим нейротрансмиттерийн идэвхт байдлын өөрчлөлтүүд нөлөөлдөг.

Судалгаанд оролцсон орнуудад явуулсан хүн амын үзлэг судалгаагаар цусны даралт ихсэх өвчин ТЦХБЭИ өвчнийг үүсгэхэд нөлөөлэх гол хүчин зүйл болохыг тогтоов. Зарим оронд 40 хүртэлх насны эмэгтэйчүүдэд тархины цусны эргэлтийн өөрчлөлтийн шалтгаанд үр тогтолтын эсрэг гормоны эмүүдийг хэрэглэдэг нь зохих ёсоор холбоотой байна.

Хамтын судалгааны үр дүнд ТЦХБЭИ эмгэгийн шинж тэмдэг, хам шинж, оношийн хэмжүүрүүдийг тодотголоо. Тархины цусны эргэлтийн далд дутагдлыг хүн амын үзлэгээр илрүүлэхэд тустай хүснэгтийн аргыг боловсруулав.

Тархины цусны эргэлтийн далд дутагдлын үед нүд, чихний талаас илрэх мэдрэлийн шинжүүдийг ялган тодотгосон нь оношийг бодитой болгоход чухал ач холбогдолтой юм. ТЦХБЭИ-ийг оношлоход клиник, лабораторийн болон тусгай багаж аппаратын иж бүрэн аргуудыг (реоэлектроэнцефалографи, хэт авианы доплерографи г.м) боловсруулсан бөгөөд тэдгээр нь хүн амд үзлэг хийхэд илүү ашигтай болох нь харгадав.

Духны термографи, хэт авианы доплерографийн аргуудыг хослон хэрэглэх нь толгойны магистраль артериудын болон Виллизиевийн цагираг судасны үйл байдлын тухай баялаг мэдээлэл өгдгийг илрүүлэв. Эдгээр арга нь хүн амын үзлэгийн үед ТЦХБЭИ эмгэг оношийг батлахад илүү зохимжтой бодит арга юм.

Энэхүү хамтын эрдэм шинжилгээний ажлын үр дүнд тархины судасны эмгэгийн эхний хэлбэрүүдийг болон цусны эргэлтийн түр цочмог өөрчлөлтийг эмгэг жамын зарчмаар эмчлэх, тухайлбал артерийн даралтыг хэвийн болгох, тархины цусны гүйдэл, метаболизм, цусны реологийн шинж чанар зэргийг сайжруулах эмийн бодисыг оролцуулсан эмчилгээний иж бүрэн бүдүүвчийг боловсруулав. Бага тунгийн аспириныг дипиридамол ба ноотропын төрлийн эмүүдтэй хавсан хэрэглэхэд эмчилгээний сайн үр дүнтэй байна. Антиагрегант, ноотропын эмүүдээр эмчлэх нь тархины цусны эргэлтийн түр өөрчлөлтийн давтагдалтыг цөөрүүлж, инсульт үүсэхийг багасгаж байна. Тархины цусны эргэлтийн түр цочмог өөрчлөлттэй өвчтөний нойр ба хүзүү-нугаламын артер судсууд нарийссан үед мэс заслын эмчилгээ хийж болох заалтад тохирох өвчтөнийг зөв сонгож авбал уг эмчилгээ үр дүнтэй болно.

ЭЗХТЗ-ийн хүрээнд хамтран явуулсан энэхүү судалгаа-шинжилгээний ажлаар боловсруулсан нэлээд зүйлийг манай эрүүлийг хамгаалахын практикт шууд хэрэглэх боломж байна. Тухайлбал „Хүн амын үзлэгийн үед инсультээс урьдчилан сэргийлэх зорилгоор өвчтөнийг илрүүлэх ба сонгох арга“, „Тархины цусны эргэлтийн далд болон түр өөрчлөлтийг оношлох, эмчлэх, урьдчилан сэргийлэх аргачилсан заалт“ гэсэн зөвлөмжүүд практик ач холбогдолтой болох нь маргаангүй.

Эрдэм шинжилгээний ажлын үр дүнд оношлогооны шинэ багажуудыг зохион бүтээв. Үүнд, мэдрэлийн өвчинийг хянах монитор, стереотаксийн мэс заслын аргаар судасны бүлхэнд клипс тавих аппарат, компьютертэй томографийн шинжилгээний аппаратын үйлдвэрлэлийг эхэлсэн зэрэг болно.

ЭЗХТЗ-ийн хүрээн дэх эрдэм шинжилгээний хамтын ажиллагаа өргөжин гүнзгийрсээр байна. Тархины судасны өвчнүүдээс урьдчилан сэргийлэх, эмчлэх чиглэлээр 1986—1990 онд явуулах эрдэм шинжилгээний ажлын программыг дээрх орнуудын зэрэгцээгээр социалист

бусад орнуудын эрдэм шинжилгээний хамт олны оролцостойгоор боловсруулж байна.

Эрүүлийг хамгаалахын энэ чухал шийдвэрлэх асуудлаар ЭЗХТЗ-ийн хүрээн дэх эрдэм шинжилгээний цаашдын хамтын ажиллагаа инсультын өвчлөл, нас баралт, дутуу тахир болох үзүүлэлтүүдийг бууруулах үр дүнд хүрэх юм.

Редакцид ирсэн 1986. 09. 26

Д. ЦЭГЭЭНЖАВ (аспирант)
Ц. БҮНДАН (Анагаах ухааны хүрээлэн)

ЗҮРХНИЙ ТИТМИЙН ЦУС ТАСАЛДАХ ӨВЧНИЙГ ОНОШЛОХОД ТИТМИЙН АНГИОГРАФИЙН АЧ ХОЛБОГДОЛ

Сүүлийн үед зүрх судасны өвчиний дотроос зүрхний титмийн цус тасалдах (ищеми) өвчин дэлхийн ихэнх орнуудад ихсэж, ДЭХБ-ын мэдээгээр зүрх судасны өвчиний дотор 53%-ийг эзлэх боллоо (2.14).

Манай гаригийн нийт хүн амын 3,5% нь зүрх судасны өвчинеөр өвчилж байгаагийн дотор зүрхний булчингийн шигдээс, титмийн цус тасалдах өвчинеөр жил бүр 2 сая орчим хүн нас барж байна. Энэ өвчинийг оношлох, эмчлэх, урьдчилан сэргийлэх талаар тодорхой үр дүнд хүрч байгаа боловч төгс оношлох, эмчлэх талаар шийдэгдээгүй асуудал цөөнгүй байна.

Ищеми өвчиний үед титмийн артер ямар нэг хэмжээгээр нарийсах буусу бүрэн ба бүрэн бус бөглөрсөн байх учраас зүрхний булчингийн хүчилтөрөгчийн хэрэгцээ, очиж байгаа артерийн цусны хэмжээ хоёрын хооронд зөрөө гарч, зүрхний булчингийн исэлдэн ангижрах процесс хүчилтөрөгч багатай (анаэроб) орчинд явагдаж пировиноградын, сүүний, өөхний хүчлүүд хуримтлагдан эдгээр бодисын нөлөөгөөр зүрхний булчингийн эсийн мембрэн гэмтэж кали алдах процесс ихсэнэ. Дээрх процесс титэм судасны өөрчлөлттэй холбоотой учраас титмийн эмгэгийн байршил, нарийслыг тогтоох зайлшгүй шаардлагатай юм.

Одоогоор ищеми өвчиний оношлоход хэрэглэж байгаа зүрхний цахилгаан бичлэг (ЗЦБ), Велоэртометрийн сорил (ВЭМ), цусанд гарах биохимийн болон ферментийн өөрчлөлтууд нь уг өвчиний таних, эмчилгээний аргыг боловсруулахад шийдвэрлэх нөлөөтэй боловч титмийн артерийн эмгэгийн байршлыг зөв тогтоож эцсийн оношийг зөв тавихад учир дутагдалтай юм. Ийм нөхцөлд титмийн ангиографийн шинжилгээ онцгой рольтой.

Судлаачид титмийн артерийг тодруулах оролдлогыг эхний үед туршилтын амьтанд (Rousethui—1933) улмаар хүнд (Radneu—1945) амжилттай хийсэн нь титмийн ангиографийн шинжилгээ хөгжих эхлэл болсон байна (1, 6, 11). Цаашид дээрх арга улам боловсронгуй болж 1958 онд Sones титмийн артерийн амсарт тодотгогч бодис шахаж зураг авснаар титмийн артерийг сонгомлоор тодруулах эхлэл болсон юм (1,11).

1967 онд Judkins баруун ба зүүн титмийн артерийг ээлжлэн сонгомлоор тодруулахад зориулагдсан сэтгүүр бүтээж хэрэглэсэн нь хам-

гийн боловсронгуй арга техник байсан учраас Judkins-ийн арга нэрээр одоо өргөн хэрэглэгдэж байна (13).

ЗХУ-д титмийн ангиографийн шинжилгээг П. Н. Мазаев (1949) Ю. С. Березов, В. В. Зарецкий (1949), Ю. С. Петросян (1962) Л. С. Зингерман (1963, 1964), Ю. Е. Березов (1964) нар хийж, одоо ЗХУ-ын зүрх судасны төвүүдэд амжилттай хийж онол практикийн ихээхэн туршлага хуримтлуулжээ.

Манай оронд титмийн ангиографийн шинжилгээг сүүлийн үед зүрхний титмийн эмгэг өвчтэй хүмүүст хийж, зүүн ховдлыг сэтгүүрдэн агшилтын ба суралтын эцсийн даралтыг (КСД, КДД) хэмжин зүүн ховдлын ангиографи хийж байгаа нь ишеми өвчний эцсийн оношиг зөв тогтоох, бусад өвчинөөс ялгах, шигдээс өвчний дараах зүрхний булчингийн агших чадварт анализ хийхэд үр ашгаа өгч байна.

1. Ишеми өвчний үед гарах титэм судасны өөрчлөлт

Титэм судсанд гарах өөрчлөлтөнд дүгнэлт хийхэд титмийн анатомын бүтэц, цусан хангамжийн онцлогийг сайтар мэдэх шаардлагатай.

Зүрх нь гол судасны хагас сар хэлбэртэй хавхлагын дээхэн хэсгээс гарч байгаа баруун ба зүүн титмийн arteriаr тэжээгдэнэ. Зүүн титмийн arter (ЗТА) нь гол судаснаас гарч 2—4 см явваад ховдол хоорондын урд салаа (ХХУС), тойрох салаа (ТС) гэсэн хоёр үндсэн салаа өгнө. Дээрх салаанууд нь зүрхний зүүн ховдол, ховдол хоорондын таславчийн 2/3, баруун ховдлын ар ханын зарим хэсгийг тэжээнэ.

Баруун титмийн arter (БТА) нь зүрхний баруун хэсгийг цусаар хангажаас гадна зүүн ховдлын ар ханын хэсэг, ховдол хоорондын таславчийн доод арын 1/3-ийг тэжээнэ. Зүрхний ЗТА, БТА тэдгээрийн салаанууд нь булчингийн бүх давхаргад жижиг салаануудаар сүлжилдэн холбогдох коллатерали үүсгэн зүрхний булчинг жигд цусаар тэжээнэ. Титмийн аль нэг arter, түүний салаа зүрхний булчингийн тодорхой нэг хэсгийг тэжээж байгаа учраас зүрхний булчингийн шигдээс, титмийн цус тасалдах өвчний үед зөвхөн нэг хэсэг газарт тэжээл дутагдах (ишеми), үхжил (некроз) үүсэх процесс явагдана.

Зүрхний ишеми өвчний үүслийн шалтгааны 85—90% нь титэм судасны хатууралтай холбоотой байдаг (7,9). Үйм учраас титмийн ангиографийн шинжилгээгээр ишеми өвчнийг 80—100% оношилно, Энэ өвчний үед илрэх зовиур, клиникин шинж тэмдэг, ЗЦБ-ийн өөрчлөлт, ачаалалттай бичлэгийн үзүүлэлт нь титэм судсанд гарсан өөрчлөлтөөс шууд хамаарна. Гэхдээ титмийн хичнээн судас аль хэсэгтэй өөрчлөлтэй байгаа, бөглөрсөн эсэхээс шалтгаална (10).

Ишеми өвчний үед титмийн судас харилцан адилгүй өөрчлөлттэй байдаг. Хамгийн нөлөөтэй, ихээр гэмтдэг судас бол ЗТА-ийн ХХУС юм. Энэ салаа нь зүрхний зүүн ховдлын булчингийн 70—80%-ийг цусаар тэжээдэг. Иймд энэ судас нарийсах, бөглөрөх үед өвчний явц хүнд байдаг. (Н. С. Бусленко, Л. М. Григорьева 1984). БТА, ТС хоёр харьцаангуй бага өөрчлөлтөнд орно. Ер нь нэг судасны дагнасан өөрчлөлт ховор ихэвчлэн хоёр буку түүнээс дээш байна (5,13). Хичнээн олон судас өөрчлөлтэй байна, өвчний явц хүнд, хүндрэл, нас баралт их байдаг.

Титмийн дээд эхлэл хэсэг 50%-иас дээш нарийсч 2—3 судас хамарсан байвал ихэвчлэх хүрц шигдээс үүсдэг. (5). Шигдэсийн үед ямар судас бөглөрснөөс үхжлийн байрлал, хэмжээ янз бүр байна. ЭТА-ийн ХХУС-н бөглөрлийн үед зүүн ховдлын урд хана, оройн хэсэгт, ТС-н бөглөрөлийн үед зүүн ховдлын хатуу хана үхэжсэн байх ба зүүн ховдлын урд болон ар ханын хэсгийг хамарч болно (3).

БТА-ийн бөглөрлийн үед баруун ба зүүн ховдлын ар ханыг хамарсан үхжил үүснэ. Зарим тохиолдолд титмийн томоохон судас дээгүүр

бөглөрснөөс үхжил их талбайг хамарч улмаар зүрхний булчин задрах, цүлхэн үүсэх хүндрэл гардаг байна.

Судалгааны материалаас үзэхэд титэм судасны 50% хүртэлх нарийслын үед клиникийн шинж тэмдэг бараг илэрдэггүй. Иймд аль болох эрт титмийн ангиографийн шинжилгээ хийх нь өвчнийг эрт оношилж эмчилгээний тактикийг зөв боловсруулахад ач холбогдолтой юм.

2. Титмийн ангиографи хийх заалт

1950-иад оны эцэс 60-аад оны эхээр титмийн ангиографийн шинжилгээг зөвхөн титмийн дутагдлын үед мэс засал хийх зорилгоор хийж байлаа. (J. L. Favuikant 1959. A. M. Bilgutay 1962, W. H. Sewell 1963) (1,11).

Сүүлийн үед титмийн ангиографийн шинжилгээний арга төхник улам боловсронгуй болж оношлогооны чанар сайжирсаар зөвхөн мэс засал хийх зорилгоор биш, онош батлах. титмийн эмгэгийн байршлыг зөв оношлох бусад өвчинөөс ялгах, цаашдын эмчилгээний хэлбэр, хөдөлмөр зохицуулалтыг шийдэх зорилгоор хийх болсон байна (9,16).

Титмийн ангиографийн шинжилгээг эхний үед төлөвлөгөөт байдлаар хийж байв. Одоо яаралтай журмаар буюу өвчний хурц үед (шигдээс үүссэний дараа эхний 6—8 цагийн дотор) буюу шигдээс үүссэнээс хойш 3—6 долоо хоногийн дараа хийж байна (12, 9, 16).

Титмийн ангиографийн шинжилгээг дараах нөхцөлүүдэд хийж болно (8, 9, 13, 15).

1. Ишеми өвчиний онош эргэлзээгүй тохиолдолд титмийн артерийн өөрчлөлтийн тархалт, байрлал, нарийслын зэргийг тогтоож, өвчиний явцад дүгнэлт өгөх, цаашдын эмчилгээний хэлбэрийг сонгох, хөдөлмөрлөх чадварыг нь дүгнэх зорилгоор хийнэ. Ялангуяа тайван буюу шөнийн үед зүрхээр байнга өвддөг, үл ялих сэтгэлийн хямрал, биеийн хүчний ачааллын үед өвддөг хүнд хэлбэрийн ишеми өвчиний үед зайлшгүй хийх шаардлагатай.

2. Клиникийн шинж тэмдгээрээ ишеми өвчин болох нь тодорхой боловч ЗЦБ, ачаалалтай бичлэг (VELOORGOMETRI)-т тодорхой өөрчлөлтгүй тохиолдолд оношийг батлах зорилгоор хийнэ. Зарим өвчтөнд ЗЦБ-т „ST“-ийн хазайлт, „T“ шүдний өөрчлөлт бүхий боловч клиникт тодорхой шинж тэмдэггүй байдаг.

И. К. Шхвацабая (1973 он) ишеми өвчин тодорхой шинж тэмдэг бүхий өвчтөнд (500) титмийн ангиографийн шинжилгээ хийхэд 90% нь титмийн хэд хэдэн артерийн нарийсалтай байжээ.

3. Ишеми өвчинийг бусад өвчинөөс ялгах зорилгоор хийнэ. Үүнд: Зүрхний гаралтай сэтгэлийн хямрал, шалтгаан тодорхойгүй кардиомиопати, климаксийн үеийн кардиомиопати, остеохондроз, радикулит, ходоод гэдээсний зарим өвчин (цөсний чулуу, ходоод 12 нугалаа гэдээсний шархлаа), уушгины зүүн доод хэсгийн үрэвсэл зэрэг өвчиний үед зүрх рүү өвдэж байгаа юм шиг өвддөг. Дээрх өвчинүүдийн үед ч ЗЦБ өөрчлөгдэж болно. Иймд онош тодруулахын тулд ачаалалтай бичлэг, титмийн ангиографийн шинжилгээ хийнэ.

4. Ишеми өвчинөөр олон жил өвчилсөн, ялангуяа шигдээсийн дараах байдалд байгаа өвчтөнд мэс засал хийх зорилгоор хийнэ.

Титмийн ангиографийн шинжилгээг ишеми өвчиний бүх үеүдэд хийх боловч хийж болохгүй тохиолдууд бий. (4, 11, 12). Үүнд: Үндсэн өвчиний улмаас амьдралын чухал эрхтэнд (элэг, бөөр, уушги) гүнзгий өөрчлөлт орсон, зүрхний хүнд хэлбэрийн хэм алдагдал, зүрхний дутагдлын хүнд хэлбэр, тархины цусны эргэлтийн хурц өөрчлөлт, тодотгогч бодист хэт мэдрэг байгаа зэрэг тохиолдолд хийж болохгүй.

3. Титмийн ангиографийн шинжилгээ хийх эрөнхий зарчим

Юуны урьд өвчтөнөө сонгож зүрх судасны мэс заслын тасагт хэвтүүлэн бүх төрлийн шинжилгээ хийнэ. Үүнд:

Зүрхний цахилгаан бичлэг (хэрэв өвдөлттэй бол шинжилгээнд орохын урьд өдөр ба өглөө), ачаалалтай бичлэг цусны булэгнэлт—протромбины индекс, биохимийн шинжилгээнд сахар, холестерин, липидийн солилцоо, зарим фермент (КФК, ЛДГ) тодорхойлж цээжний хөндийн эрхтэнг гэрэлд харах, бусад шинжилгээ хийсэн байна (12, 15).

Шинжилгээнд орохын өмнө өвчтөнд сэтгэл санааны болон эмийн бэлтгэл хийнэ. Шинжилгээнд орохын урьд шөнө, өглөөгүүр тайвшруулах, өвчин намдаах эм уулгана. Өвчтөнг шинжилгээнд тэргэнцэрээр хүргэнэ. Тодотгогч бодисын сорил узсэн байна, Ангиографийн шинжилгээг хэсгийн мэдээ алдуулалтаар буюу өнгөц унтальтын байдалд хийнэ (13).

Титмийн ангиографийн шинжилгээг титэм судсыг сонгомлоор (тиэм судасны амсарт тодотгогч бодис шахах) ба сонгомол бусаар (гол судасны өгсөх хэсэгт титэм судасны амсарын ойролцоо) то друулах хоёр хэлбэрээр хийдэг.

Сонгомол аргаар хийхэд Judkins-ийн аргыг баримгална (1, 9, 14). Үүний тулд Сельдингериин аргаар гуяны аль нэг талын артерт хатгаж Judkins-ийн сэтгүүрийг зөвлөн залуурын хамт дээшлүүлэн гол судасны өгсөх хэсэгт аваачин зөвлөн залуураа сугалан авч буулэн үүсэхээс урьдчилан сэргийлж гепарин 25—50 мг шахаж сэтгүүрээ титмийн артерийн амсарт тулган 1—3 мл тодотгогч бодисыг шахаж телевизийн дэлгэнцнээ харахад титмийн судсанд тодотгогч бодис орсон бол титмийн зураглал гарна, мөн сэтгүүр зүрхний агушилтын аясаар хөд өлнө. Энэ нөхцөлд автомат шприцээс 5—8 мл тодотгогч бодисыг шахаж секундэд 4—6 зургийг эгц ба хажуу проекциоор авна. Хэрэв киноаппараттай бол секундэд 60—80 зураг авна (11, 15). Дээрх арга нь баруун ба зүүн титмийн артерийг эзлжлэн сэтгүүрдэхэд зарчмын хувьд ижил боловч техникийн онцлог бий.

Шинжилгээ хийсний дараа сэтгүүрээ сугалан авч гуяны артерийг 20—25 минут дарж цус гаражгүй болсны дараа дарж боно. Өвчтөн 24 цаг хэвтрин дэглэм сахина. Онц хүндрэлгүй бол 5 хоногийн дараа эмнэлгээс гаргана.

Шинжилгээний явцад өвчтөний биеийн байдлыг ЗЦБ-ээр тогтмол хянаж, артерийн даралт хэмжин, өвчтөний биеийн байдлыг өөрөөс нь асууж зүрхний орчимд өвдөл нитроглицерин хэлэн доор нь тавьж шаардлагатай бол бусад арга хэмжээ авна.

4. Титмийн ангиографийн шинжилгээнд хийх дүгнэлт

Уг шинжилгээгээр гарсан титэм судасны өөрчлөлтөд дүгнэлт өгөхдөө ДЭХБ-ын баримталж байгаа Ю. С. Петросян, Л. С. Зингерманы (1974) ангиллыг баримтална (4, 11, 14, 15).

I. Зүрхний цусан хангамжийн анатомын хэлбэрийг тогтооно.

— Зүрхний цусан хангамжинд титмийн аль артер илүү оролцож байгаагаар нь:

- зүүн хэлбэрийн цусан хангамжтай
- баруун хэлбэрийн цусан хангамжтай
- баруун ба зүүн артер зүрхний цусан хангамжинд оролцсон байвал жигд цусан хангамжтай гэж үзнэ.

2. Титэм судсанд байгаа эмгэгийн байршилаар

- зүүн титмийн артер (ЗТА)
- ЗТА-ийн ховдол хоорондын урд салаа (ХХУС)
- ЗТА-ийн тойрох салаа (ГС)
- баруун титмийн артер (БТА)

3. Эмгэг процессын тархалтаар:
 - а) титмийн артерийн дээд хэсэг (дээд 1/3)
 - б) титмийн артерийн дунд хэсэг (дунд 1/3)
 - в) титмийн артерийн төгсгөл хэсэг (доод 1/3)
4. Титэм судасны нарийслыг зэрэг болгон дүгнэнэ.
 - I зэргийн нарийсалт—50% хүртэл нарийссан
 - II зэргийн нарийсалт—50—75% хүртэл нарийссан
 - III зэргийн нарийсалт—75%-иас дээш нарийссан
 - IV зэргийн нарийсалт—титмийн артерийн хөндий бөглөрсөн байна.

Огт нарийсаагүй бол нуль зэрэг гэнэ.

5. Титмийн артер тэдгээрийн салаануудын коллатерали үүсгэсэн байдалд дүгнэлт өгнө.

Дээрх ангиллаар титэм судасны ангиограммд дүгнэлт хийж оношид зөв тусгаснаар титмийн ямарч эмгэгийг бодит үндэслэлтэй оношлож болох юм.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. Н. М. Амосов, Я. А. Бендет—, Терапевтические аспекты кардиохирургии“Хирургическое лечение ишемической болезни сердца. 1981. 181—191.
2. Н. С. Бусленко—Клиника, диагностика ишемической болезни сердца и принципы отбора больных для операции аорто хоронарного шунтирования. Док. дис., 1974.
3. А. М. Вихерт, В. С. Жданов—Кальциоз коронарных артерий сердца Кардиология. 1975. 3, 102—108.
4. В. С. Гасилин, Б. А. Сидоренко—„Стенокардия“ М. 1981.
5. Р. Горлин—„Болезни коронарных артерий“ перевод с английского. М. 1980
6. В. Н. Дзяк, И. И. Крыжановская, З. К. Алексеенко, И. К. Следзевская, Г. В. Яновский—„Ишемическая болезнь сердца“. Киев 1977.
7. Д. Г. Иоселиани—„Ишемическая болезнь сердца в аспекте хирургического лечения“ Док. дис. 1979.
8. М. Д. Князев, А. А. Кириченко—„Показания к хирургическому лечению при ишемической болезни сердца“, „Кардиология“ 1982. 6. 5—8.
9. В. И. Колесов—Хирургия венечных артерий сердца“ Ленинград, 1977
10. Б. В. Петровский, М. Д. Князев, Б. В. Шабалкин—„Хирургия хронической ишемической болезни сердца“ М. 1978.
11. Ю. С. Петросян, Л. С. Зингерман—„Коронарография“ Медицина. 1974.
12. П. Х. Рабкин, А. М. Абугов, И. С. Аслибекян, А. И. Боровков—Коронарография при острой недостаточности коронарного кровообращения, „Кардиология“ 1975. 8. 14—18
13. А. В. Сумароков, В. С. Монсеев—Клиническая кардиология. Ишемическая болезнь сердца. М. 1986. 5—70.
14. Диагностика и хирургическое лечение ишемической болезни сердца. Методические рекомендации И. С. С. С. Хим Букулева А. Н. АМН СССР М. 1985.
15. Современные рентгеноконтрастные методы диагностики ишемической болезни сердца. „Лекции“ М. 1982.
16. Под ред. Проф. В. Г. Шершнева—Новые направления в диагностике и лечении ишемической болезни сердца“ М. 1983.

Редакцийд ирсэн 1986. 09. 01

Ө. ЖҮГДЭР (Эх нялхсыг хамгаалах эрдэм шинжилгээний хүрээлэн)
Б. ШИЖИРБААТАР, Д. ИЧИНХОРЛОО (Анагаах ухааны дээд сургууль)

КАРДИОТОКОГРАФИЙГ ЭХ БАРИХЫН ПРАКТИКТ ХЭРЭГЛЭХ НЬ

Манай орочд сүүлийн жилүүдэд эх барих эмэгтэйчүүдийн практикт оношлогоочы өндөр хүчин чадал бүхий орчин үеийн аппаратуудыг хэрэглэх боллоо. Клиникийн I амаржих газарт Анагаах ухааны

дээд сургуулийн эх барих эмэгтэйчүүдийн өвчин судлалын тэнхимийн багш нар, Эх нялхсиг хамгаалах эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эх барих эмэгтэйчүүдийн өвчин сүдлалын секторын эрдэм шинжилгээний ажилтнууд тус амаржих газрын эх барих эмэгтэйчүүдийн эмч нар хамтран кардиотокографи, Микро-Аструп, электроаналгези, хэт дууны авиаагаар оношлох аппарат зэрэг багаж аппаратуудыг эрдэм шинжилгээ судалгааны ажил болон практикт ашиглаж байна. Цаашид улам өргөжүүлж бусад хот аймгуудад ашиглах шаардлагатай байна.

Сүүлийн жилүүдэд хэвлэж дэх ургийн хүчилтөрөгчийн дутагдлыг эрт илрүүлэхэд түүний зүрхний цохилтыг хянаж байх мониторын аргыг хэрэглэж байна.

Кардиомониторын аппаратыг хэрэглэнээр умайн доторхи даралтын өөрчлөлт ба төрөх үйл ажиллагааны явцад ургийн зүрхний цохилтын хэм яж өөрчлөгдөж байгаад тасралтгүй хяналт тавих явдал юм.

Мөн кардиомониторын дэмжуулагчийн тусламжаар умайн агшиж чадварыг ашиглаж төрөлтийн явцыг хянаж байна.

Эх барих эмэгтэйчүүдийн практикт ашиглаж байгаа багаж аппаратуудын дотроос кардиотокографийг юуны өмнө эх барихын практикт аймаг, хотуудын төрөх газруудад өргөн ашиглаж жирэмслэлт төрөлтийн хүндрэлээс сэргийлэх нь перинаталь эндэгдлийг буур уулахад ач холбогдолтой юм.

Эрдэм шинжилгээ судалгаа практик ажиллагаанд төрөлтийн явцыг хянахаас гадча, ургийн байдлыг хянахад дотор залгадаг электродтой аппаратууд илүү ашигтай юм. Уг аппаратанд ургийн зүрхний цохилт, умайн бэзлалт (агшилтын хүч)-ыг цаасан дээр бичихийн зэрэгцээ, ургийн зүрхний цохилт дэлгэцэн дээр бичигдэж авиа дуу нь тод сонсогдоно. Мөн эхийн ЭКГ-г хамт бичиж болдог.

Ургийн зүрхний цохилтын бичлэг хийх энэхүү шинжилгээг эрдэмтэн Coldeygo-Barela (1968), Ноп (1969) нар эх барихын практикт ашиглаж, ЗХУ-д В. С. Цвигун, В. Н. Демидов (1976) нар, манай оронд 1979 оноос эх барихын практикт нэвтэрч байна.

Кардиотокографийн шинжилгээгээр ургийн байдлыг үнэлэхдээ тусгай схемийг ашиглаж болно. Үүнд:

Жирэмсэн үеийн кардиотокограммд эмнэл зүйн үнэлэлт өгөхдөө үндсэн 5 үзүүлэлт (ургийн зүрхний цохилтын дундаж тоо, осцилляцын хэлбэлзлийн ендөр, нуль (0)-шугамыг осцилляцын минутанд огтлох тоо болон ургийн зүрхний бичлэгийн өөрчлөлт, акцепляраци, децелярацыг) авч баллын системээр дүгнэнэ. Энэ нь Аргарын (1953) схемтэй ойролцоо юм. Эхний 3 нь үндсэн үзүүлэлт бөгөөд 10 минутын бичлэгээр дүгнэж болно. Сүүлчийн 2 нь нарийвчлач харах ёстой өөрчлөлт учир 30-аас доошгүй минутын бичлэг шаардлагатай.


Дээрх үзүүлэлтээр 8—10 балл авбал ураг хэвийн, ямар ч эмгэг өөрчлөлтгүй: 5—7 балл авбал ураг ямар нэг эмгэгт өртөж буй шинжийн нэг тул нэмэлт шинжилгээ, онцгой хяналтаар онош тодруулах, 4-өөс доош балл авбал эх барихын яаралтай арга хэмжээ авах шаардлагатай.

Ургийн зүрхний цохилт 1 минутанд 120—160 байвал хэвийн гэж үзнэ. Хэрэв 1 минутанд 160—180 хурч түргэсвэл ургийн зүрхний цохилт олширч эхэлж байна. 180—200 байвал олширсон (таксикарди) гэж үзнэ.

Хэрэв ургийн зүрхний цохилт 1 минутанд 119—100 байвал ургийн зүрхний цохилт удааширч эхэлж байна. 100-аас доош бол удааширсан (брадикарди) гэж үзнэ.

Кардиотокографаар шууд ба шууд бус гэсэн 2 аргаар бичлэг хийдэг.

Электрокардиографийн өөрчлөлттэй бичлэг



Ургийн зүрхний цохилтын цаасан дээр бичигдэж байгаа дундаж шугамыг цахилгаан саармаг шугамнаас дээш шуд өндөрсөж гарахыг акцелераци, доош уртсаж буй шүдийг децелераци гэнэ. Энэ бүгд нь эмгэг өөрчлөлтийг харуулж байгаа бичлэгийн хэлбэрүүд и.м.

Хэрэв эмгэг өөрчлөлт илрээгүй, ургийн зүрхний цохилт хэвийн үед бичлэгт акцелераци, децелераци илрэхгүй, шүднүүд цахилгаан саармаг шугамын дагуу жигдхэн ойролцоо түвшинд бичигдэх ёстой.

Ийм үед хугацаа, шүднүүдийн тоогоор эмгэг илрэлийг тогтоож болно. Тухайлбал: шүднүүдийн тоо 1 минутанд 10—25 удаа давтагдаж байвал эмгэг өөрчлөлтгүй хэвийн, харгын 25-аас дээш, 10-аас доош өөрчлөгдж байвал ямар нэг эмгэг илэрч байна гэж хугацаагаар нь тодорхойлж болно. Хэрэв цахилгаан саармаг шугамнаас дээш, доош гарсан шүдний тоо 1 минутанд 12 байвал хэвийн, 4—11 бол рисктэй гэж үзнэ. Иймд кардиотокографаар ургийн зүрхний цохилт умайн базлалтын өчүүхэн өөрчлөлтийг тогтоож болох учир эх барихын практикт жириэмслэлт, төрөлтийн хүндрэлээс сэргийлж өргэн хэрэглэх нь ашигтай байна.

Редакцид ирсэл 1985.10.03

Ю. З. РОЗЕНБЛЮМ, В. С. ЛАПУШКИН

БНМАУ-Д СУРАЛЦАЖ БАЙГАА ЗӨВЛӨЛТИЙН
СУРАГЧДЫН НҮДНИЙ ХАРАА МУУДАХААС
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АСУУДАЛД

Нүдний харах чадвар муудахын үндсэн шалтгаан нь гэрэл хугалах үйл ажиллагааны гажиг өөрчлөлт, түүний дотор холын хараа муудах явдал юм.

БНМАУ нь эрс тэс уур амьсгалтай бөгөөд энэ бүс нутагт өвөл зуны сарууд болон хоногийн дундаж температурын зөрүү их, жилд унах тундасны хэмжээ бага, уулархаг байдалтай холбоотойгоор атмосферын даралт бага байх зэрэг цаг уурын онцлогтой. Эдгээр тохиromжгүй хүчин зүйл нь өсөж яваа, дасан зохицох чадвар мутай хүүхдийн бие маходод нөлөөлснөөс зарим эрхтэн системийн ачаалал ихсэж, үйл ажиллагаа нь алдагдаж элдэв төрлийн өвчин эмгэг үүсэхэд хүргэдэг. Тухайлбал эдгээр нөлөөллийн улмаас нүдний харааг зохицуулах аппаратын хөгжил саатаж болох юм.

Хэдийгээр БНМАУ-ын нутаг дэвсгэрт нарны гэрэлтэй байх хугацаа жилд 2600—3000 цаг үргэлжлэх боловч хүүхдийн бие маходод шүрэлцэхүүц хэмжээний хэт ягаан тuyaг авч чадахгүй байна. Энэ нь цаг агаарын эрс ширүүн уур амьсгал, зөвлөлтийн иргэдээс гадаадад оршин суух амьдралын өвөрмөц байдалтай холбоотой. Хүүхдийн бие маходод суррахад хоол тэжээлийн байдал баагүй үүрэгтэй. Тухайлбал хүчиний бүтээгдэхүүнд А, В, С-ийн төрлийн витаминууд, түүнчлэн ундны усанд зарим бичил элементүүдийн агуулагдах хэмжээ баагаа байгааг тэмдэглэх хэрэгтэй. Үүнээс гадна гадаадад оршин сууж буй зөвлөлтийн иргэдийн амьдралын нөхцөл нь нэлээд хэмжээгээр суурин болж төвлөрсөн байдалтай байдгаас хүүхдүүд агаарт гарах, биеийн хөдөлмөр эрхлэх нь баагасч, хөдөлгөөний идэвх буурах хандлагатай болдог. Дээр дурдсан хүчин зүйлүүд нь нүдний харааг зохицуулах аппаратын үйл ажиллагааг сурруулахад нөлөөлдөг.

Нэг талаас биохимиийн дасан зохицох процесстой холбоо бүхий хараа зохицуулах чадвар буурах, нөгөө талаас хөдөлгөөн багассантай холбоотойгоор харааны ачаалал нэмэгдэх нь сурагчдын холын хараа муудахад хүргэдэг байна. Энэ дүгнэлт нь Москвагийн Гельмгольцын нэрэмжит нүдний өвчин судлалын эрдэм шинжилгээний институтээс холын хараа муудах өвчиний шалтгааныг тайлбарлаж буй ойлголттой тохирч байгаа юм.

Сурагчдын нүдний хараа муудах үндсэн шалтгаан нь холын хараа муудах явдал гэж үзэж нүдний харааг хамгаалах ажлыг үүнд чиглүүлэх хэрэгтэй байна. Эдгээр арга хэмжээний үндсэн зорилго нь хүүхдийн бие маходод нөлөөлөх байгаль цаг уурын тохиromжгүй хүчин зүйлийн нөлөөг баагасгахад оршино.

Сургуулийн өмнөх наснаас эхлэн хүүхдийн хөдөлгөөн баагасах үзэгдэлтэй идээхтэй тэмцэж, хүүхдийн бие бялдрын үв тэгш хөгжлийг хангах ерөнхий арга хэмжээг авах хэрэгтэй.

Цэцэрлэгт хүүхдийг байнга хөдөлгөөн тоглоомоор тоглуулж, биеийн тамирын дасгал хийлгэж, цэвэр агаарт байх хугацааг уртасгах шаардлагатай. Нөхцөл бололцоог ашиглан хүүхдийг хэт ягаан тuyaг баагаар шарах ажлыг зохион байгуулж одоо мөрдөж байгаа зааврыг баримтлан хоолыг витаминжуулж байгаа байдалд хяналт тавих нь чухал байна.

Сургуулийн насанд хүүхдийн холын хараа муудахаас урьдчилан сэргийлэхэд гол анхаарлаа хандуулах хэрэгтэй байна. Бусад арга хэмжээг хөдөлгөөн баагасах үзэгдэлтэй тэмцэхэд чиглүүлнэ. Энэ ажилд биеийн тамирын төрөл бүрийн бүлгэм, дугуйлангуудыг удирдан хичээллүүлдэг биеийн тамирын багш, пионерийн ордны ажилтнууд их үүрэгтэй. Биеийн тамирын хичээлээр бүх сурагчдын хөдөлгөөний идэвхийг жигд дээд зэргээр өрнүүлэх шаардлагатай. Биеийн тамирын хичээлгүй өдрүүдэд З дугаар цагийн хичээлийн дараа 10 минут гимнастик хийж биеийн чилээг гаргах нь чухал. Сурагчид гэртээ байх хугацаандаа биеийн тамирын дасгал, хөдөлгөөн сайн хийж байхыг чанд мөрдүүлэх хэрэгтэй. Амралтын өдрүүдэд хүүхдүүдийг хотоос гадна аялал зугаалгаар явуулах нь булчингийн системийн үйл ажиллагааг сайжруулах хүчин зүйлийн нэг к.м.

Гельмгольцын нэрэмжит нүдний өвчин судлалын эрдэм шинжилгээний институттээс боловсруулсан нүдний дасгал нь холын хараа муудахаас урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдолтой. Энэ дасгал нь бие махбодыг чийрэгжүүлэн түүний уйл ажиллагааг идэвхжүүлэхээс гадна нүдний алимын булчингуудыг бэхжүүлж, дасан зохицох чадварыг сайжруулдаг. Ийм дасгалыг хичээл бүрийн дунд 2—3 минугын турш хийвэл зохино. Дасгалыг багш юмуу эсвэл тусгай бэлтгэлтэй сурагч удирдан хийлгэж болно.

Нүд чилэх, холын хараа муудахаас урьдчилан

сэргийлэх зорилгоор сургууль дээр хичээлийн

үед хийх биесийн тамирын дасгал (Э. С. Аветисов, 1982)

1. Бэлтгэх байдал—Партаа налан сууж гүнзгий амьсгаа авна. Урагш бөхийж амьсгалаа гаргана. Дасгалыг 5—6 удаа хийнэ.

2. Бэлтгэх байдал—Партаа налж суусан байна. Зовхио буулгаж нүдээ аних, нээх дасгалыг 5 удаа хийнэ.

3. Бэлтгэх байдал—Гараа ташаандaa авч суусан байна. Толгой-гоо баруун тийш эргүүлж баруун гарын тохойг харна. Дараа нь зүүн тийш эргүүлж зүүн гарын тохойг хараад эхний байдалд орно. Ийм дасгалыг 5 удаа хийнэ.

4. Бэлтгэх байдал—Суугаа байдалтай байна. Ангийн самбарыг 2—3 минутын турш харна. Хуруугаа нүднээсээ 15—20 см-ийн зайнд байрлуулан хараагаа түүн дээр шилжүүлэн 3—5 секунд хараад гараа буулгана. 5 удаа давтана.

5. Бэлтгэх байдал—Суугаа байдалтай. Нүдээ дээш харж цагийн зүүний эсрэг чиглэлээр дараа нь цагийн зүүний дагуу чиглэлээр нүдний алимыг эргэлдүүлнэ. Дасгалыг 5 удаа хийнэ.

6. Бэлтгэх байдал—Гараа урагш сунгаж суусан байна. Толгой-гоо өргөлгүйгээр гараа дээш өргөж амьсгаагаа аваад гараа буулгаж амьсгалаа гаргана. 5 удаа давтана.

7. Бэлтгэх байдал—Суугаа байдалд 30 секундын турш нүдээ аньж заагч хурууны үзүүрээр иллэг хийнэ.

Сургуулийн эмч, багш нар анги, танхимын гэрэлтүүлгийн норм, сурагчид парт, ширээнд зөв сууж байгаа эсэхэд хяналт тавина. Хүүхдийн амралт, ахуйн нэхцлийг зөв зүйтэй зохион байгуулах, өдрийн дэглэмдээ хичээллэх, идэвхтэй амрах зэргийг зөв хослуулах, өрөө тасалгааны эрүүл ахуйн нэхцлийг сайжруулах, хичээллэх, амрах, байрны гэрэлтүүлгийг хангаж өгөх нь холын хараа муудахаас урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдолтой.

Гэрийн даалгавар хийхдээ нүдний дасгалыг хийх нь ашигтай. Холын хараа муудах, даамжрахаас урьдчилан сэргийлэх өвөрмөц арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Хичээлийн жилийн эхэнд эмнэлгийн ажилтнуудын хүчээр нийт ангийн сурагчдын нүдний харааг шалгаад, хараа муутай сурагчдыг нүдний кабинетын хяналтанд оруулна. Дараа нь эдгээр сурагчдыг нүдний кабинет буюу эсвэл сургуулийн тусгайлан тоноглосон өрөөнд нүдний нарийн мэргэжлийн эмч үзэж, холын хараа муутай болон холын хараа нь муудах хандлагатай сурагчдыг тодорхойлно. Холын хараа муудах хандлагатай хүүхдүүдэд аккомодац нь багассан, эцэг эх нь ойрын хараатай хүүхдүүд, хуурамч миопитэй, түүнчлэн 1,0 дptr-тэй тэнцэх астигматизмтай болон 2 үзлэгийн хооронд гэрэл хугалах чадвар нь 2,0 дptr-оос илүү нэмэгддэг хүүхдүүдийг хамааруулна. Эдгээр сурагчдыг хараа сайжруулах дасгалаар хичээллүүлнэ. Хараа зохицуулалтын хамгийн сайн дасгал нь солих линзтэй дасгал байдаг. Солих линз (шил) бүхий хараа зохицуулах дасгалын аргачлал. (Э. С. Аветисов, К. А. Мац 1971).

Өөрөөс нь 33 см зайнд байрлуулсан ямар нэг номноос уншуулж ердийн аргаар (дүрмээр) харьцангуй аккомодацийн эерэг ба сөрөг

хэсгийг урьдчилан тодорхойлно. Үншиж болох хамгийн их нэмэх, хамгийн бага хасах шилний хэмжээнээс 0,5—1,0 дптр-ийг хасахад гарсан хэмжээ нь цагираг булчингуудын субмаксималь ачааллыг илтгэнэ. Миопийг (холын хараа муудах гажгийг) тохирох шилээр зассаны дараа 0,5 дптр-тэй хасах шил зүүлгэж үншуулж эхэлнэ. Шилний хүчийг 0,5 дптр-ээс 1,0 дптр-ээр аккомодацийн эерэг хэсгийн субмаксималь хэмжээнд хүртэл нэмэгдүүлнэ. Шинэ шил зүүлгэх тутамд 3—5 минут үншуулна. Дараа нь сүүлчийн хасах шилний хэмжээг аажмаар хооронд нь 1 минутын зайдайгаар 1,0 дптр хүртэл бууруулна. Ингэсний дараа нэмэх шил тавьж эхэлнэ. Нэмэх шилний хүчийг харьцангуй аккомодацийн сөрөг хэсгийн субмаксималь хэмжээ хүртэл аажим нэмэгдүүлнэ. Шинээр шил нэмэх бурд 3 минут үншуулна. Эхний 3 өдөр дээр дурдсан дасгалыг өдөрт 1 удаа, үлдсэн өдрүүдэд 2 удаа хийнэ. Субмаксималь ачааллын түвшинг тодотгохи тулд харьцангуй аккомодацийн хэмжээг 3 өдөр дараалан тодорхойлно. Нэг курс дасгалжуулалт нь 15—20 дасгалаас бурдэнэ.

Дасгалжуулалтын үр дүнг эргографийн үр дүнгээр буюу эсвэл харьцангуй аккомодацийн нөөцийг хэмжих замаар тодорхойлно. Үншуулж байгаа сэдэв нь сонирхолтой байхаас гадна тасралтгүй үншуулах нь дасгалыг зөв хийх нэг нөхцөл байдаг.

Хэрэв эхний курс дасгал хийгээд цагираг булчингийн ажиллах чадвар сайжрахгүй бол 1 сарын зайдайгаар уг курсыг дахин давтан хийх хэрэгтэй. Дасгалын үр дүнг сайжруулах зорилгоор буюу линзийн тусламжтайгаар дасгал хийх боломжгүй нөхцөлд гэртээ удаан хугацаагаар дасгалаа хийх нь чухал.

Дасгалыг тусгай бэлтгэл сургууль хийсэн эмнэлгийн сувилагч, багш, хүмүүжүүлэгч, лаборант, пионерийн удирдагч зэрэг хүмүүс зориуд бэлтгэсэн өрөөнд удирдан хийлгэнэ. Нэг удаа 20 сурагч зэрэг хичээллэж болно.

Гэрийн нөхцөлд хийж болох нэлээд энгийн, хүртээмжтэй дасгал нь „Шилэн дээр тэмдэглэх“ дасгал юм.

«Шилэн дээр тэмдэглэх дасгалын аргачлал (Э.С.Аветисов, 1969)

Холын харааны шилтэй хүүхдийг цонхны ойролцоо, цонхноос 20—25 см зайдай зогсооно. Цонхны шилэн дээр хүүхдийн нүдний харалдаа 3—5 мм-ийн диаметртэй цагариг тэмдэг тавина. Цонхны шилэн дээр байрлуулсан цагирагийн дундуур цонхоор гадагш ямар нэг зүйлийг олж тогтоон харна. Дараа нь гаднах зүйл шилэн дээрх цагираг 2-ыг ээлжлэн харна. Дасгалыг өдөрт 2 удаа 15—20 хоног хийнэ. Хэрэв хараа сайжрах төлөв ажиглагдахгүй бол 10—15 өдөр заварлаад дахин үргэлжлүүлж хийнэ.

Эхний 3 өдөр дасгалыг 3 минут, дараагийн 3 өдөр 5 минут, үлдсэн өдрүүдэд 7 минут хийнэ. Энэ аргыг хэрэглэснээр БНМАУ-д оршин суудаг зөвлөлтийн сурагчдын холын хараа муудахаас урьдчилан сэргийлж түүний даамжралтыг 2,5—3 дахин бууруулсан юм.

Ойр хараатай бүх сурагчдыг диспансерийн хяналтанд оруулж жилд 2-оос доошгүй удаа нарийн мэргэжлийн эмч нараар үзүүлэх шаардлагатай. Харааны ачааллыг багасгах, нүдээ амраах, хараагаа засахын тулд тохирсон шил зүүж эмчийн зааврыг ягштал биелүүлэх, нүдний дасгал хийх, хүүхдийн идэвхтэй хөдөлгөөнийг нэмэгдүүлэх зэрэг нь холын хараа муудах, даамжрахаас урьдчилан сэргийлж болох гол арга юм гэдгийг ариун цэвэр гэгээрлийн суртал ухуулгын ажлаар дамжуулан холын хараа муутай хүүхдүүд, эцэг, эхчүүдэд сайтар ойлгуулах нь их ач холбогдолтой.

ТУРШЛАГА СОЛИЛЦЬЁ

Э. ДОВДОН, Р. НЯМАА

(Улсын нэгдсэн тусгай эмнэлэг)
(Анагаах ухааны дээд сургууль)

ФИЛАТОВ—КАЛЬФЫН ЭЛАСТОНОМЕТРИЙН ХЭМЖИЛТИЙН ТАБЛИЦЫГ ХЭРЭГЛЭСЭН ТУРШЛАГА

Нүдний даралт ихсэх (глауком) өвчнийг оношлох үндсэн аргын нэг нь нүдний даралт хэмжих арга юм. Тонометрээр нүдний даралт үзсэний шууд үр дүн нь тонометрийн дардас бөгөөд түүнд тохирсон даралтын холбогдлыг тойруу замаар Полякын шугамаар тодорхойдог.

Нүдний даралтыг үзсэн тонометрийн дардасыг Полякын шугамаар хэмжиж даралтыг олох аргыг алдаа ихтэй, даралтны зарим шинжилгээг хийхэд бэрхшээлтэй байгааг харгалзан А.П. Нестеров, М.Б. Бургафт нар тонометрийн дардасны диаметрийн хэмжээгээр нь нүдний тонометрийн ба дотоод бодит даралтыг олох таблицыг зохиож гаргасан юм (3). Энэ таблицыг ашиглан А. И. Нестеров нүдний шингэний урсгалын коэффициентын хурдацыг тодорхойлох тонографийн хялбарчилсан шинжилгээг гаргасан билээ.

Бид нүдний даралтыг хэмжих калиброкын аргыг хэрэглэж эхэлсэн боловч бидний хэмжилтээр нүдний даралт өгсөж гарах хандлагатай байснаас түүний шалтгааныг тодруулах зорилгоор шинжилгээ өөрсдийн боловсруулсан аргаар хийж үр дүнгий нь тооцож үзсэн юм.

Шинжилгээ хийсэн арга:

1. Нүдний даралт үзэх шинжилгээг хийхдээ хэвтээ байдалд 0,5%-ийн дикайны уусмалыг 3 удаа дусаав.

2. Нүдний алимыг тогтвортой байлгах, даралтны хэмжилтийг яг эвэрлэгийн төз дээр хийхийн тулд хөдөлгөөнтэй, цахилгаан хараа тогтоогчийг нүднээс 40 см-т байрлуулав.

3. Даралт үзэх үед тонометрийн бариулыг тонометрийн голыг дагуулан 3—4 мм доошлуулж тонометрийн жингээр нүдэн дээр байлгах хугацааг 3 секундээр тогтоосон болно.

4. Тонометрийн дардасны диаметрийг анхны хэсэгчилсэн шинжилгээнд микрометрээр хэмжиж дараагийн хэсэгчилсэн шинжилгээнд Полякын шугамаар хэмжив.

5. Бүх тохиолдолд нүдний даралтыг Маклаковын тонометрийн 5,10 граммын туухайгаар үзэв.

Уул аргаар хийсэн шинжилгээний дүн нь тонометрийн дардасны диаметрийг микрометрээр хэмжиж нүдний даралтны дундаж холбогдлыг А.П. Нестеров, М.Б. Бургафтын таблицаар гаргахад манайд 40-өөс дээш насны эрүүл хүмүүсийн нүдний даралтны статистикийн дундаж нь зөвлөлтийн ба олон улсын судлаачдын дунджаас 3—4 мм М.У.Б даралтаар илүү байна гэсэн дүгнэлт хийхэд хүргэсэн юм (6).

Учир нь бидний хийсэн шинжилгээнд тонометрийн дардасны диаметрийн дундаж хэмжээ нь зөвлөлтийн судлаачдын дунджаас 0,25—0,36 мм-ээр бага байв. (2). Үүнээс үндэслэн нүдний даралтыг үзэж байгаа бидний арга буруу байж болохыг шалгах зорилгоор тонометрийн дардасыг Полякын шугамаар хэмжсэн 5,10 граммын тонометрийн даралтнаас нүдний дотоод бодит даралтыг олох Москва хотын Гельмо-

гольцын нэрэмжит институтээс боловсруулсан тусгай хүснэгтийг (5) ашиглан нүдний дотоод бодит даралт (P_0)-ыг олж статистикийн боловсруулалт хийхэд P_0 нь 16,1 мм М.У.Б. даралттай тэнцүү буюу олон улсын дундажтай тохирч байв (5,6). Гэвч тонометрийн дардасны диаметрийг Полякын шугамаар хэмжихэд А.П. Нестеровын аргаар нүдний шингэний урсгалын хурдацын коэффициентийг тодорхойлох, аль ч тонометрээр үзсэн нүдний дотоод бодит даралтыг олж болохгүй учир шинжилгээ нь хязгаарлагдмал болохын хамт Полякын шугамыг ашигласнаар нарийн шинжилгээ хийхэд бас алдаа гарч болзошгүй. байлаа. Үүнээс үндэслэн нүдний даралтыг хэмжих аргын онолын зарим асуудалтай ямар нэг хэмжээгээр танилцах шаардлага гарсан юм.

М.Б. Вургафт (1971) Маклаковын тонометрээр даралтыг үзэх оношилж асуудлыг хөгжүүлэн тонометрийн жингээс дардасны хэмжээ яаж хамаардагийг доорхи тэгшигэлээр илэрхийлжээ (1).

$$1gW_2 - 1gW_1 = (D_2 - D_1) \cdot K; W_2, W_1 - \text{тонометрийн жин.}$$

D_2, D_1 -жин тус бүрийн дардасны диаметрийн хэмжээ. К-Нүдний даралт хэвийн байх үед 0,25, нүдний даралт ихсэх глауком өвчний үед 0,22-тай тэнцүү тогтмол тоо. Дээрх тэгшигэлийн байрыг сольж даарахаа тэгшигэлийг гаргажээ. $1gW_1 = 1gW_2 - (D_2 - D_1) \cdot K$

Эрдэмтэн Гольдман нүдний эвэрлэг дээр тонометрээр дарахад дардасны диаметр нь 3,06 мм хүртэл хэмжээтэй байх үед тонометрийн даралт (P_t) ба бодит даралт (P_0) нь хоорондоо тэнцдэг болохыг тогтоож нүдний дотоод бодит даралт (P_0)-ыг олох тохиромжтой нөхцөл бүрдэнэ гэж үзсэн байна. Үнд 3,06 мм дардас үүсгэж байгаа тонометрийн граммын жинг 10-аар үржүүлэхэд нүдний дотоод бодит даралтын хэмжээ гарна гэж тогтоожээ (1).

М.Б. Вургафт Маклаковын тонометрээр нүдний даралт үзэх үед тонометрийн будаг нулимсанд угаагдаж эвэрлэгийн хавтгайлтаас үүссэн дардасны хэмжээ 0,4 мм-аар ихэнэ гэж үзсэн байна. Ингээд М.Б. Бургафт нь нүдний даралтыг Маклаковын тонометрээр үзэх үед Гольдманы нүдний дотоод бодит даралт нь тонометрийн даралттай тэнцүү болох үеийн 3,06 мм-ын дардасны хэмжээн дээр 0,4 мм-ийг нэмж 3,46 мм болгоод тонометрийн жин нь хэдэн грамм байхад 3,46 мм-ийн диаметртэй дардас үүсгэхийг олж улмаар нүдний даралтыг (P_0) олсон байна. Үүнчлэн тонометрийн дардасны диаметрийн байж болох бүх хэмжээнд тохирох тонометрийн жингүүдийг тодорхойлж 10-аар үржүүлж нүдний дотоод бодит даралт P_0 -ыг олох тусгай таблицыг гаргажээ.

Нүдний тонометрийн даралтыг олох тэгшигэлийг эрдэмтэн Фриденвальд (1937) гаргасан байна (3). $1gP_t = 1gP_0 + EV_c$. P_t -нүдний тонометрийн даралт P_0 -нүдний дотоод бодит даралт (М.Б. Вургафтын тэгшигэлээр олно.) Е-нь нүдний уян хатан чанар.

Нестеровын тодорхойлсноор тэр нь 0,0200 (1). V_c — даралт үзэх үед үүсэх камерын шингэний шилжилтийн багтаамж (3). Эрдэмтдийн хийсэн дээрх бүтээлүүдийг ашиглан эрүүл хүмүүсийн нүдэнд эластотонометрийн шинжилгээ хийж тонометрийн жин тус бүрийн дардасны диаметрийн дунджийг статистикийн аргаар гаргаж М.Б. Вургафтын (I) хийсэн судалгаатай харьцуулж үзэв.

Бидний хийсэн шинжилгээгээр эластотонометрийн дардасны диаметрийн хэмжээ М.Б. Вургафтын эластотонометрийн дардасны диаметрийн хэмжээнээс 0,35 мм-ээр бага байгаагаас бид нулимсны цагирагийг дунджаар 0,05 мм байна гэж үзээд нүдний тонометрийн даралт нь нүдний дотоод бодит даралттай тэнцэх үеийн тонометрийн дардасны хэмжээг Гольдманы олсон 3,06 мм дээр 0,05-ийг нэмж $D_1 = 3,11$ мм гэж үзсэн юм.

Нүдний даралт үзэх үед үүсдэг нулимсны цагираг нь бидний шинжилгээнд 0,05 мм буюу маш бага хэмжээтэй байгаагаас нүдний дарал-

Эрүүл хүмүүсийн нүдэнд хийсэн эластотонометрийн
шинжилгээний тонометрийн дардасны диаметрийн
статистикийн дундаж, -дараалтны холбогдлыг
М.Б. Вургафтын судалгаатай харьцуулбал:

	М.Б. Вургафтын судалгааны дүн				Бидний хийсэн судалгааны дүн			
Тонометрийн жин. гр.	5,0	7,5	10,0	15,0	5,0	7,5	10,0	15,0
Дардасны дундаж хэмжээ мм	5,35	6,05	6,55	7,25	5,04 5,05	5,7 6,2	6,35 6,85	
σ-мм	0,31	0,30	0,31	0,32	0,34	0,35	0,27	0,31
Нүдний дотоод бодит даралт	16,8	16,8	16,9	17,0	16,4 16,3	16,8 16,9	15,4 17,8	
Хэсэгчлэн хийсэн шинжилгээнд хамрагдсан нүдний тоо	700	600	685	700	766	—	848	—
P_0 -ийн байж болох хязгаар	—	73	85	85	106	103	104	106
P_t -ийн байж болох хязгаар					13,3 20,0	14,1 21,2	14,1 20,0	14,1 20,0

тыг тонометрийн дардасны диаметрийн хэмжээгээр илэрхийлэхэд зориулагдсан А.П. Нестеров, М.Б. Вургафтын хэмжилтийн (калибривкын) таблицыг ашиглахад манайд нүдний даралт хэвийн хэмжээнээс ихсэж байна гэж үзэв. Үүл таблицыг шууд хэрэглэх боломжгүйнээс дорхой болсноос бид өөрийн хийсэн шилжилгээнд тулгуурлан нүдний дотоод бодит даралт (P_0)-ыг олох М.Б. Вургафтын тэгшитгэл, нүдний тонометрийн даралтыг олох Фриденвальдын тэгшитгэлүүдийг ашиглан А.П. Нестеров, М.Б. Вургафтын нүдний тонометрийн ба бодит даралтыг зориулсан таблицтай төстэй таблицыг хийхийн хамт тонографийн шинжилгээний үзүүлэлтүүдийг шинэчлэн бодож тусгай таблиц болгон гаргав. (Таблиц 2,3,4)*

Бид А.П. Нестеровын аргаар 15 граммын тонометрээр тонографийн шинжилгээг 40-өөс дээш насны 30 хүний 59 нүдэнд хийж үзэхэд нүдэнд шахалт үзүүлэхийн өмнөх тонометрийн дардасны статистикийн дундаж $M=6,8$ мм. $\sigma=\pm 0,29$ $t=\pm 0,038$ байв. Нүдэнд шахалт үзүүлсний дараах 15 граммын тонометрын дардасны дундаж $M=7,4$ мм

Хүснэгт 2
Тонометрийн даралт (мм МУБ)

Δ	ТОНОМЕТРИЙН ЖИН / ГР/			
	5	7.5	10	15
3.2	47.8			
3.3	45.3			
3.4	42.9	64.4		
3.5	40.6	60.8		
3.6	38.2	57.6		
3.7	36.3	54.4	72.6	
3.8	34.4	51.6	68.8	
3.9	32.7	49.7	65.3	
4.0	30.9	46.4	61.9	
4.1	29.3	44.0	58.7	
4.2	27.8	41.7	55.7	
4.3	26.3	39.5	52.8	
4.4	25.0	37.5	50.1	
4.5	23.9	35.5	40.7	71.7
4.6	22.7	34.1	45.5	68.3
4.7	21.7	32.4	43.3	65.0
4.8	20.7	30.9	41.3	61.9
4.9	19.6	29.5	39.3	59.0
5.0	18.7	28.1	37.5	56.2
5.1	17.7	27.1	35.7	52.7
5.2	17.2	25.4	33.9	51.0
5.3	16.1	24.3	32.4	48.6
5.4	15.4	23.2	30.7	46.5
5.5	14.8	22.8	29.8	44.5
5.6	14.2	21.3	28.5	42.8
5.7	13.5	20.4	27.2	41.0
5.8	13.1	19.7	26.3	39.4
5.9	12.8	18.9	25.2	37.9
6.0		18.1	24.3	36.5
6.1		17.6	23.4	35.1
6.2		16.9	22.7	33.9
6.3		16.4	21.9	32.8
6.4		15.8	21.2	31.9
6.5		15.3	20.4	30.7
6.6		14.9	20.0	29.8
6.7			19.3	26.8
6.8			18.4	28.1
6.9			18.3	27.6
7.0			17.9	26.9
7.1			17.6	26.4
7.2				25.7
7.3				25.4
7.4				24.7
7.5				24.3
7.6				23.9
7.7				23.5
7.8				22.9

Хүснэгт 3
Нүдний дотоод бодит даралт(мм. МУБ)

Δ	ТОНОМЕТРИЙН ЖИН / ГР/			
	5	7.5	10	15
3.2	47.4			
3.3	44.7			
3.4	42.2	63.3		
3.5	39.9	59.8		
3.6	37.6	56.4		
3.7	35.5	53.3	71.1	
3.8	33.3	50.3	67.1	
4.9	31.7	47.5	63.3	
4.0	29.9	44.8	59.8	
4.1	28.2	42.3	56.4	
4.2	26.6	39.9	53.3	
4.3	25.1	37.6	50.3	
4.4	23.7	35.6	47.5	71.2
4.5	22.4	33.6	44.8	67.3
4.6	21.1	31.7	42.3	63.5
4.7	20.0	29.9	39.9	59.9
4.8	18.9	28.3	37.7	56.6
4.9	17.8	26.7	35.6	53.9
5.0	16.8	25.2	33.6	50.4
5.1	15.0	23.3	31.7	47.5
5.2	15.0	22.4	29.9	44.9
5.3	14.1	21.2	28.3	42.4
5.4	13.3	20.0	26.4	40.0
5.5	12.2	18.9	25.2	37.8
5.6	11.9	17.8	23.8	35.7
5.7	11.2	16.8	22.4	33.7
5.8	10.6	15.9	21.2	31.8
5.9	10.2	15.0	20.0	30.0
6.0		14.1	18.8	28.3
6.1		13.4	17.8	26.7
6.2		12.6	16.9	25.2
6.3		11.9	15.9	23.8
6.4		11.2	15.0	22.5
6.5		10.6	14.1	21.2
6.6		10.0	13.4	20.0
6.7			12.6	18.8
6.8			11.9	17.8
6.9			11.2	16.9
7.0			10.6	15.9
7.1			10.0	15.0
7.2				14.1
7.3				13.4
7.4				12.6
7.5				12.2
7.6				11.9
7.7				10.6
7.8				10.0

Хүснэгт 4А.П. Нестеровын хялбарчилсан аргаар хийсэн тонографийн шилжилгээний үнд сэн үзүүлэлтүүд Тонометрийн жин 15 гр. Нүдэнд шахалт үзүүлэх хугацаа 4 минут

$\sigma = \pm 0,44$, $m = \pm 0,05$ байв. Энэ дундгийг бидний гаргасан хүснэгтээр тооцож үзэхэд тонографийн шинжилгээний үзүүлэлт нь:

$P_0 = 17,8$, $C = 0,27 \text{ mm}^3$, $F = 2,1 \text{ mm}^3$ Беккерын коэффициент -65. Энэ шинжилгээрийг дүн нь бидний (Японы Тос-ЕЕ-0,13) электрон аппаратаар 40-өөс дээш насы 41 эрүүл хүний 82 нүдэнд хийсэн нүдний шингэний ургалын хурдацын коэффициент (УХК) $C = 0,28 \text{ mm}^2$ байсантай үндсэндээ тохирч байна (7). А.П. Нестеровынхаар (4) УХК нь $0,29 \text{ mm}^3$ байжээ.

ДҮГНЭЛТ

1. А.П. Нестеров, М.Б. Вургафт нарын нүдний даралтыг хэмжихэд зориулж гаргасан калиброкын арга нь нүдний даралтны бүх төрлийн шинжилгээг үнэн зөв хийх боломж олгож байгаа боловч бидний хийсэн шинжилгээнд тонометрийн дардасны хэмжээ эрс бага байгаагаас уг таблицыг шууд хэрэглэх боломжгүй байна.

2. Бидний дээр дурдсан аргаар шинжилгээг явуулахад А.П. Нестеров, М.Б. Вургафт (3) зэрэг эрдэмтний үзсэнээр нүдний даралтыг үзэхэд алдаа гаргах гол эх үүсвэр нь болсон нулимсны цагирагийг тонометрийн бүх жинд ижил хэмжээгээр багасгаж байгаа болохоор түүнд тохирсон таблицыг зохих үндэслэлтэйгээр гаргах нь зүйтэй гэж үзлээ.

Эрдэмтдийн хийж гүйцэтгэсэн бэлэн материалд тулгуурлан бидний гүйцэтгэсэн энэ өчүүхэн ажлын шалгуур нь практик үйл ажиллагаа учраас энэ талаар эрдэмтэд, эмч мэргэжилтнүүд саналаа ирүүлнэ гэдэгт найдаж байна.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. М.Б. Вургафт—Офтальмол. Журн. 1971. 3. 342
2. Г.А. Киселев, Л.Б. Таняшина—В.О. 1972. 2. 25
3. А.П. Нестеров, М.Б. Вургафт—Вест офтальмол. 1972.
4. А.П. Нестеров—Первичная глаукома 1982. М. Медицина. 70.
5. Министерства здравоохранения РСФСР. „Организация активного выявления и ранней диагностики глаукомы“ 1978. 21.
6. Э. Довдон—40-өөс дээш насы хүмүүсийн нүдний тонометрийн ба даралтын дундаж. Анагаах ухаан. 1982. 3. 34.
7. Э. Довдон—Глауком өвчтэй ба эрүүл хүмүүсийн нүдэнд хийсэн электронографийн шинжилгээний дүн. Анагаах ухаан. 1985. 2.

ХОВОР ТОХИОЛДОЛ

Н. НЯМАА, Д. ГОМБОЖАВ

(Завхан аймгийн нэгдсэн эмнэлэг)
(Завхан аймгийн мал эмнэлгийг удирдах газар)

ҮХРИЙН АРЬСНЫ ГУУР

Завхан аймгийн Улиастай хотын харьяат Б.Г. 8 настай, эрэгтэй. Сургуулийн сурагч. Зүйнхаа амралтаар хөдөө амарч мал аж ахуйн ажилд тусалдаг байсан.

Хүүхэд сэргэлэн цовоо, бие бялдарын өсөлт хөгжилт насандaa тохирсон. Хүүхэд өгүүлэхдээ, амраад ирсний дараахан улан дээр гүвдрийн маягийн юм гарч, дараа нь цавь, сувээ, эрүүний орчим овойж, түрүүчийнх нь арилж байсан гэв. Дарж үзэхэд хөндүүргүй, арьсны ёнгө хэвийн байв. Удалгүй дагзны ар хэсэгт гүвдрийн гарч хөндүүрлэн буглаж нүх гарч цоорood, нүхээр нь шүүслэг шингэн ялгарч, өт шиг юм цухуйж, түүнийг ээж нь сугалж авчээ. Ингээд хүүхдийн эмчид үзүүлж, мал эмнэлгийн лабораторт шинжилгээ өгснөөр үхрийн гуурын авгалдайн I үелбэр гэсэн хариу гарчээ. Гүрүүчийн гүвдрийн гарсан газрын дээд хэсэг мөн овойж буглан жижиг сув гарч түүнээс нь идээлэг шүүс гарсан байна. Түүнийг нь зүслэг хийхэд бага зэргийн цайвар ёнгийн шүүс, өт мэт зүйлийг авав. Энэ нь 0,6 см урттай, эржгэр үе бүхий зүйл байв. Шинжлүүлэхэд III үелбэрийн үхрийн гуурын авгалдай гэсэн хариу гарав.

Иймээс хүүхдэд харшил намдаах, биеийн эсэргүүцлийг сайжруулж, цус бүлэгнэлтийг идэвхжүүлэх эмчилгээг 21 хоног гэрээр хийж ажиглахад хүүхдийн арьс, толгойн хэсэгт гүвдрийн дахин гаралгүй, биеийн байдал сайжирсан болно.

Гиподермийн авгалдайнууд хүнийг гууртуулах нь цөөнгүй тохиолддог ажээ. Гиподермийн ихэнх авгалдай хүний толгойд нэвтрэн ордог нь санамсаргүй тохиолдол биш юм. Эдгээр нь үхэрт яргадгийнхаа нэгэн адил дээш яргадаг учраас толгойд ордог байна. Авгалдай арьсан дор нэвтрэн орсны дараа бие махбодоор 7—8 сарын турш яргана. Хүний арьсанд улаавтар буюу хөхөвтөр ёнгөтэй хавдар үүссэнээр авгалдай арьсан дор байрласны анхны шинж тэмдэг илэрнэ. Анхны хавдар арилахад түүний дээд талд шинэ хавдар үүсэж байр нь олон дахин солигдоно. Өвчний эцсийн шатанд хүний бие сульдаж толгой өвдөх, байн байн халуурах, цусны улаан бөөм цөөрч, цагаан бөөм олширно.

Энэ үед хавдар нь хатиг маягтай болж хувирдаг байна.

Редакцийд ирсэн 1986,01.2⁹

ЭРДЭМТДИЙН ДУГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

1986 ОНД АНАГААХ УХААНЫ ДЭД ЭРДЭМТНИЙ ЗЭРЭГ ХАМГААЛСАН ЭРДЭМТЭЛ

Рагчаагийн Бямбаа (Говь—Алтай аймгийн Эрүүлийг хамгаалах газрын дарга)

Зэрэг хамгаалсан сэдэв: „БНМАУ-ын хөдөөгийн хүн амд үзүүлэх эх барих тусlamжийн зохион байгуулалтын зарим асуудлууд“

Хамгаалсан газар, он сар, өдөр: Улаанбаатар, 1986 оны 12 дугаар сарын 11.

н. Бямбаа энэхүү нэг сэдэвт бүтээлдээ манай улсын хөдөөгийн хүн амд үзүүлэх эх барихын тусlamжийн зохион байгуулалтыг боловсронгуй болгоход чиглэсэн шинжлэх ухааны үндэслэлийг судлан тогтоожээ.

Намжилын Даваацэрэн (Анагаах ухааны дээд сургуулийн мэс заслын тэнхимиийн багш).

Зэрэг хамгаалсан сэдэв: „Хүний шохойжсон бэтгийн эмнэл зүй, оношлогоо, эмчилгээ“

Хамгаалсан газар, он, сар, өдөр: Улаанбаатар, 1986 оны 6 сарын 19.

н. Даваацэрэн энэхүү нэг сэдэвт бүтээлдээ хүний шохойжсон бэтгийн эмнэл зүй, оношлогооны арга болон мэс заслын эмчилгээний орчин үеийн арга барилыг тусгасан нь практикийн эмч нарт ашиг тустай бүтээл болсон байна.

Цэрэндоржийн Содномпил (Эрүүлийг хамгаалах Яамны ажилтан)

Зэрэг хамгаалсан сэдэв: “БНМАУ-ын Эрүүлийг хамгаалахын удирдах байгууллагуудын ажлын зохион байгуулалт, түүнийг боловсронгуй болгох арга зам“

Хамгаалсан газар, он, сар, өдөр: Москва, 1986 оны 10 сарын 21.

н. Содномпил энэхүү нэг сэдэвт бүтээлдээ шинжлэх ухаан техникийн дэвшил эрчимтэй явагдаж буй орчин үед эрүүлийг хамгаалахын удирдлагыг боловсронгуй болгох асуудал нэн чухал юм. Энэ судалгааны ажлаар эрүүлийг хамгаалахын удирдах системийг шинжлэх ухааны үндэстэй, системт судалгааны аргаар судлаж, уг системийг боловсронгуй болгох арга замыг тодорхойлжээ. Эрүүлийг хамгаалахын удирдлагыг боловсронгуй болгоход тооцоолон бодох техник нэвтрүүлэх явдал зайлшгүй чухал болохыг тогтоож, түүнийг БНМАУ-ын Эрүүлийг хамгаалахад нэвтрүүлэх үндсэн чиглэл, арга замыг тодорхойлсон байна.

Мөн эрүүлийг хамгаалахын удирдах системд хяналтын автомат систем (ХАС) нэвтрүүлэх асуудлыг боловсруулсан байна.

Мунтагийн Сүхбаатар (Анагаах ухааны дээд сургуулийн хүүхдийн өвчин судалалын тэнхимиийн багш)

Зэрэг хамгаалсан сэдэв: „Хүүхдийн уушгины цочмог үрэвслийн үеийн цус бүлэгнэлт, ялтсан эсийн өөрчлөлт“.

Хамгаалсан газар, он, сар, өдөр: Ленинград, 1986. 06. 18.

н. Сүхбаатар энэхүү нэг сэдэвт бүтээлдээ хүүхдийн уушгины цочмог үрэвслийн нийт цус бүлэгнэлтийн өөрчлөлтийг өвчиний явц, үе шат, хүндрэл зэргээс шалтгаалан өөрчлөгддөг болохыг тогтоон эмчилгээний зарчим боловсруулжээ. Түүнчлэн уг өвчиний үед ялтсан эсийн өөрчлөлтийг судлан тогтоожээ. Уушгины цочмог үрэвслийн үеийн цусны

бичил эргэлтийн хямралыг зохицуулахын тулд гепарин эмчилгээг, ялтсан эсийн өөрчлөлтийг засахад аспирин эмчилгээг хэрэглэсэн нь өвчин хүндрэхээс сэргийлэх арга хэмжээ болсон байна. Хүүхдийн уушгины цочмог үрэвслийн үеийн судасны дотор тод цус нэлэнхүй бүлэгнэх үйл ажиллагааг тогтоосон нь онолын төдийгүй эмнэл зүй, эмчилгээний чухал ач холбогдолтой ажил болжээ.

Галсан-Эндонгийн Сүхбат (Анагаах ухааны дээд сургуулийн физиологийн тэнхимийн багш)

Зэрэг хамгаалсан сэдэв: „Дельта-сон пептид сөрөг сэтгэл хэдлэлийн төвийн механизмын“

Хамгаалсан газар, он, сар, өдөр: Москва, 1986 оны 5 сарын 21.

Н. Сүхбат энэхүү нэг сэдэвт бүтээлдээ „Дельта-сон пептид“ хэмээн нэрлэгддэг нейропептид нь сөрөг сэтгэл хэдлэлийн үед харааны доод төвгөр болон тархины торлог байгууламжаас их тархины гадарт үзүүлэх өгсөх, идэвхжүүлэх нөлөө, тэрчлэн сөрөг сэтгэл хэдлэлийн үед илрэх вегетатив өөрчлөлтүүдийг дарангуйлдаг болохыг судлан тогтоожээ.

Дондоогийн Тамжидмаа. (Улсын шүүх эмнэлгийн магадлах товчоо) Зэрэг хамгаалсан сэдэв: “АВО ба Левисийн системийн эсрэг төрөгчийг шинжилснээр ялгаруулагчийн шалгуурыг тогтоох нь”

Хамгаалсан газар, он, сар, өдөр: Москва, 1986 оны 10 сарын 27.

Н. Тамжидмаа энэхүү нэг сэдэвт бүтээлдээ шүүх эмнэлгийн хянан магадалгааны боломжийг нэмэгдүүлэх зорилгоор ялгаруулагчийн зэрэгийг тодорхойлох оношийн шинэ сорилуудыг үндэслэжээ. Ялгаруулагчийн зэргийг тодорхойлох эдгээр аргачлалууд нь ихээхэн үр дүнтэй болсон байна.

П. БАТХҮҮ (Анагаах ухааны дээд сургууль)

ХОТЫН ХҮҮХДЭД АМБУЛАТОРИ-ПОЛИКЛИНИКООР ҮЗҮҮЛЭХ ТУСЛАМЖИЙН ХЭМЖЭЭ, ХЭРЭГЦЭЭ

Дүгнэлт: 1. Хүүхдэд амбулатори-поликлиникоор үзүүлж байгаа тусlamжийг райончилон зохион байгуулсан болэвч поликлиник, хэсгийн эмнэлэг, стационарын үйл ажиллагаа салангид байна.

2. Улаанбаатар хотын 0—15 насны хүүхдийн ерөнхий өвчлөлийн түвшин эмнэлгийн тусlamж эрэлтээр 1000 хүүхэд тутамд 1017,8 байгааг насны бүлгээр тодорхойлоход 1 хүртэлх насанд хамгийн өндөр (6726,8) дараа нь 1—2 насанд (2506,4) тохиолдож байгаа бөгөөд 3-аас дээш насанд хүүхдийн өвчлөл алгуур буурч байна.

3. Амьсгалын эрхтэний (600,9), хоол боловсруулах эрхтэний (180,6), бодисын солилцооны (65,0) халдварт ба паразитын (50,9), чих, хамар хоолойн (47,3), нярайн өвчинүүд (25,9) хамгийн элбэг тохиолдож, өвчлөлийн бүтцэнд эхний зургаад байгаа буюу зөвхөн амьсгалын эрхтэний өвчинүүдийн эзлэх хувийн жин (59,0%), хоол боловсруулах эрхтэний өвчинүүдийн эзлэх хувийн жин (17,7%) нийлээд нийт өвчлөлийн 76,7%-ийг эзэлж байна.

4. Бүх насны хүүхдэд чих, хамар хоолойн өвчин элбэг тохиолдож байгаагийн дотор зонхилох нь дунд чихний хурц ба архаг явцтай улайх, идээт үрэвслүүд (5,7—30,3), хамрын салстын үрэвсэл (3,4—87,3) байна.

5. Хоёр хүртэлх насны хүүхэд халдварт өвчинөөр хамгийн элбэг (188,7) өвчилж байгаа бөгөөд энэ насанд салхин цэцэг, томуу, цусан суулга, менингококкын халдварууд, 3—7 насанд томуу, менингокок-

кын халдварт, салхин цэцэг, цусан суулга тус тус зонхилон тохиолдож байгаа боловч, 0—7 наасны хүүхдэд тохиолдож байгаа халдварт өвчиний бүтцэнд халдварт гепатит тэргүүн байранд орж байна. Харин сургуулийн наасны хүүхдэд томуу, томуу төст өвчин, халдварт гепатит, менингококкын халдварт давамгайлан тохиолдож байна.

6. Нярайн өвчлөл 1000 нарай тутамд 335,6 байгаагийн зонхилохыг хүйсний үрэвсэл (192,0), нярайн үжил (135,0) эзэлж байна.

7. Судалгаанд хамрагдсан 0—15 наасны хүүхдэд эмгэг байдал 1000,0-д 996 байнаас шинээр илэрсэн далд хэлбэрийн өвчнүүд 713,3 байгаа нь Улаанбаатар хотын 0—15 наасны хүүхдийн ерөнхий өвчлөлийн түвшин 1000 хүүхэд тутамд 1731,1 байгааг харуулж байна.

8.3—7 наасны хүүхдийн эмгэг байдал өндөр (1513,5) байгаа нь эцэг эхийн асаргаа, эмнэлгийн тусламж авах байдал, З хүртэлх наасны хүүхдэд нэлээд сайн, З нааснаас эхлэн суларч байгаатай холбоотой байна. Сургуулийн өмнөх наасны хүүхдэд хөнгөн ба далд хэлбэрийн өвчнүүд элбэг тохиолдож байна.

9. 1000 хүүхэд тутмаас 119,3 нь эмнэлэгт хэвтэж эмчлүүлж байгааг наасны бүлгээр тодорхойлоход 1 хүртэлх насанд хамгийн өндөр 588,7; дараа нь 1—2 насанд 191,1 байна.

10. Хүүхдийн поликлиник, хэсгийн эмч нар ажлын цагийн 77,8%—83,9%-ийг үр бүтээлт хөдөлмөрт, үүнээс нарийн мэргэжлийн эмч нар 66,3%-ийг, хэсгийн эмч нар 49,4%-ийг өвчтөн үзэж, оношлох, эмчлэхэд зарцуулж байгаа нь эмч нар эмнэлгийн бичиг баримт хөтлөхөд их цаг (25,2%—43,2%) зарцуулж байгаатай холбоотой байна.

11. Хүүхдийн эмч нар үр бүтээлтэй хөдөлмөрт зарцуулсан цагийн нэлээд хэсгийг (26,7%—27,4%) эмчилгээ оношлогоосны бус ажилд зарцуулж байна. Үүний 16,7%—75,0%-ийг хурал, цуглаан, олон нийтийн ажилд зарцуулсан буюу үр бүтээлтэй бус хөдөлмөрт ажлын цагийн 16,1%—22,2%-ийг зарцуулж байгаагийн ихэнх нь өвчтөн хүлээхтэй холбоотой байсан нь эмчийн хөдөлмөр зохион байгуулалт буруу байгааг харуулж байна.

12. Нэг өвчтөн үзэхэд нарийн мэргэжлийн эмч дунджаар $3,62 \pm 0,13$ минут, хэсгийн эмч $2,07 \pm 0,05$ минут тус тус зарцуулсан байхад бичиг баримтын хөтлөлтөнд үүнээс илүү хугацаа ногдож байгаа нь өвчтөнийг бүрэн үзэж шинжлэхэд бага хугацаа зарцуулж байгааг харуулж буйна.

Зөвлөмж: 1.3 хүртэлх наасны хүүхдийн өвчлөлийг бууруулах асуудал амбулагори-поликлиникт ажиллаж байгаа хүүхдийн эмч нарын гол зорилт тул эрүүл ахуйч, халдвартын эмч мэргэжилтнүүдтэй хамтран өвчлөл эндэгдлийн зонхиилс шалтгазн болж байгаа өвчнүүдээс сэргийлэх, бууруулах нэгдмэл аргачлал боловсруулж мөрдөх.

2,0—15 наасны хүүхдийн өвчлөлийг тууштай бууруулах, тэдэнд амбулатори поликлиникоор үзүүлэх тусламжийн чанарыг сайжруулахын тулд хариуцлагатай, дадлага туршлагатай, хүүхдийн эмч нарыг хэсэг, поликлиникт ажиллуулж, хэсгийн эмнэлгийн хүчин чадал, эмчийн ажлын ачааллыг зөв зохицуулахын зэрэгцээ районы поликлиникийг урьдчилан сэргийлж оношлон эмчлэх, улсын хүүхдийн төв поликлиникийг оношлон эмчлэх зөвлөх поликлиникийн түвшинд ажиллуулах, эмчийн хөдөлмөрийг шинжлэх ухааны үндэстэй зохион байгуулах шаардлагатай байна.

ЦУСНЫ ДАРАЛТ ИХДЭХ ӨВЧНИЙ ЯВЦАД ЦАГ АГААРЫН ЗАРИМ ХҮЧИН ЗҮЙЛИЙН НӨЛӨӨ

Дүгнэлт: 1. Цусны даралт ихдэх өвчтэй хүмүүс бусад өвчин эмгэгтэй хүмүүстэй харьцуулахад цаг агаарын хэлбэлзлийг илүүтэй мэдрэн өвчин нь сэдэрдэг болох нь Улаанбаатар хотын түргэн тусламжийн станцын олон жилийн үйл ажиллагааны байдлаас харагдav.

Цусны даралт ихдэх өгчтэй хүмүүсийн 72% нь цаг агаарын хэлбэлзлийг мэдрэн ямар нэг байдлаар хариу урвал үзүүлж байна.

2. Цусны даралт ихдэх өвчний ноцтой хүндрэл (криз, инсультууд) цаг агаарын хүчин зүйлүүдийн хэлбэлзэл ихтэй хаврын улиралд илэрхий элбэгшиж байв.

3. Цусны даралт ихдэх өвчний явц хүндэрснээс эмнэлэгт хэвтэх тохиолдол өвөл, хаврын улиралд ихсэж байгаа бөгөөд өвчний I, II үед буй хүмүүс хавар, III үед буй хүмүүс өвлийн улиралд олонтоо хэвтэж байна.

4. Цаг агаарын зарим хүчин зүйлийн хэлбэлзлийг цусны даралт ихдэх өвчтэй хүмүүсийн хөдөлмөрийн чадвар алдаж байгаа тохиолдолтой харьцуулан ажиглахад агаарын даралтын хэлбэлзэл бусдаас илүүтэй нөлөөлж байгаа нь батлагдаж байна.

5. Цаг агаарын хүчин зүйлүүдийн хэлбэлзэл ихэсдэг үеийг угтуулан цусны даралт бууруулах эмчилгээг сэргийлэх чиглэлээр явуулах нь цусны даралт ихдэх өвчтэй хүмүүсийн хөдөлмөрийн чадвар алдах тохиолдлыг цөөрүүлэх, улмаар өвчний ноцтой хүндрэлүүдээс сэргийлэхэд ач тусаа өгч байна.

6. Оюуны хөдөлмөр эрхэлдэг насанд хүрсэн хүмүүсийн дотор цусны даралт ихдэлт 17,9%-д тохиолдох байна.

7. Цусны даралт ихдэх өвчний үе шатыг тогтоох болон тархины цусан хангамжийн байдлыг тодорхойлоход тархины цахилгаан бичлэг (РЭГ) болон цусны даралт ихдэх өвчний гемодинамикийн төрлийг тогтоож эмчилгээг сонгон явуулахад зүрхний эзэлхүүн, захын судасны эсэргүүцлийг илэрхийлэх интеграль реографийн шинжилгээ ихээхэн ач холбогдолтой байв.

Зөвлөмж: 1. Цусны даралт ихдэх өвчтэй хүмүүст цаг агаарын хэлбэлзлийг мэдрэх чадвар өндөр байгааг харгалзан үзэж цаг агаарын хүчин зүйлуу-(агаарын даралт, салхи, температур)-дийн хэлбэлзэл ихтэй байдаг өвөл, хаврын улиралд сэргийлэх зорилгоор даралт бууруулах эмчилгээг тасралтгүй явуулах шаардлагатай байна.

1. Цусны даралт ихдэх өвчтэй хүмүүст цаг агаарын хүчин зүйлийн хэлбэлзэл илэрхий муугаар нөлөөлж буй учир цаашид эмчлэн сэргийлэх ажлыг энэ чиглэлээр өргөн хүрээтэй зохион явуулах нь зүйтэй байна.

3. Оюуны хөдөлмөр эрхэлдэг хүмүүсийн дотор цусны даралт ихдэх өвчний тохиолдол элбэг байгааг харгалзан үзэж тэдний дунд зохиох урьдчилан сэргийлэх ажлыг улам сайжруулах шаардлагатай байна.

МАХН-ЫН ХIX ИХ ХУРЛЫН ШИЙДВЭР АМЬДРАЛД

ҮНДЭСНИЙ БАГА ХУРАЛ

МАХН-ЫН ХIX ИХ ХУРЛААС ЭРҮҮЛИЙГ ХАМГААЛАХ САЛБАРЫН ОДООГИЙН БАЙДАЛ ГҮН ГҮНЗГИЙ ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙЖ, ШИЭ ЗОРИЛТУУДЫГ ДЭВШҮҮЛЭН ТАВСАН БИЛЭЭ. ДЭВШҮҮЛСЭН ЗОРИЛТЫГ АМЬДРАЛД БҮТЭЭЛЧЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛГООР ЭРҮҮЛИЙГ ХАМГААЛАХ ЯАМНААС „МАХН-ЫН ХIX ИХ ХУРЛААС ЭРҮҮЛИЙГ ХАМГААЛАХ ТАЛААР ДЭВШҮҮЛСЭН ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМ“, СЭДЭВТ ОНОЛ ПРАКТИКИЙН БАГА ХУРАЛ, ДЭХБ-ЫН ЗҮҮН ӨМЧӨД АЗИЙН БҮСИЙН ХОРООТОЙ ХАМТРАН „АМБУЛАТОРИ ПОЛИКЛИНИКИЙН ТУСЛАМЖ, ДИСПАНСЕРЧЛАЛ“ СЭДЭВТ ҮНДЭСНИЙ БАГА ХУРАЛ ХИЙВ.

Бага хуралд МАХН-ЫН ТӨВ Хорооны нарийц бичгийн дарга Ц. Балхажав, хэлтсийн эрхлэгч З. Даашзвэр, ЭХЯ-НЫ САЙД Ч. Цэрэннадмид нар болон аймаг, хотын эрүүлийг хамгаалах газрын дарга, эмч, мэргэжилтэн, эрдэм шинжилгээний ажилтнууд оролцлоо.

Тус хуралд ЭХЯ-НЫ САЙД Ч. Цэрэннадмид „МАХН-ЫН ХIX ИХ ХУРЛЫН ШИЙДВЭРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХД ЭРҮҮЛИЙГ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ЗОРИЛТ“ ГЭСЭН ИЛТГЭЛ ТАВСАН ИЛТГЭЛДЭЭ: „СОЦИАЛИСТ ЭРҮҮЛИЙГ ХАМГААЛАХЫН ҮНДСЭН ЗОРИЛТ БОЛ ХҮН АМЫГ АЛИВАА ӨВЧИӨӨС СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛ ЮМ. УРДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫН ГОЛ ШАЛГАРСАН АРГА БОЛ ХҮН АМЫГ ЗОХИХ ҮЕ ШАТТАЙГААР ДИСПАНСЕРЧЛАХ ЯВДАЛ МӨН. ЭНЭ ЗОРИЛТ НЬ ЭРҮҮЛИЙГ ХАМГААЛАХ ХӨГЖЛИЙН ШИНЭ ҮЕ ШАТ ЮМ“ ГЭЖ ЦОХОН ТЭМДЭГЛЭВ.

Үндэсний бага хурал „Хүн амд үзүүлэх амбулатори, поликлиникийн тусламж, зохион байгуулалтыг боловсронгуй болгох ю“, „Хүн амьг диспансерлахад нам, улс, олон нийтийн байгууллагын гүйцэтгэх үүрэг“, „Хүн амьг бүх нийтээр диспансерлахын онолын Үндэс, практик ач холбогдол“, „Хүн амьн эрүүл мэндийг бэхжүүлэхд амралт, рашаал сувиллын гүйцэтгэх үүрэг“ зэрэг 10 гаруй сэдвэр илтгэл хэлэлцлээ,

МАХН-ЫН ХIX ИХ ХУРЛЫН ШИЙДВЭРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭН УРДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ДАВАМГАЙ ХӨГЖҮҮЛЖ, БҮХ НИЙТИЙГ ҮЕ ШАТТАЙГААР ДИСПАНСЕРЧЛАХ АЖИЛД ШИЛЖИХ ТОМООХОН ЗОРИЛТ ДЭВШҮҮЛЖ БАЙГААГ ҮНДЭСНИЙ БАГА ХУРАЛ ДЭЭР ОНЦЛОН ТЭМДЭГЛЭЭД ЭНЭ ТАВАН ЖИЛД РАЙОНУУДАД ТОМООХОН НЭГДСЭН ПОЛИКЛИНИК, ОРОН СУУЦ, ГУДАМЖНЫ ХОРООДОД НЭГДСЭН ХЭСЭГ ЗОХИОН БАЙГУУЛЖ ОНОШЛОГОО ЭМЧИЛГЭЭНИЙ АППАРАТ, БАГАЖ ТӨХӨӨРӨМЖӨӨР АМБУЛАТОРИ, ПОЛИКЛИНИКИЙГ ДАВУУТАЙ ХАНГАН, АМБУЛАТОРИ ПОЛИКЛИНИКИЙГ УРТАСГАСАН, ЭЭЛЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭТЭЙ БОЛГОЖ ӨНДӨР МЭРГЭЖИЛТЭЙ, ДАДЛАГА ТУРШЛАГАТАЙ ЭМЧ НАРЫГ АЖИЛЛУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ АВАХ БОЛСНЫГ ТЭМДЭГЛЭВ.

Манай сурвалжлагч*

ЗХУ-ЫН ЭРҮҮЛИЙГ ХАМГААЛАХЫН ӨДРҮҮДЭД

ЭНХИЙН ҮЙЛСЭД ЗОРИЛГО НЭГ

Монгол Зөвлөлтийн найрамдлын 35 дахь сарын хүрээнд зохиогдсон ажлын нэг чухал хэсэг нь ЗХУ-ЫН ЭРҮҮЛИЙГ ХАМГААЛАХЫН ӨДРҮҮД ЮМ.

Манай оронд ЭРҮҮЛИЙГ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГА ҮҮСЧ ХӨГЖИХӨД АУГАА ИХ ЗӨВЛӨЛТИЙН АРД ТҮМНИЙ АХ ДҮҮГИЙН ИНТЕРНАЦИОНАЛЧ ТУСЛАМЖ ШИЙДВЭРЛЭХ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭСЭН БИЛЭЭ. БНМАУ, ЗСБНХУ-ЫН ЭРҮҮЛИЙГ ХАМГААЛАХ САЛБАР ДАХЬ ХАМТЫН АЖИЛЛАГАА БҮХ ТАЛААР ХӨГЖИН, ЗӨВЛӨЛТИЙН АРД ТҮМНЭЭС ҮЗҮҮЛЖ БАЙГАА ТУСЛАМЖ ЖИЛЭЭС ЖИЛД НЭМЭГДЭЖ БАЙНА.

ЗХУ-ЫН ЭРҮҮЛИЙГ ХАМГААЛАХ ӨДРҮҮДИЙН АЖИЛЛАГААГ НЭЭЖ ЭХЯ-НЫ НЭГДҮГЭЭР ОРЛОГЧ САЙД Г. ЖАМБА ХЭЛСЭН ҮГЭНДЭЭ „ЗХУ-ЫН ЭРҮҮЛИЙГ ХАМГААЛАХЫН ӨДРҮҮД НЬ МОНГОЛ ЗӨВЛӨЛТИЙН АРД ТҮМНИЙ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ НЭГ ТОД ЖИШЭЭ ЮМ“ ГЭЖ ТЭМДЭГЛЭВ.

ЗХУ-ын эрүүлийг хамгаалахын өдруудад ЗСБНХУ-ын Анагаах ухааны академийн академич, доктор профессор В. И. Покровский тэргүүтэй зөвлөлтийн анагаах ухааны өндөр, нарийн мэргэжлийн эмч, эрдэмтэд оролцлоо.

Манай хоёр орны эрдэмтэн, эмч нар蒙古лын эх нялхсын эрүүл мэндийг хамгаалах программаар хамтран ажиллаж байгаа бөгөөд түүнийг хэрэгжүүлэхэд Зөвлөлтийн эрүүлийг хамгаалахын өдруудад ач тусаа оглоо. ЗСБНХУ-ын хүүхдийн өвчин судлал, мэс заслын институтийн захирал, Анагаах ухааны академийн сурвалжлагч гишүүн Ю. Е. Вельтищев, профессор Р. М. Дементьева нар эх, нялхсыг хамгаалах эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, хүүхдийн эмч наратай уулзаж туршлагаа солилцов. Тэдгээр эрдэмтэд Хүүхдийн клиникин төв эмнэлэг, Улаанбаатар хотын Ажилчин, Сүхбаатарын районы хүүхдийн нэгдсэн эмнэлгийн ажилтай танилцаж, эмч наарт зөвлөлгөө өгч, онол практикийн бага хуралд оролцов. Зөвлөлтийн эрдэмтэд бага наасны хүүхдийг диспансерчлах, бөөр шээсний замын өвчин, амьсгалын замын өвчиний оношлух, эмчлэх зэрэг тулгамдсан асуудлаар хамтран ажиллаж байгаа ўйл ажиллагаагаа улам бэхжүүлэхэд анхаарлаа төвлөрүүлэх нь зүйтэй гэж үзэв.

Гэмтэл согогийн эмнэлгийн эмч мэргэжилтэн нар олон жил хамтран ажилласан Күрган мужийн гэмтэл согогийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн тасгийн эрхлэгч анагаах ухааны доктор С. И. Шведтэй уулзаж туршлагаа харилцан ярилцав. Эрдэмтэн С. И. Шведтэй өвчтөнийг амбулаторийг хэрхэн үздэг агра ажиллагаагаа үзүүлж эмч наратай дугуй ширээний яриа хийж, мэс засал хамтран хийв.

Г. А. Илизаровын туршлагыг манай эмч нар амжилттай эзэмшиж байгааг С. И. Шведтэй өндөр үнэлэв. Москвагийн стоматологийн институтийн тэнхимийн эрхлэгч Л. П. Воробьев, В. А. Ольхин, анагаах ухааны хоёрдугаар дээд сургуулийн багш доцент И. Г. Мясников нар анагаах ухааны дээд сургуулийн эрдэмтэн, багш, оюутнуудад баялаг туршлагаасаа ярьж, сонирхолтой сэдвээр лекц уншилаа.

Зөвлөлтийн эрдэмтэд Анагаах ухааны дээд сургуулийн дотрын өвчиний онош зүй, эмчилгээний болон стоматологийн тэнхимийн сургалт хүмүүжил, эрдэм шинжилгээний ажилтай танилцав.

А. Герциний нэрэмжит хавдар судалын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал, профессор В. И. Чисов Хавдар судалын нэгдсэн төвийн мэс засал, эмзгүйчүүд, хими туяа эмчилгээний тасгийн ажилтай танилцаж, манай эмч наратай хамтран өвчтөн үзэж, эмчилгээний чанарыг сайжруулах, хавдар судалын эрдэм шинжилгээний ажлаар хамтран ажиллах талаар үнэтэй санал дэвшүүлэв.

Үүний зэрэгцээ өдгөэр эрдэмтэд Дорнод, Архангай аймаг, Дархан хотын эрүүлийг хамгаалах байгууллагын ўйл ажиллагаатай танилцаж, орон нутгийн эмнэлгийн байгууллагуудад арвин баялаг туршлагаасаа нэвтрүүлэв.

ЗХУ-ын Эрүүлийг хамгаалахын өдруудийн төгсгөлд эрдэмтэн зочидтой уулзалт зохиов. Уулзалтанд Эрүүлийг хамгаалах Яамны ажилтнууд, эрдэмтэд, ерөнхий мэргэжилтнүүд оролцлоо.

Ю. Е. Вельтищев ЗСБНХОУ-ын Эрүүлийг хамгаалах Яамны харъяа хүүхдийн өвчин судлал, мэс заслын институтийн захирал, сурвалжлагч гишүүн;

Бид энэ өдруудад Эх нялхсыг хамгаалах эрдэм шинжилгээний хүрээлэн, Улсын хүүхдийн клиникин төв эмнэлэг, Сүхбаатар, Ажилчны районы хүүхдийн эмнэлэг, сувилал ясли зэрэг эмнэлгүүдийн ажилтай танилцлаа. Эх нялхсыг хамгаалах эрдэм шинжилгээний хүрээлэнтэй 1986—1990 онд хамтран ажиллах сэдвийн чиглэл хэлэлцээрийн талаар санал тохиролцэн хоёр талын Эрүүлийг хамгаалах ямар баттуулах бэлтгэлийг хангав.

Бид хүүхдийн эмч наратай хүүхдийн харшил судлал, иммун судлал, Орчин Үеийн оношлогоо, эмчилгээний аргууд, нарийн уушгинь үрэвслийн эмчилгээний тактик, ураг хамгаалалын асуудлаар чөлөөт ярилцлагатай явууллаа. Энэ цөхөн хоногийн дотор зохиогдсон хамтын ажиллагаа монголын эх нялхсын эрүүлийг хамгаалах ажилд бага ч болсон хувь нэмэр болох бслов уу гэж найдаж байна.

Бид дараах зүйл дээр анхаарлаа төвлөрүүлэх нь зүйтэй гэж үзэж байна. Хүүхдийн эрүүл мэндэд тавих анхаарал халамжийг ураг нарийн үеес нь эхлэх хэрэгтэй. Өвчтэй эхээс өвчтэй хүүхэд төрдөг нь бараг зуун хувь нотлогдсон асуудал билээ. Иймээс жирамсэн эхчүүдийг диспансерчлах, цаг алдалгүй эрт хэвтүүлж эмчийн хяналтад байлгах явдал чухал.

— Өндөр үнэтэй аппарат, багаж шаардагдах лабораторийн шинжилгээ явуулах оношлогооны төвлөрсөн лаборатори байгуулах нь эдийн засгийн хувьд ач холбогдолтой.

— Нярийн эрүүл мэндийг хамгаалах ажилд гол асуудлыг төвлөрүүлэх нь зүйтэй байна. Манай орны амаржих газруудад дутуу болон эмзэгтэй төрсөн нярийн тасаг нээж ажиллуулсаар тодорхой амжилтанд хүрч байгаа юм. Үүний зэрэгцээ дутуутнярийн идэвхт сэхээн амьдрзуулах эмчилгээний явуулын бригадыг зохих аппарат, тоног төхөөрөмжтэйгээр зохион байгуулах;

— Хүүхдийн эмч нарын сургалтын чанарыг сайжруулбал зохио. Одоогийн байдлаар багш нарын тоо дутуугаас болж нэг группэд хэт олон (15—16 хүртэл) оюутан байгаа нь ялангуяа клиникин сургалт явуулахад хүндрэлтэй байгаа нь би-

дэнд харагдлаа. Энэ бүхэн ирээдүйн эмч нарын чанарт мүү нөлөө үзүүлж болож юм. Докторантураар хүүхдийн мэргэжлийн эмцийг яяралтай бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх факультетийг тусад нь гаргаж тусгай тэнхимтэй болгох;

Хүүхдийн арчилгаа сувилгааны чанарыг сайжруулахад дунд мэргэжлийн ажилтнуудын мэргэжил мэдлэг, чухал шийдвэрлэх рольтой юм. Иймд тусгай курс зохиож болох юм.

Хүүхдийг багаас нь эхлэн эрүүл ахуйн дадал заншил эзэмшилж, хөдөлмөрчдийн ариун цэвэр, эрүүл ахуйн мэдлэгийг өндөржүүлэх, эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэхэд ном, товхимол, гарын авлага, үзүүлэн таниулах материалыг өргөнөөр гаргаж ашиглах нь зүйтэй гэж үзэж байна.

В. И. Чисов — Москва хотын Герцений нэрэмжит хавдар судлалын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал, профессор;

— Хорт хавдрыг эрт илрүүлэх, ялангуяа шинжлэх ухааны үндэслэлтэй судалгааны ажил явуулах, цаашдын оношлогоо, эмчилгээндээ хэрэглэх явдал чухал байна. Иймээс аймаг, хот, районын нэгдсэн эмнэлгийн дэргэд онкохирург, онкогиги неколог эмч нарын бүрэлдүүнтэй хавдар судлалын кабинет байгуулах хэрэгтэй юм. Ингэснээр:

— Ердийн эмнэлгүүдээс өөр өөрсдийн үйлчлэх хүрээний хүн амын дунд хавдартай тэмцэх ажлыг зохион явуулах удирдлагаар хангаж, эмчилгээ оношлогооны зөвлөмж сайжирснаар хорт хавдрыг эрт илрүүлэх нөхцөлийг бүрэлдүүлнэ.

— Хаана, ямар эрхтэний өмөн ихсэж буюу багасаж байгаа судалгаатай болсноор хавдартай тэмцэх ажлын шинжлэх ухааны үндэслэл сайжирч эмч нарын хариуцлага дээшлэн онош хожимдох явдал буурна.

— Сум болгонд оношлогооны лаборатори байгуулах боломжгүй нь мэдээж. Тэх дээ хэдэн сумдын дунд юмуу аймаг, хот, районад циталогийн төвлөрсөн лаборатори, флюорографийн кабинет байгуулж тоног төхөөрөмжөөр тоноглох явдал ач чухал байна. Энэ нь зөвхөн хавдар төдийгүй бусад өвчинийг эрт илрүүлэхэд ач холбогдолтой. Рентген радиологийн оношийн зарим аппаратыг орчин үеийн шинэ төхөөрөмжөөр солих хэрэгтэй.

— Анагаах ухааны дээд сургуульд хавдар судлалын тэнхим байгуулах замаар дипломын өмнөх ба дараах сургалтыг сайжруулах.

— Одоогийн байдлаар хавдар судлалын нэг эмчид 25 өвчтөн ногдож байгаа нь хүнд өвчтөнд эмчийн зүгээс үйлчлэх үйлчилгээнд муугаар нөлөөлж байгаа тул нэг эмчид 15-аас илүүгүй өвчтөн байхаар бодож нормативт өөрчлөлт оруулах;

— Анагаах ухааны хүрээлэнгийн хавдар судлалын сектор энэ чиглэлийн асуудлыг бүрэн шийдвэрлэж чадахгүй учир хавдар судлалын төвийн бүрэлдэхүүнд эрдэм шинжилгээний сектор байгуулах нь зүйтэй санагдана.

В. А. Воробьев — Москва хотын шүдний эмчийн дээд сургуулийн дотрын өвчин судлалын тэнхимиийн эрхлагэ, профессор;

— Одоогийн практиктай аймгийн нэгдсэн эмнэлэгт оношлогооны асуудлыг кардиолог эмч нар хариуцаж байна. Үйл оношлогооны кабинетыг тусад нь нээж ажиллуулах хэрэгтэй. Ингэснээр сум дундын больницод төлөвлөгөөтэйгээр явуулын бригад ажилшуулж үзлэг хийж байх.

— Нэг өвчтөнд хэтэрхий олон, заримдаа 10-аад нэр төрлийн эм өгч байгаа явдал тааралдаа. Энэ нь клиникин фармакологийг цаашид хөгжүүлэх шаардлагатай байгаа харуулж байна.

— Анагаах ухааны дээд сургуулийн материаллаг бааз, ажлын нөхцөл сайн байна. Гэвч цаашид анхаарвал зохион зүйл байна. Тухайлбал:

— Тус сургуулийн VI курсийн сургалтын зохион байгуулалтыг ЗХУ-ын Анагаах ухааны дээд сургуулиудын субординатурын сургалттай ойртуулан боловсронгий болгох,

— Оюутнуудыг өөрийн гараар, бие даан эмчилж сувилах практик бэлтгэлийг сайн хангах хэрэгтэй. Үүний тулд сургууль өөрийн клиниктэй болох, клиникийн ажиллагааг сургалтанд, клиникийн эмнэлгүүдийг сургалтын ортой болгох зэрэг арга хэмжээ авах, багш нарын клиникт ажиллах цагийг ихэсгэх нэг группэд хичээллэх оюуны тоог 8-аас ихгүй байлгах.

— Мэргэжил дээшлүүлэх, олгох курсуудын ялгааг гарган тусад нь салгаж сургалтын чанарыг сайжруулах талаар тодорхой ажил зохион хэрэгтэй юм.

И. Г. Мясникова — Москвагийн II Анагаах ухааны дээд сургуулийн эх барих, эмэгтэйчүүдийн өвчин судлалын тэнхимиийн багш, доцент:

— Сургалтын явцад хамгийн гол анхаарал хандуулах зүйл бол оюутнуудын дадлагын хичээл юм. Ирээдүйн эмч нар өөрсдөө эх барьж чаддаг байх хэрэгтэй.

— Зарим амаржих газарт, жишээлбэл, Дарханд өвчтэй, төрөх эмэгтэйчүүдийг хэвтүүлж эмчлэх тасаг байхгүй, гистологийн шинжилгээ явуулдаггүй тал байна. Монголчуудад резус хүчин зүйл бага ч гэсэн цус задрах өвчтэй хүүхдийг төрүүлэхээс урьдчилан сэргийлэх явдал эмч нарын байнгын анхаарлын төвд байх ёстай.

— Өвчтөн үзэх явцад жирэмсний хожуу үеийн хүнд хордлоготой хүн тааралдаж байлаа. Иймээс хүнд, хортой нөхцөлд ажилладаг жирэмсэн эхчүүдийг ялангуяа жирэмсний сүүлийн хагаст нь ажлаас чөлөөлж, эмчилж сувилах арга хэмжээ авах шаардлагатай юм.

В. М. Козлов—Москва хотын нүдний бичил мэс заслын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн тасгийн эрхлэгч, доктор;

— Улсын клиникийн төв эмнэлэг дээр 50 ортой нүдний тасаг ажиллаж байна. Энэ бол 2 сая хүн амтай улсын хэмжээнд авч үзвэл маш бага юм.

Тоног төхөөрөмжийн хувьд орчин үеийн түвшинд хүрэхгүй байна. Нүдний даралт ихсэх өвчтэй хүмүүсийг маш удаан, заримыг нь 10 гаруй жил эмчилж байна. Эмчилгээний тактикаа өөрчлөх хэрэгтэй.

Шиллэг биеийн мэс заслыг нэвтрүүлэх, холын харалганы мэс заслын бэлтгэл хийх, орчин үеийн микроскоп бэлэн нүдний мэс заслын бусад нарийн багажтай болох хэрэгтэй.

— Цаашдаа нүдний өвчин ангаах бие даасан эмнэлэгтэй бэлэх нь зүйтэй. Аймаг болгонд нүдний эмнэлэг байгуулж хүчээ тарамдах хэрэггүй, харин улсын хэмжээгээр нэг том, 200—300 ортой эмнэлэг байгуулах нь илүү ашигтай юм.

С. И. Швед—Курганы Гэмтэл-согогийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн тасгийн эрхлэгч, профессор;

— Осол гэмтээ жилээс жилд буурахгүй байгаа нь харамсалтай юм. Ялангуяа авто замын болон хүүхдийн гэмтэл хааягдуй их байна.

— Осол гэмтээл орсон өвчтөн бүрд эмнэлгийн анхны тусламж хүрэхээр зохион байгуулах явдал чухал. Үүний тулд аймагт гэхэд гэмтэл согогийн эмч наад зах нь 2 хүн ажиллаж, нэг нь гэмтэл согогийн Үйлчилгээний зохион байгуулалтыг хариуцах хэрэгтэй.

— Дархан Эрдэнэтийн нэгдсэн эмнэлэгт жишигэлбэл, гэмтлийн 20—40 ор байна. Хэд хэдэн аймгийн дунд нийлүүлж гэмтлийн тасаг гаргах нь чанарын хувьд дээр баймаар санагдана.

— Гэмтэл согогийн нарийн мэргэжлийн эмч бэлтгэх талаар төлөвлөгөөтэй ажиллах явдал чухал байна.

Ярилцлагыг тэмдэглэсэн Ц. Цэндэм

ОНОЛ ПРАКТИКИЙН БАГА ХУРАЛ

Монгол-Зөвлөлтийн найрамдлын 35 дахь сарын ажлын үеэр зохиогдсон Зөвлөлтийн эрүүлийг хамгаалах өдрийн тогтолцоулалт Эх нялхсиг хамгаалах эрдэм шинжилгээний хүрээлэнгээс онол практикийн бага хурал хийв.

Хуралд ЭХЯ-ны орлогч сайд Д. Менхөө, ЗХУ-ын Анагаах Ухааны Академийн сурвалжлагч гишүүн, РСФСР-ийн Эрүүлийг хамгаалах Яамны хүүхдийн өвчин судлал, мэс заслын хүрээлэнгийн захирал, анагаах ухааны доктор, профессор Ю. Е. Вельтищев, мөн хүрээлэнгийн гүйцэд ба дутуу нярайн эмгэг ба физиологийн клиникийн удирдагч, анагаах ухааны доктор, профессор Г. М. Дементьева нар болон Эх нялхсиг хамгаалах эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдэмтэн, эрдэм шинжилгээний ажилтнууд, Анагаах ухааны дээд сургуулийн хүүхдийн өвчин судлалын тэнхимийн эрдэмтэн багш, эмч нар оролцов.

Хуралд доктор, профессор Ю. Е. Вельтищев „Хүүхдийн беэр судлалын орчин үеийн онолын Үндэслэл“, доктор, профессор Г. М. Дементьева „Клиничийн неонатологийн тулгамдсан асуудлууд“, Эх нялхсиг хамгаалах эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал, доцент Э. Лувсандаагва „БНМАУ-ын хүүхдийн беэр, шээсний замын өвчин бүтэц, тархалт“, АУДЭС-ийн хүүхдийн өвчин судлалын тэнхимиин эрхлэгч, доцент Н. Гэндэнжамц, багш Д. Одонтуяа нар „Уушгины стафилококийн үүсэлтэй анхдагч үрэвслийн эмчилгээнд гепарин хэрэглэсэн нь“ зэрэг сонирхолтой илтгэл тавилаа.

Ю. Е. Вельтищев илтгэлдээ, орчин үед өвчиний эмгэг жам, онош, эмчилгээний асуудал, ялангуяа дархлал судлалын болон биохимиийн шинэ шинэ онолын Үндэслэлүүдээр улам бүр баяжжих байгааг онцлон тэмдэглэв.

Г. М. Дементьевыа эрүүл эхээс эрүүл хүүхэд төрүүлж, нярай үед нь онцгой анхаарал тавих, эхийн эрүүл мэндийн байдал хүүхдийн бие бялдар, эрүүл мэндэд хэрхэн иөлдөлдөг талаар онцлон ярив.

Профессор Ю. Е. Вельтищев, Г. М. Дементьевыа нарын илтгэл нь хүүхдийн өвчин судлалын талаар явуулах эрдэм шинжилгээний ажлын чиглэл, хандлагыг зааж, арга зүйн Үндэс болох ач холбогдолтой боллоо.

Үг хэлсэн хүмүүс эрдэм шинжилгээний ажлын практик өгөөжийг улам өндөржүүлэх, практикаас урган гарч буй тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд ажлаа чиглүүлэх, эрдэм шинжилгээ судалгааны ажилд практикийн эмч нарыг өргөн оролцуулах, тэднийг судалгаа шинжилгээний ажлын арга зүйд сургах талаар эрдэм шинжилгээ, сургалтын байгууллагын эрдэмтэн, багш нар байнга анхаарах талаар чухал санал гаргаж ЗХУ-ын Анагаах ухааны ололтоос суралцахын чухлыг онцлон тэмдэглэээ.

Г. Оросоо, Д. Энэбиш

ЭХ НЯЛХСЫН ЭРҮҮЛ МЭНД БҮХ НИЙТИЙН ҮЙЛ ХЭРЭГ МӨН.

ЗӨВЛӨЛГӨӨН, ҮЗҮҮЛЭХ СУРГУУЛЬ БОЛОВ

МАХН-ын XIX их хурлаас өсвөр залуу үеийнхний эрүүл мэндийг улам бэхжүүлэх, эх, хүүхдийн өвчлөл эндэгдлийг бууруулах зорилгоор „БНМАУ-д 2000 он хүртэлх хугацаанд эх хүүхдийн эрүүл мэндийг сахин хамгаалах асуудлаар цогцолбор-зорилтот программ боловсруулж нэвтрүүлэх“ онцгой чухал зорилтыг холбогдох яам, хороо, эрдэм шинжилгээний байгууллагын өмнө дэвшүүлэн тавьсан билээ.

Намын их хурлын шийдвэрийг амьдралд хэрэгжүүлэх зорилгоор БНМАУ-ын Эрүүлийг хамгаалах Яам, ДЭХБ-ын байнгын төлөөлөгчийн газар, Эх нялхсиг хамгаалах эрдэм шинжилгээний хүрээлэн, Эрдэнэт хотын Эрүүлийг хамгаалах газар хамтран Эрдэнэт хотод „Нялхсын өвчлөл эндэгдлийн шалтгаан, бууруулах арга зам“ сэдвээр улсын чанартай Үзүүлэх сургууль, онол практикийн бага хурал, мэргэжил дээшлүүлэх семинар, туршлага солилцох зөвлөгөөн, дугуй ширээний ярилцлага зохион байгуулж явуулав.

ҮЗҮҮЛЭХ СУРГУУЛЬ. Орчин үеийн анагаах ухааны ололт амжилт, эрдэм шинжилгээний ажлын Үр дүнг эх нялхсиг байгууллагын практикт нэвтрүүлж арга ажиллагааны тэргүүн туршлагыг нийтийн хүртэл болгох зорилгоор уг үзүүлэх сургуулийг бэлтгэн хийв.

Тус Үйл ажиллагаанд МАХН-ын Төв Хорооны ажилтан Б. Аюуш, Эрүүлийг хамгаалах Яамны орлогч сайд Д. Мөнхөө. ЭХЯ-ны хүүхдийн ерөнхий мэргэжилтэн Э. Лувсандагва, эх барих эмэгтэйчүүдийн ерөнхий мэргэжилтэн. Б. Шижирбаатар, БНМАУ-ын хүний гавьяат эмч Н. Гэндэнжамц, Цэрэндорж, Эх нялхсиг хамгаалах эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтнууд, аймаг, хотын Эрүүлийг хамгаалах газрын дарга, эх нялхсиг байцааг мэргэжилтэн, эмч нар болон Зөвлөлтийн мэргэжилтийн оролцов. Мөн Эрдэнэт хотын Намын Хороо, АДХ-ын Гүйцэтгэх Захиргааны хариуцлагатай ажилтнууд оролцлоо.

Үзүүлэх сургуулийг тус хотын нэгдсэн эмнэлэг, хүүхдийн больници, хүүхдийн нэгдсэн хэсэг, эмэгтэйчүүдэд зөвлөлгөө өгөх газар, 4 дүгээр ясли, хүүхдийн сувилалд хийв.

ОНОЛ ПРАКТИКИЙН БАГА ХУРАЛ. Үзүүлэх сургуулийн үеэр “Эх нялхсиг өвчлөл эндэгдлийг бууруулах нийгэм-эрүүлахуйн асуудал” сэдвээр онол практикийн бага хурал болж МАХН-ын XIX их хурлын шийдвэрийг хэрэгжүүлэхэд эх, нялхсиг байгууллагын зорилт (Д. Мөнхөө), Нялхсиг эндэгдлийн шалтгаан бууруулах арга зам (Э. Лувсандагва). Нялхсиг эндэгдлийг судлах арга зүй, бууруулах арга хэмжээг боловсруулах (С. Я. Сарычева), Бага настын хүүхдийн амьсталийн эрхтэйний өвчний оношлогоо, эмчилгээний асуудал (Н. Гэндэнжамц), Эхийн эндэгдлийн шалтгаан, бууруулах арга зам (Б. Шижирбаатар). Эрдэнэт хотын хүүхдийн өвчлөлийн байдал, бууруулах арга зам (Ч. Жигжидсүрэн) зэрэг 15 илтгэл хэлэлцэв.

Тус бага хурал нь эх нялхсиг өвчлөл эндэгдлийн шалтгаан түүнийг бууруулах арга замыг цаашид гүнзгийрүүлэн судлах, хэтийн төлөвийг тодорхойлох. арга ажиллагааг боловсронгуй болгон чанаржуулахад чухал Үр дүнтэй боллоо.

МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ СЕМИНАР. Эрүүлийг хамгаалах Яамны ерөнхий мэргэжилтэн, эрдэм шинжилгээний ажилтан, эрүүлийг хамгаалахын зохион байгуулагч, эрдэмтэн багш нар гурван өдрийн семинар өгөв.

Тус семинар нь эх хүүхдийн өвчлөл, судлал, диспансерчлалын онол, аргачлал, практикийн байгууллагын тэргүүн туршлага, жишээнд тулгуурлан өгөгдсөн нь эмч мэргэжилтнүүдийн мэргэжил мэдлэгээ дээшлүүлэх, урьдчилан сэргийлэх арга ажиллагааг өргөжүүлэх, эмчилгээ үйлчилгээнд орчин үеийн анагаах ухааны оношлогоо эмчилгээний арга барилгыг нэвтэрүүлэх, Эх нялхаст үзүүлэх эмнэлгийн тусламжийн зохион байгуулалт, арга зүйг боловсронгуй болгоход бүрэн чиглэгдэв.

ЭХ НЯЛХСЫН ЭРҮҮЛ МЭНД-ШБОС ТЭРГҮҮН ТУРШЛАГА гэсэн үзэсгэлэн ажиллав.

Үзэсгэлэнд Архангай, Баян-Өлгий, Сэлэнгэ, Завхан, Өмнөговь, Сүхбаатар, Эрдэнэт, Улаанбаатар зэрэг аймаг, хотын эх нялхсиг байгууллагын 200 гаруй үзмэр тавигдсан нь нийтийн хүртэл болохуйц тэргүүн туршлага учраас практик ажилд нэвтрүүлэх нь эх нялхсиг байгууллагын нэн тэргүүний зорилт мөн.

Үзүүлэх сургуулийн үеэр „ЭХ НЯЛХСЫН ЭРҮҮЛ МЭНД БҮХ НИЙТИЙН ҮЙЛ ХЭРЭГ“ сэдвээр дугуй ширээний ярилцлага хийв.

МАХН-ын Төв Хороо, Сайд нарын Зөвлөлийн 1979 оны 21 дүгээр тогтоолд эх хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах ажлыг цаашид сайжруулах явдлыг улс нийгмийн нэн чухал зорилт гэж үзэж орон нутгийн нам улс, олон нийт, хоршооллын байгууллагын нийт хөдөлмөрчдийн бүтээлч идэвх санаачилгыг түүнд чиглүүлэн бүх нийтийн үйл хэрэг болгон өрнүүлэхээр заасан билээ.

Орон нутагт эх хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах ажилд тус хотын Намын Хороо, АДХ-ын Гүйцэтгэх Захиргаа болон орон нутгийн нам улс, хоршооллын байгууллагууд бодит туслалцаа үзүүлж байдгийг тус ярилцлагад оролцсон хүмүүсийн яриа харууллаа.

Ярилцлагад Эрдэнэт хотын нам, улс, олон нийтийн байгууллагын ажилтууд бусад аймаг, хотын Намын Хороо, АДХГЗ-ны эмнэлгийн ажил эрхэлсэн дарга нар, хөдөлмөрчдийн төлөөлөгчид оролцож эрдэмтэн, мэргэжилтнүүдээс асуулт асууж, харилцан ярилцаж санал бодлоо солилцов.

Үзүүлэх сургуулийн төгсгөлд „МАХН-ын XIX их хурлын шийдвэрийг хэрэгжүүлэхэд эх нялхсын байгууллагын зорилт“ сэдвээр зөвлөлгөөн боллоо.

Зөвлөлгөөнөөс МАХН-ын их хурлын шийдвэрийг хэрэгжүүлж, эх нялхсын байгууллагын тэргүүн туршлагад тулгуурлан эх нялхсын эрүүл мэндийг хамгаалах ажилд чанарын ахиц гаргах, эх нялхаст Үзүүлэх эмнэлгийн тусламжийн зохион байгуулалт, арга зүйг боловсронгуй болгох, эх нялхсын өвчлөл эндэгдлийн шалтгааныг судалж бууруулах арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх ажлыг улам эрчимжүүлэх зорилгоор эрүүлийг хамгаалах, эх нялхсын байгууллагын эмч мэргэжилтэн, ажилтан ажилчдад хандаж зөвлөмж гаргав.

Зөвлөлгөөнд оролцогчид үзүүлэх сургуулиар танилцсан байгууллага газруудын туршлагаас өөрсдийн ажилд бүтээлчээр хэрэгжүүлэх зорилт дэвшиүүлэв.

Ц. Алтанцэцэг

ҮНШИГЧДЫН БАГА ХУРАЛ БОЛОВ

Эмнэлгийн хэвлэлийн нэгдсэн редакци, „Анагаах ухаан“ сэтгүүлийн үншигчдын бага хурлыг Хөвсгөл, Хэнтий, Завхан, Эрдэнэт, Улаанбаатар зэрэг аймаг, хотод хийж өнгөрсөн онд тус редакциас хэвлэл нийтлэлийн талаар хийсэн ажлаа тайлagnav.

Хуралд аймаг, хотуудын эмч, эрдэм шинжилгээний ажилтан, идэвхтэн бичигчид оролцов.

Тус хурлаар „Анагаах ухаан сэтгүүлийн агуулга, чанарыг сайжруулъя“ гэсэн илтгэл хэлэлцүүлж, сэтгүүлийн агуулга чанар, өнгө үзэмж, хэвлэл нийтлэлийн талаар санал бодлоо солилцож солирхсон зүйлээ асууж харилцан ярилцав.

Үншигчдын бага хурлаас сэтгүүлд нийтэлж буй өгүүлийн ялангуяа „Эрдэм шинжилгээ, судалгаа“, „Мэргэжлийн зөвлөлгөө“ буланд нийтлэгдэж буй өгүүлийн шинжлэх ухааны үндэслэлийг сайжруулах, судалгаа шинжилгээний дорвitoят бүтээл гаргах, тэдгээрийн тоог олшруулах, чанарыг эрс сайжруулах, ЗХУ-ын анагаах ухааны эмчилгээ оношлогоонд гарч буй шинэ сэргэг зүйлийг түргэн шуурхай мэдээлэх, эрүүлийг хамгаалахын өмнө тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд туслах өгүүлэл нийтлэх, эмч нар гарын авлага болохуйц өгүүлэл зэргийг ихэсгэх зорилт дэвшүүлэв.

Үүний хамт тус редакцийн зөвлөлөөс сэтгүүлийн хэвлэл нийтлэлийн ажилд Анагаах ухааны хүрээлэн, Анагаах ухааны дээд сургууль, Эрүүл ахуй халдварт нян судлалын улсын институт, Эх нялхсыг хамгаалах эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан багш нар идэвхтэй оролцож байгааг тэмдэглэж ялангуяа хөдөө, орон нутагт ажиллаж байгаа эмч нар хэвлэл нийтлэлийн ажилд идэвх муутай, оролцохгүй байгааг анхааруулав.

Ц. Алтанцэцэг

УХАМСАРТАЙ САХИЛГА ХҮНИЙГ ЗАХИРЧ УДИРДАНА

ЭРҮҮЛИЙГ ХАМГААЛАХ АЖЛЫГ ҮНЭЛЭХ, ТӨЛӨВЛӨХ ТУХАЙ

МАХН-ын XIX их хурлаас хүн амын эмнэлгийн үйлчилгээний хүрээг өргөтгөж, чанарыг сайжруулах талаар томоохон зорилт дэвшүүлсэн билээ.

Хүний эрүүл мэнд гэдэг бол өргөн цар хүрээтэй, гүнзгий утга агуулгатай ойлголт юм. Эрүүл энх байна гэдэг юуны өмнө хүний аз жаргал бөгөөд хөдөлмөрийн өндөр бүтээл гаргах чадвартай, сайн сайхан амьдарч аж төрөхийн нэг нөхцөл байдаг. НҮБ-ын хүний эрхийн дүрэм, ДЭХБ-ын дүрэмд „Эрүүл мэнд бол энэ ертөнцийн хүн бүрийн эдэлбэл захих“ эрх гэж заасан байдаг.

Нийгмийн хөгжлийг шийдвэрлэх хүч нь хүн өөрөө болохоор хүний эрүүл мэндийн тухай, хүний эрүүл байх эрхийн тухай асуудал бүх л нийгмийн гол гогцоо асуудал байсаар ирсэн бөгөөд энэ нь зөвхөн социалист нийгэмд л жинхэнэ ёсоор шийдвэрлэгддэг юм. Капиталист нийгэмд хэдий хэмжээтэй мөнгө төлсний нь хэрээр өвчтөнийг эмчилдэг бол социализмд өвчтөнийг ямар ч үнэ төлбөргүй бүрэн эдгэрч тэнхэртэл нь эмчилдэг. Ингэхлээр социалист нийгмийн эмч, эмнэлгийн ажилтны ёс суртахуун болж тухайн нийгмийн ёс суртахууны бүрэлдэхүүн хэсэг болж байдаг.

Гэхдээ эмнэлгийн үйл ажиллагааны үр дүн нь хувь хүний үйл ажиллагааны мөн чанараас өөрөөр хэлбэл, хүний хүчин зүйлээс ихээхэн шалтгаална. Эмч хүн өндөр мэдлэгтэй, бие бялдэр, оюун санааны асар их тэвчээр хатуужилтай, зохион байгуулах чадвартай байхаас гадна сэргэл зүйч, уран зураач, багш, сурган хүмүүжүүлэгч байхыг шаарддаг өвөрмөц мэргэжил юм.

Хүний биологийн бэлэн ний мийн нууцыг хадгалж хүмүүст хүндлүүлж явдаг онцгой мэргэжил.

Зөвлөлтийн нэрт эмч Мөлчанов „Өвчтөнтэй харьцахдаа генералтай харьцааж байгаа юм шиг байж, өвчтөнийг эмчлэхдээ цэрэгтэй харьцааж байгаа шиг байж хэрэгтэй“ гэж хэлсэн байдаг.

Ер нь эмч хүнийг мэдлэг мэргэжлийн ур чадвар, идэвх санаачлага, дадлага туршилага, ёс суртахуун, хүмүүжил, ажлын хариуцлага, сахилга батын талаас нь олон түмэн үнэлдэг бөгөөд тэр үнэлэлт хэдий чинээ өндөр байж нэр хүнд нь тэр хэмжээгээр ёсно. Ийм нэр хүндтэй эмчийг ард түмэн хүндэлж, нам засаг хайрлан ивээж байдаг билээ. Дээрх үзүүлэлт нь эмч хүний хувийн шинж чанарыг харуулдаг учраас заруулж нарыг тэдгээр үзүүлэлтээр байгаа үнэлж, тэд эмч хүний ямар чанарыг нь эзэмшиэн, ямар талаас нь туслах шаардлагатай тодорхойлон, чиглэсэн зорилготой ажил эзхиох талаар эмнэлгийн захирагаа, нам олоц нийтийн байгууллага анхаарч ажиллавал зүйтэй санагддаг.

Эмч нарыг мэргэжилтийн нь хувьд хэрхэн үнэлэх талаар товч ярилаа. Гэтэл тэдний үйл ажиллагааг хэрхэн төлөвлөх, ямр үзүүлэлтээр үнэлэх нь нэлээд нарийн төвөгтэй юм. Нийгэмд хэр амиг тустай, хөгжил дэвшилд ямар нөлөө үзүүлснээр нь алчваа хөдөлмөрийг үнэлдэг. Гэтэл одоогийн практикт ор хоног, өдөр, сар, жилд үзэх хүний тоо гэх зэрэг үзүүлэлт хэрэглэж байгаа нь эмчийн хөдөлмөрийн эцсийн дун болох, өвчтөн эдгэрсэн эсэх, өвчлөлт буурсан зэргийг бүрэн харуулж чадахгүй байна. Эмчийн үйл ажиллагааг үнэлж дүгнэхдээ эрхэлж байгаа ажлын онцлогтой нь заавал холбох ёстой.

Амбулатори-поликлиник, хэсгийн эмнэлэгт ажиллаж буй эмч нарын ажлыг үнэлэх үзүүлэлт нь үйлчлэх хүрээний хүн амын өвчлөлийг бууруулах явдал юм. Үний түлд тэд үйлчлэх хүрээний хүн амыг урьдчилан сэргийлэх үзлэгт бүрэн хамруулан диспансерчлах, ихээр тархаж байгаа өвчлөлийг бууруулах, томуу ба томуу төст өвчин, гүйлсэн булчирхайн үрэвсэл, шүлний өвчтэй хүмүүсийг эрүүлжүүлэх зэрэг системтэй ажил зохиох л чухал юм. Мөн түүнчлэн хөдөлмөрийн чадварыг түр алдагдуулж байгаа зонхилох өвчин болох хэрэх, зүрхний гажигтай, ходоод гэдэс, амьсгалын замын архаг өвчинтэй хүмүүсийг амбулатори ба хэсээр эрт оношлон илрүүлж холбогдох эмчилгээ хийж, шаардлагатай үед нь эмнэлэгт хэвтүүлэн эмчилж, эмнэлгээс гарах үед нь хяналтанд авч ажиллах нь хэсгийн эмч нарын идэвх санаачлагыг өндөржүүлэхэд нөлөөлөх ач холбогдолтой юм. Хэсгийн эмч нарын ажлыг үйлчлэх хүрээнд хүн амын өвчлөлт хэр зэрэг буурсан эсэхээр үнэлдэг журамд шилжвэл хөдөлмөрдийн дунд явуулах эрүүл аж төрөх ёсны сурталчилгааны ажил, эмч нараас харьяа үйлдвэр, аж ахуйн газрын эрүүл ахуйн нөхцөлд тавих хяналт сайжрахад түлхэц өгнө.

Больници, стационарт ажиллаж байгаа эмч нарын ажлыг, орны эргэлтийг хурдасгасан байдал, оношлолт эдгэрлэтийн хувь зэрэээр үнэлж болох юм. Энэ нөхцөлд стационарын эмч шаардлагатай бүх эмчилгээг цаг алдалгүй хийж өвчтөнийг эдгэрүүлж гаргахдаа амбулатори, хэсгийн эмчийн хяналтанд хүлээлгэн өгч, цаашдлын эмчилгээний талаар зөвлөгөө өглөг журам аяндаа хэвшихэд нөлөөлнө. Үйлдэл

вэрийн ажилчин хүн 21 хоног болынцод эмчлүүлэхэд, тухайн хугацаанд бүтээгдэхүүний алдагдал, эмчилгээний зардал, тэтгэмж нийлээд улсад зургаан мянга шахам төгрөгний хохирол учирдаг байна. Үүнээс гадна өвчилсөн хүний оюун санаа, биений хүчний байдалд тодорхой хугацаанд өөрчлөлт гарч хөдөлмөрийн бүтээмжид сөрөг нөлөө үзүүлдгүйг бодолцвол бүр ч их хохирол тооцогдох болно. Иймээс цаашид өвчлөлийг бууруулсан, өвчтөнийг богино хугацаанд эмчлэн эдгэрүүлсэн, ор хоног тутамд ногдох зардлыг хямруулснаас гарах нийгэм-эдийн засгийн асар их ач холбогдолыг хяргалзан эмч, эмнэлгийн ажилтныг урамшууллагыг системийг бий болгох нь зүйтэй байна. Эмнэлгийн байгууллага, эмч нарт ч ийм үзүүлэлтээр төлөвлөгөөт даалгаврыг өгдөг журамд шилжмээр байна.

Ард түмний өрүүл мэндийг сахин хамгаалах үйл хэрэгт орон нутгийн төрийн захирагааны байгууллага, Үйлдвэр аж ахуйн газрын захирагаа чухал үүрэгтэй.

БНМАУ-ын Эрүүлийг хамгаалах хуульд „Аймаг, хот, сум (хот) район, хороо, сангийн аж ахуй, хөдөө аж ахуйн нэгдэл болон Үйлдвэр, албан газар, байгууллага нь хөдөлмөрчид, хамт олны хөдөлмөр, амралт, ахуйн нөхцлийг сайжруулах, эрүүл мэндийг хамгаалах, тэдэнд ариун цэвэр, эрүүл ахуйн мэдэгдэхүүн олгох, орчныг бохирдлоос хамгаалаас асуудлаар жил бүр нэгдсэн төлөвлөгөө зохиож, АДХ-ын Чуулган, хамт олны хурлаар баталж ажиллана“ гэж заасан байдаг. Үйлдвэр аж ахуйн байгууллагын захирага, Үйлдвэрчний эвлэл, Эмнэлгийн байгууллага, хамтарч өвчлөл бууруулах төлөвлөгөөг жил, сарын хугацаатай гаргаж тодорхой ажил зохиолов зохих нөлөө үзүүлнэ. Ганц жишээг дурьдахад томууг багасгаж чадвал амьсгалын замын өвчин, гүйлсэн булчирхайн үрэвсэл, уушгины хатгалгаа, дунд чихний үрэвслийг багасгахаа улмаар хүнийг тахир дутуу болгодог хэрэх өвчин, зүрхний гажиг, үе мөчний бусад хүнд өвчний гаралтыг багасгах юм. Үйлдвэрлэлээс ажилчдыг хөндийрүүлэхгүйгээр эрүүлжүүлж, чийрэгжүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах зорилгоор Үйлдвэрийн дэргэд сувилал, амралтын газар байгуулах, Үйлдвэр цехийн хэсгийн эмнэлгийг тогтмол ажиллагаатай байлгах, ажилчдыг цай хоолоор Үйлчлэх зэрэг хамтын хүчээр өвчнөлтийг бууруулж хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх бодит боломж байна. ЗХУ-ын Чилябинск хотын В. И. Лениний нэрэмжит тракторын заводын туршилагаар Улаанбаатар хотын З дугаар цахилгаан станцын нам захирагааны байгууллага 1982 оноос Ажилчны районы нэгдсэн эмнэлгийн эмч нарын бүрэлдэхүүнтэй, эмч, инженерийн нэгдсэн бригад“ гаргаж ажилчдын хөдөлмөрийн аятай нөхцөлийг бүрдүүлэхэд эмч нар туслах Үйлдвэрийн газрын бүх өрөө тасалгааны агааржуулалт, гэрэлтүүлэг, дуу чимээнд хэмжилт хийн ариун цэвэр, өрүүл ахуйн нөхцөлийг сайжруулж ажилчин, албан хаагчдыг диспансериги хяналтад бүрэн хамруулсан байна.

Мөн өрүүл ахуй, ариун цэвэр, урьдчилан сэргийлэх арга хэмжээг багтаасан өрүүлжүүлэх программуудыг ажиллажээ. Эдгээр арга хэмжээний үр дунд 1983 оныг 1981 онтой харьцуулалт хөдөлмөрийн чадвар түр алдарт зуун (100) ажилчинд таван тохиолдоор өвчлөл 120 хоногоор буурчээ.

Хэдийгээр ийм туршилага байгаа боловч орон нутаг, Үйлдвэрийн газрын хэмжээнд өвчлөлийг бууруулах талаар тодорхой арга хэмжээ авах ажил тэдгээрийн удирдах ажилтнуудын идэвх санаачлагаас шалтгаалж жигд бус зохиогдож байна.

Үүнээс үзвэл, өвчлөл бууруулах төлөвлөгөөт даалгаварыг эмнэлгийн байгууллага, эмч нарт төдийгүй орон нутагт төрийн захирагааны нэгж, Үйлдвэр аж ахуйн газар, байгууллагын захирагаанд жил бүр өгдөг болох нь зүйтэй байна.

Эн нь эдийн засгийн ач холбогдолтой төдийгүй хүн амыг цаашилбал улс орны Үйлдвэрлэл, ахуйн соёлын түвшинг нийтэд нь өөд татах механизм болно гэж үзэж байна.

Их эмч С. Цэрэннадмид

УДАМШЛЫН ТУХАЙ УНЦИХ ГЭЭД УРАМ ХУГАРСАН МИНЬ

Өргөн мэдлэгээ уншигч бидэнтэйгээ хуваалдаж шинжлэх ухааны ололт амжилтаас сонин, хэвлэлд сургалчилж байдаг эрдэмтэд судлаачдын бичсэнийг бид байнга шимтэн уншдаг билээ. Гэтэл уншсан зарим зүйлийн дотор эргэлзээтэй, тэр ч битгий хэл эндүү гэмээр бичигдсэн зүйл заримдаа тааралдах юм.

Үүнийг удамшлын тухай хэвлэлд бичсэн зүйлээр жишээ татан авч үзье.

„Үнэн“ сонинь 1985 оны 276 дугаарт анагаах ухааны дэд эрдэмтэн Ц. Мухарын „Удамшил, эрүүл мэнд“ гэсэн өгүүлэл нийтлэгдсэн билээ. Зохиогч удамшил гэдэг ойлголтыг тайлбарлахдаа хүүхэд эцэг эхээ давтан төрөхийг хэлнэ гэжээ. Ийм тайлбар нь удамшлын ухааны хувьд ч диалектикийн зүй тогтлын үүднээс ч алдаатай ойлголт юм. Ном зохиолд ч ингэж ойлгож болохгүй гэж бичсэн байна. Жишээ нь „Анагаах ухааны генетикийн үндэс“ номонд „Хромосом доторх генүүдийн шинэ хоршил үүсч энэ эсээр үр тогтох шинээр төрөх удам эцэг эхийн шууд хуулбар биш, харин эцэг эхээс авсан генүүдийн шинэ хоршлын дунд үүсэж бий болсон, чанарын хувьд цоо шинэ өөрийн гэсэн өвөрмөц давтагдашгүй шинжтэй бие махбод юм...“ (27-р тал) гэж бичжээ.

Эцэг эхээс үр хүүхдэд дамжиж байгаа удашлын мэдээлэл нь хромосом ба генийн түвшинд шинэ шинэ хоршил найрлыг үүсгэж генетикийн нийлбэр мэдээлэл өөрчлөгддөг учир хүүхэд эцэг эхтэйгээ адилхан байх төдийгүй олон шинжээр тэднээс ялгарч байдгийг бид мэдэх билээ.

МЭДЭХ БИЛЭЭ.
Мөн энэ өгүүлэлд уdamшлын 2000 орчим эмгэг байгааг дурьдаад
...түүний дотор судас хатуурах, цусны даралт ихсэх болон зарим
хорт хавдрууд... мэт уdamшилд өртөмтгий олон өвчин байдаг" гэж
эндүү бичжээ. Учир нь орчин үед мэдэгдэж байгаа 2000 гаруй уdamш-
лын өвчин бол тодорхой нэг генээр үүсдэг (моногенийн) эмгэгүүд юм.
Харин зохиогчийн "удамшилд өртөмтгий" гэж нэрлээд байгаа эмгэгүүд
үүсэхэд хувь хүний уdamшлын бүтэц нөлөөтэй боловч гол нь орчны
нөлөөнөөс шалтгаалж үүсдэг. Ийм эмгэгүүд нэг гэр бүлд уdamших
хандлагатай байхад өөр тохиолдолд огт уdamшихгүй ч байж болдог.
Иймд эдгээр бүлэг өвчинийг дээр дурьдсан уdamшлын гэгдэх 2000 өвч-
ний тоонд оруулдаггүй билээ.

Мөн цааш нь „Бие маходын онцлог ДНХ-ийн молекулын хэсгүү-
дэд агуулагдана“ гэж ямарч утгагүй, ойлгомжгүй төдийгүй буруу та-
шаа бичээд „Үүнийг ген гэнэ“ гэж тайлбарласан нь даанч болхи
болжээ.

Энэ мэтчилэн зохиогч маань өөрөө сайн ойлгоогүй юмаа бичээд байгаа юмуу дэа гэсэн бодол уг өгүүллийг цаашид унших тутам өөрийн эрхгүй төрөхөөр байна. Энэ эрдэмтний бичсэн „Удамшлын өвчин“ гэсэн хоёр дахь (Үнэн, 1986 № 210) өгүүлэлд алдаа ташаа зүйл бүр ч ихэсч ойлгоход бэрх, болхи хэллэг, буруу томьёолол олон байгаа нь уншихад урам хугарахаар болжээ. Жишээ нь „Мутаци болсон бэлгийн хромосомын өвчтэй“ ген үр хөврөлд оролцож үүргээ биелүүлж чадахгүй болсноос генийн өвчин үүсдэг гэж бичжээ. Генийн өвчин үүсэх жамыг ингэж тайлбарлаж болохгүйн дээр зохиогч бэлгийн эс, бэлгийн хромосом хоёроо хооронд нь андуурч будилаад байгаа нь илт

байна. Цааш нь „Удамшлын өвчний эх уурхай болсон хромосомын ба генийн гажигийн давамгайллах сулруулах чадвараас болж өвчтэй эцэг эхээс төрсөн хүүхдийн тэн хагас нь юмуу эсвэл дөрөвний нэг нь өвчтэй байх зарим тохиолдолд үе алгасан удамших зэрэг тодорхой хэм хэмжээтэй үйлчилдэг. Үүнийг удамшлын хууль гэнэ гэж бичжээ. Энэ өгүүлбэр ямар нэг тодорхой утга санаа илэрхийлэх чадваргүй, хэллэг бүтэцийн хувьд дэндүү болхи болсныг эс тооцъё гэхэд удамшлын хуулийн тухай ингэж тодорхойлно гэхэд боломжгүй санагдана. Дунд сургуулийн сурахаас уншсан ч энэ тухай ойлгомжтой бичсэн байгаа. Түүнээс гадна „Удамшлын өвчний эх уурхай болсон хромосомын ба генийг гажиг . . .“ гэж юу яриад байна вэ?

Мөн зэхиогч маань хромосомын гажигийг Менделейн хуулийн дагуу удамшдаг гэсэн буруу ойлголттой байгаа бололтой. Хромосомын эмгэгийг хэдийгээр генетикийн өвчинд хамгааруулж үзэх боловч ховорхон хэдэн тохиолдлоос бусад хромосомын өвчин ерөөсөө удамшдаггүй билээ. Удам дамжиж болох тэр цөөхөн тохиолдол нь генийн эмгэгийн удамших зүй тогтолоос өөр байдаг.

Тэрчлэн өвчтэй эцэг эхээс төрөх хүүхдийн тэн хагас нь юмуу дөрөвний нэг нь өвчтэй байна гэж баталж хэлээд байгаа нь үнэнд огт нийцэхгүй. „Тэн хагас“, „дөрөвний нэг“ гэж генетикийн номонд бичиж байгаа нь ийм байх боломжтой гэсэн үг болохоос биш хүүхдийн төдөн хувь нь заавал өвчтэй байна гэсэн үг бишээ. Түүнээс гадна удамшлын өвчтэй хүүхэд заавал өвчтэй эцэг эхээс төрөх албагүй харин ихэнх тохиолдолд эмгэг генийг далд хадгалж явaa эрүүл хүмүүсээс өвчтэй хүүхэд төрдөг гэдгийг зохиогч мартсан бололтой.

Эрдэмтэн Ц. Мухар бодисын солилцооны удамшлийн өвчнийг тайлбарлахыг оролдох явцдаа „Үнээс болсон юмуу“ нэг ген-нэг фермент“ гэсэн хэллэг байдаг“ гэж ихэд эргэлзэнгүй бичсэнээрээ генийн тухай бодисын солилцооны удамших эмгэг яагаад үүсдэг талаар түн ч нимгэн мэдлэгтэй байгаагаа өөрөө зөвшөөрчээ.

„Нэг ген-нэг фермент“, „нэг ген-нэг полипептид“ гэдэг нь зохиогчийн ойлгосон шиг зүгээр нэг хэллэг төдий зүйл биш бөгөөд молекулын төвшинд үүсэх генийн өвчний мөн чанарыг тайлбарласан онол билээ. Энэ онолыг үндэслэгчид 1958 онд Нобелийн шагнал хүртсэн нь уг нээлт молекулын генетикт чухал хувь нэмэр болсныг гэрчлэх бөгөөд удамшлын тухай сонирхон судлаж байгаа хэн боловч түүнийг мэдсэн байх ёстойсон.

Зохиогч энэ өгүүллийнхээ эцэст хүйс даган удамшсан цус хайлах эмгэгийн тухай бичсэн нь эргэлзээ төрүүлж байна. Цус хайлах эмгэг (гемолитическая болезнь) маш олон янз байж болох боловч тэдгээрийн аль ч хүйс дагаж удамшдаггүй билээ. Харин зохиогч маань цусны бүлэгнэх чанар алдагддаг өвчнийг (гемофилия) цус хайлах өвчин гэж ташаарсан байж магадгүй юм. Учир нь гемофилийг үүсгэдэг ген X-хромосомд байдаг учраас түүгээр эрэгтэйчүүд өвчилнө.

Анагаах ухааны генетик нь шинэ тутам залуу шинжлэх ухаан учир ялангуяа манай оронд мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай тал байдаг бизээ. Гэвч энэ нь алдаатай буруу зөрүү зүйл бичиж ярихыг зөвтгөх шалтаг болох ёсгүй.

„Эрүүл мэнд“ сэхтгүүлийн 1986 оны 5 дугаарт анагаах ухааны дэд эрдэмтэн С. Лхүндэв „Арьсны удамшлын өвчин“ гэсэн өгүүлэл хэвлүүлсэн байна. Энэ өгүүлэлд эхний өгүүлбэрээсээ өгсүүлээд алдаа ташаа зүйл олон байна.

Зохиогч удамшлын өвчин гэдэг тодорхойлолтыг „Өвчтэй эцэг эхээс үр хүүхдэд нь дамжсан өвчнийг хэлнэ“ гэж уншигчдад буруу ойлголт өгөхөд хүрчээ.

Удамшлын өвчтэй хүүхэд заавал өвчтэй эцэг эхээс төрж байх албагүй гэдгийг С. Лхүндэв, Ц. Мухарын нэгэн адил мартаад байгаа бололтой. Удамших хэлбэрээсээ хамаараад эрүүл эцэг эхээс өвчтэй хүүхэд төрөх явдал удамшлын өвчний дотор ихэнх хувийг эзэлдэг. Мөн генийн шинээр үүсэх мутац (хувьслын) -ийн улмаас хэзээ ч энэ удамд байгаагүй өвчин гэнэт илэрч болдог.

Тэрчлэн эцэг эхэд байгаа өвчин хүүхэд илрэх нь заавал удамшилтай ч холбоогүй. Зарим халдварт өвчнийг хүүхэд эхээсээ авч төрж болно. Тэхээр удамшлын өвчин гэдгийг орчин үеийн ном зохиолд бичиж байгаагийн дагуу зөв тодорхойлох хэрэгтэй байжээ.

Цааш нь „Удамшлын бүх өвчнийг моноген, полиген, хромосомын хэлбэрүүд гэж З хэсэгт хуваадаг боловч ДЭХБ-ын мэдээгээр бүх удамшлын өвчний гуравны нэг нь арьсны удамшлын өвчин байна. Үүнийг дотор нь Фенокопийн, генокопийн өвчинүүд гэж хуваана“ гэж бичсэн байх юм.

Генетикийн өвчнийг ерөнхийд нь генийн ба хромосомын гэж хоёр том бүлэг болгон ангилах бөгөөд тэр нь цаашдаа нарийвчлан хуваагддаг билээ.

Сүүлийн жилүүдэд хэвлэгдсэн номонд бичсэнээр бол арьсны удамшлын биеэ даасан эмгэгүүд 250 орчим бүртгэгджээ. Удамшлын нийт эмгэгийг 2000 орчим гэж үзвэл түүний гуравны нэг нь арьсны удамшлын өвчин байж чадахгүй болох нь харагдаж байна. Тэгэхээр зохиогчийн иш татсан эх материал алдаатай байсан юмуу хэт хуучирсан тоо байсан бололтой.

„Арьсны удамшлын өвчнийг дотор нь фенокопийн, генокопийн өвчин гэж хуваадаг“ гэсэн нь бүр ч ташаа зүйл болжээ. Орчны хүчин зүйлийн нөлөөгөөр үүссэн өвчний илрэл генээр үүссэн өвчний шинж тэмдгээс ялгарахгүй байх тохиолдолд фенокопи гэдэг нэр томьёог хэрэглэдэг нь уг өвчний үед удамшил ямарч хамаагүй гэсэн санааг илэрхийлж байгаа юм. Харин генокопи гэдэг нэр томьёог өөр өөр генийн нөлөөгөөр нэг ижил шинж тэмдэг (өвчин) нөхцөлдөн үүсэх үед ихэвчлэн хэрэглэдэг.

Цааш нь „...түүнийг үр хөврөлийн ба их биеийн гаралтай гэж 2 хуваана“ гэж бичсэн байх юм. Хэрэв удамших эмгэгийн тухай ярж байгаа бол үр хөврөлийн эмгэг (эмбриопати) удамшлын биш шалтгаантай байдаг шүү дээ. Гэтэл зохиогч маань „Үр хөврөлийн гаралтай арьсны удамшлын өвчин...“ гэж байн байн яриад байгаа нь арьсны төрөлхийн өвчин удамшлын өвчин хоёрыг хольж хутгаад байгаа нь илт байна.

Арьс өнгөний эмч нарын генетикийн мэдлэг сүл байсан үед төрөлхийн өвчин удамшлын өвчин хоёрыг адилтган ойлгодог байсан ташаарлын тухай „Арьсны удамшлын өвчин“ „Наследственные дерматозы“ (номыг зохиогчид) К. Н.-Суварова, А. А. Антоньев цохон тэмдэглэсэн байна. (Уг номын 50 дугаар тал).

Генетикийн ухаан төдийлөн хөгжөөгүй байсан үед ийм алдааг уучилж болохсон. Харин ямарч мэргэжлийн эмчид генетикийн тодорхой мэдлэг гарцаагүй шаардлагатай болсон өнөө үед ийм энгийн зүйл дээр эмч хүн тэр дундаа эрдэмтэн хүмүүс будилах нь зохисгүй хэрэгзээ.

Эдгээр зүйлийг уншихад тун элбэг тааралдаж байгаа буруу ташаа зүйлс нь хэвлэлийн буку санамсаргүй алдаа биш харин зохиогчдын генетикийн мэдлэгийн түвшинтэй шууд холбоотой гарсан алдаанууд байгаа нь илт байна.

Шинжлэх ухааны ололтыг олон түмэнд сурталчилахыг зорьсон нь сайшаалтай боловч хэн бүхний мэдэх энгийн зүйл дээр алдаж үншигчдад эндүү ташаа ойлголт өгөхөд хүрчээ.

Эцэст жирийн оюутан бил эрдэмтэн ах нартайгаа шөргөөцөлдөх гэсэн муу эчнээ бодол агуулаагүй гэдгээ хэлэхийн далимд хэвлэлийн материалын чанар чансаа, өгөөж, үр нөлөөг сайжруулах, эмч нарын генетикийн мэдлэгийг дээшлүүлэх талаар холбогдох газрууд улам анхаарах хэрэгтэй байгааг дурьдах нь зүйтэй бизээ.

Анагаах ухааны дээд сургуулийн оюутан

Р. Отгонбаяр
Ц. Мягмарцэрэн

ЭМНЭЛГИЙН ХЭВЛЭЛИЙН НЭГДСЭН РЕДАКЦИЙН ЗӨВЛӨЛ

Ж. Чадчаабазар (Эрхлэгч) Л. Буджав, Ш. Ванчаарай (Хариуцлагатай нарийн бичгийн дарга) Б. Гоош, Б. Дэмбэрэл, Г. Дашзэвэг, Ч. Долгор Ш. Жигжид сүрэн, Т. Зориг, Ж. Купул, Э. Лувсандагва, П. Нямдаваа Б. Рагчаа, Г. Цагаанхүү, Б. Шижирбаатар, Н. Шура

Техник редактор Б. Болат Хянаагч Д. Ундармаа

Өрөлтөнд 1987 оны 1 сарын 7-нд орж 3497 ш хэвлэв.
Цаасны хэмжээ 70X108 I/16. Хэвлэлийн хуудас 5,5
х.н.х. 7,7 А—94975. Зах № С—III

Д. Сүхбаатарын нэрэмжит Улсын Хэвлэлийн Комбинатад
Хэвлэв. Д. Сүхбаатарын талбай-6

ШИНЭ ЭМ

ГЛИВЕНОЛ



Фармакологийн үйлдэл: Гливенол үрэвсэл, өвдөлт намдаах төдийгүй анафилаксын эсрэг үйлчилгээтэй. Мөн венийн судасны чангартлыг ихэстэх, венийн цусны зогсонгыг багасгах, цусны бичил эргэлтийг сайжруулах, судасны ханын нэвчимтгий чанарыг бууруулна. Эдгээр үйлдлийн механизм бүрэн тайлбарлагдаагүй. Гэвч эмгэг процесс үүсэхэд оролцдог брадикиниин болон бусад биоидэвхт бодисуудын (гистамин, серотонин) эсрэг нөлөөлдөг болох нь батлагджээ.


Хэрэглэх заалт: Венийн цусны эргэлтийн өөрчлөлт, хөл хавагнах, хөндүүрлэх, флебит, венийн судасны бүдүүрэл, шамбрам, венийн зогсонгоос шалтгаалсан арьсны тэжээлийн өөрчлөлт зэрэгт хэрэглэнэ.

Хэрэглэх арга, тун: Гливенолыг ууж хэрэглэнэ. Холцгийн дундаж тун 0,6—0,8—0,12 (өдөрт 3 удаа ууна). Бүрээстэй нунтгийг хоол идэх үед буюу хоолны дараа зажлахгүй залгина. Ээлж эмчилгээ нэлээд хэдэн доо хоног үргэлжилнэ. Гливенолыг бусад бэлдмэлүүдтэй хавсран хэрэглэж болно.

Хориглох үе, гаж нөлөө: З хүртэлх сартай жирэмсэн эмэгтэйчүүд хэрэглэж болохгүй. Бэлдмэлийг хэрэглэж байхад беөлжис хүрэх, беөлжих, арьсаар туурах, загатнах зэрэг гаж нөлөө ажиглагдаж болох бөгөөд ийм үед эмчилгээг зогсоно.

Эмийн хэлбэр, савлалт: 0,4 г-ийн бүрээстэй нунтаг, 0,2 г-ийн шахмалаар үйлдвэрлэнэ. Гливенолыг ХБНЮУ-д үйлдвэрлэх бөгөөд БНПАУ-д «Польфавенил», ЗХУ-д «Трибенозид» нэртэй үйлдвэрлэнэ.

Улсын эм хангамж үйлдвэрлэлийн газрын мэдээлэл технологийн тасаг.



М. Ариунболд ХОРТ ХАВДРААС СЭРГИЙЛЬЕ

Энэ номд хорт хавдар өвчиний тухай ойлголт, уг өвчинеес хэрхэн сэргийлэх, хамгийн эрт мэдэгддэг шинж тэмдгийн талаар өгүүлнэ. Энэ номыг жирийн үншигчдаас гадна эмч, эмнэлгийн ажилтан, тэрчлэн ухуулагч, суртал нэвтрүүлэгчдэд зориулжээ.

Хамтын бүтээл. ВИРУСТ ГЕПАТИТ

Эл номыг зохиогчид халдварт, ийлдэст гепатитын талаар тус улсад хийсэн судалгаа, шинжилгээний ажил, 1979—1980 онд ажилласан Зөвлөлт-Монголын экспедицийн хийсэн ажлыг нэгтгэн дүгнэж шалтгаан, тархал судлал, эмнэлзүй, онош, сэргийлэлтийн асуудлыг шинжлэх ухааны сүүлийн ололт амжилтанд тулгуурлан орчин үеийн төвшинд үншигчдад толилуулах зорилт тавьжээ.

Хамтын бүтээл. БНМАУ-ЫН ЭРҮҮЛИЙГ ХАМГАЛАХЫН ХӨГЖИЛТ

Энэхүү ном нь 1976, 1977 онд орос, Монгол хэлээр хэвлэгдсэн «БНМАУ-ын Эрүүлийг хамгаалахын 55 жил» номын үргэлжлэл юм. Уг номд тус улсын эрүүлийг хамгаалахын үндсэн албад, нарийн мэргэжлийн тусlamжийн хөгжил, өнөө үеийн гол зорилт, шинжилгээ судалгааны ажлын үр дүн, тэргүүний арга барил, туршлага, практикийн асуудлуудыг тусгажээ.

Номыг нийт эмч, эмнэлгийн ажилтан, оюутан сурагчид, нам улсын удирдах ажилтан, эрүүлийг хамгаалахын зохион байгуулагчид, анагаах ухааны болон БНМАУ-ын шинхэн үеийн түүх судлагч нарт зориулсан байна.

ШИНЭ НОМ